

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2021 оны жилийн эцэс/

2022 оны 03 дугаар сарын 28

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилгын 24 зорилтын 134 арга хэмжээ тусгагдсан бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газраас 2021 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 7 зорилгын 24 зорилтын 134 арга хэмжээний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **95.07** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- ЗОРИЛГО 1. /Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 12,467.5 тэрбум төгрөг байсныг 2021 онд 12,468.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2021 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2021 онд 836.4 мянган тоннд хүргэнэ/-д хамаарах 67 арга хэмжээний хэрэгжилт - 88.66%;
- ЗОРИЛГО 2. /Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2018 онд 75 хувь байгааг 2021 онд 81 хувьд хүргэнэ./-д хамаарах 9 арга хэмжээний хэрэгжилт – 97.78%;
- ЗОРИЛГО 3. /Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай

зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2018 онд 75 хувь байгааг 2021 онд 81 хувьд хүргэнэ./-д хамаарах 26 арга хэмжээний хэрэгжилт – 97.31%;

- ЗОРИЛГО 4. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2020 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна./-д хамаарах 7 арга хэмжээний хэрэгжилт – 98.57%;
- ЗОРИЛГО 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2021 онд 30 хоногт хүргэнэ./-д хамаарах 16 арга хэмжээний хэрэгжилт - 100.0%;
- ЗОРИЛГО 6. Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангаж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2018 оны зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү 3.4 байсныг 2021 онд 1.5 болгон бууруулна./-д хамаарах 2 арга хэмжээний хэрэгжилт - 100.0%;
- ЗОРИЛГО 7. Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж е-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд 5 үйлчилгээг нэгтгэнэ./-д хамаарах 7 арга хэмжээний хэрэгжилт - 91.43%-ийн тус тус биелэлттэй байна.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ
/2021 оны жилийн эцэс/

Зорилго, зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц /хувиар/						Үнэлгээ /%/
		100	90	70	50	30	0	
ЗОРИЛГО 1. Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 12,467.5 тэрбум төгрөг байсныг 2021 онд 12,468.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2021 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2021 онд 836.4 мянган тоннд хүргэнэ.								
Зорилт 1 - ЗГҮАХ-3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.	18	7	7	0	3	1		83.89

Зорилт 2 - ЗГҮАХ-3.2.2. Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	2	2						100
Зорилт 3 - ЗГҮАХ-3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	15	12	3	0				98
Зорилт 4 - ЗГҮАХ-3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	3	3						100
Зорилт 5 - ЗГҮАХ-3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.	3	3						100
Зорилт 6 - ЗГҮАХ-3.2.16. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.	4	4	0	0				100

Зорилт 7 - ЗГҮАХ-3.2.1. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	8	1	5	2				86.25
Зорилт 8 - ЗГҮАХ-3.2.1.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	14	11	2	0	1		0	95
Дүн	67	43	4	15	4	1	0	88.66
<p>ЗОРИЛГО 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2018 онд 75 хувь байгааг 2021 онд 81 хувьд хүргэнэ.</p>								
Зорилт 1 - Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна.	9	7	2	0				97.78
Дүн	9	7	2	0	0	0	0	97.78
<p>ЗОРИЛГО 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2018 онд 75 хувь байгааг 2021 онд 81 хувьд хүргэнэ.</p>								
Зорилт 1 - Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	6	6						100

Зорилт 2 - Геологийн салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	7	5		2				91.43
Зорилт 3 - Уул уурхайн салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	3	3						100
Зорилт 4 - Газрын тосны салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	4	3	1	0				97.50
Зорилт 5 - Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	2	2						100
Зорилт 6 - Геологи, уул уурхай хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.	4	4						100
Дүн	26	23	1	2	0	0	0	97.31
<p>ЗОРИЛГО 4. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2020 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.</p>								

Зорилт 1 - Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна.	7	6	1	0				98.57
Дүн	7	6	1	0	0	0	0	98.57
<p>ЗОРИЛГО 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2021 онд 30 хоногт хүргэнэ.</p>								
Зорилт 1 - Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	6	6						100
Зорилт 2 - Салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.	3	3						100
Зорилт 3 - УУХҮСайдын багцын төсвийн гүйцэтгэл 2020 онд 95,7 хувь байсныг 2021 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.	4	4						100
Зорилт 4 - Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	3	3						100
Дүн	16	16	0	0	0	0	0	100

ЗОРИЛГО 6. Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангаж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2018 оны зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү 3.4 байсныг 2021 онд 1.5 болгон бууруулна.

Зорилт 1 - Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийнэ.	1	1						100
Зорилт 2 - Санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана.	1	1						100
Дүн	2	2	0	0	0	0	0	100

ЗОРИЛГО 7. Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж e-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд 5 үйлчилгээг нэгтгэнэ.

Зорилт 1 - “Эрдэс баялгийн цахим засаглал” үндэсний арга хэмжээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд батлаж хэрэгжилтийг ханган ажиллана.	2	1		1				85
Зорилт 2 - УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	5	4		1				94
Дүн	7	5	0	2	0	0	0	91.43
<u>Нийт дүн</u>	<u>134</u>	<u>102</u>	<u>21</u>	<u>6</u>	<u>4</u>	<u>1</u>	<u>0</u>	95.07

Дөрөв. Дүгнэлт.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 7 зорилгын 24 зорилтын 134 арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтийг **95.07** хувийн биелэлттэй гэж дүгнэв.
2. Нийт 134 арга хэмжээний биелэлтийг дүгнэсэн 102 арга хэмжээ 100 хувийн хэрэгжилттэй, 21 арга хэмжээ нь 90 хувийн хэрэгжилттэй, 6 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, 4 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй байна. Тасарсан арга хэмжээ байхгүй байна.

Тав. Зөвлөмж.

1. Биелэлт нь 50, 30 хувиар дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа дараах арга хэмжээг эрчимжүүлэх. Үүнд:
 - 1.2. *“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. /50%/*
 - 1.2.1 *Мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ. /50%/*
 - 1.2.4 *Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө. /50%/*
 - 8.2.2 *Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна. /50%/*
 - 1.2.2 *Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ. /30%/*
2. Зарим арга хэмжээг төлөвлөхдөө тухай онд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодорхойлж, нарийвчлан төлөвлөх
3. Арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй болон дутуу биелэлт бичих, утга найруулга, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд гарч байгаад анхаарах

Жич: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээг хавсаргав.

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

Ц.Одхүү

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Батнайрамдал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

№	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УУХҮЯамны Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая.төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилго 1. Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 12,467.5 тэрбум төгрөг байсныг 2021 онд 12,468.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2021 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2021 онд 836.4 мянган тоннд хүргэнэ.							
1.	ЗГҮАХ-3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.						
1.1.	Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	1,232,006.2 /Гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зээлээр/	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн эсэх, 0-Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөөгүй, 1-Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн	Далд уурхайн бүтээн байгуулалт 26 хувь.	Далд уурхайн бүтээн байгуулалт 54 хувь.	“Оюу толгойн ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол улсын Их хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын 2019 оны 174 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 23 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг ажиллаж байна. (Дээрх ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар, ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021.02.24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан) Мөн тус яамнаас Ашигт малтмалын тухай хуулийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу “Оюутолгойн далд уурхайн хүдэр тээвэрлэх шугам /үе шат1/-ыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах” тухай техникийн ажлын хэсгийг 2021.02.05-ны өдөр зохион байгуулж, Оюутолгойн далд уурхайг Улсын комисс ашиглалтад бүрэн хүлээж авах хүртэл үйлдвэрлэлийн зориулалтаар түр ашиглах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>2021 оны эцсийн байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-89%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-85%, далд уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл-49,943 экв.м, туузан дамжуургын малталт-13,851 экв.м, далд уурхайн бүтээн байгуулалт 78 хувьд хүрсэн байна.</p> <p>Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.09.14-ний өдрийн 01/2234, 2021.10.07-ны өдрийн 01/2423 дугаар албан бичгээр тухай бүрт уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн.</p> <p>УУХҮСайдын 2021.11.24-ний өдрийн А/284 дүгээр тушаалаар Оюу Толгой төслийн анхдагч мэдээлэл, боловсруулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийж, талуудын мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчдийн хэсэгт техникийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан Рио тинто ХХК, Оюутолгой ХХК-ийн төлөөлөлтэй Ажлын хэсгийн гишүүд 2021.11.25-ны өдөр уулзалт зохион байгуулсан.</p>	
1.2.	<p>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>322,939.3 /Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилт ээр 22.4%-ийг, зээлээр 77.6%-ийг/</p>	<p>Зохион байгуулсан эсэх 0-Зохион байгуулаагүй, 1-зохион байгуулсан</p>	<p>Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 52 хувьд, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 17 хувьд, засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 15 хувьд, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө</p>	<p>Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100 хувьд, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 34 хувьд, засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 39 хувьд хүргэнэ</p>	<p>ХБНГУ-ын “ЗВ TEC AUFBEREITUNGSSYSTEME” GmbH компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж байна. Метал хийц үйлдвэрлэлийн ажлын явц Бутлуурын байгууламж 100%, Туузан дамжуургын систем 100% дууссан Нийт металл хийцийн тээвэрлэлтийн ажлын явц 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц Бутлуурын байгууламж 95%, Туузан дамжуургын систем 90%. Овоолгын хэсгийн металл хийц болон механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц 48%-тай байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 24%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.11.09-ны өдрийн 01/2725, 2021.12.06-ны өдрийн 03/3022 албан тоотой тухай бүр уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн.</p>	50%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

				оруулалт 100%-тай.			
1.2.1.	Мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.	55,483.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилт аар 7.7%-ийг, зээлээр 92.3%-ийг/	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлсэн, эсэх 0-дэмжлэг үзүүлээгүй, 1-дэмжлэг үзүүлсэн	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 52%тай.	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100% хүрнэ.	ТЭЗҮ 100%-ийн гүйцэтгэлтэй. Инженерийн зураг төслийн ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Конвейерийн системийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 50%. Материал тээвэрлэлт 10%-д хүрсэн. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 35%-д хүрсэн.	50%
1.2.2.	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.	-	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулах ажилд дэмжлэг үзүүлсэн эсэх 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1-Дэмжлэг үзүүлсэн	0	1	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100 хувь, бүтээн байгуулалтын ажлын явц 35 хувьтай гүйцэтгэгдэж байгаа бөгөөд 2021.10.01-ний өдөр бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	30%
1.2.3	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	239,003.5 /Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилт ээр 16.6%-ийг, зээлээр 83.4%-ийг/	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн эсэх 0-Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөөгүй, 1-Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 17 хувьтай	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 34 хувьд хүрнэ.	Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.10.04-ний өдрийн 01/2374 тоотуор уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн 4-р шугам барьж, байгуулах ажилд БНХАУ-аас нийт 151 инженер, техникийн ажилтан урьж ажиллуулах хүсэлт ирүүлснийг тухай бүр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тодорхойлж өгсөн.	100%
1.2.4.	Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	28,452.8 /Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилт ээр 100%-ийг/	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн эсэх 0-Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөөгүй 1-Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн	Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 15%-тай.	Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 39%-д хүрнэ.	Хүйтнээр хатуурах холимгоор хэв бэлтгэх хагас автомат шугамын гүйцэтгэл 100%, засвар, механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон инженерийн зураг төслийг боловсруулах ажил 30 орчим хувьтай, Шинэ Засвар механикийн завод–II төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн техникийн даалгавар боловсруулах ажил хийгдэж байна. Засвар, механикийн заводын Цутгуурын цехийн элчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл шинэчлэлийн ажил 10%. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 20%-д	50%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						хүрсэн. Ажлын явц гэрээнд заасан график төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.	
1.3.	Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулах ажилд дэмжлэг үзүүлнэ.	1,166,564.8 /Өөрийн хөрөнгө, гадаадын хөнгөлөлттэй зээл/	Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулах ажилд дэмжлэг үзүүлсэн, эсэх 0-Дэмжлэг үзүүлээгүй 1-Дэмжлэг үзүүлсэн	Бүтээн байгуулалтын ажил 47%-тай.	Бүтээн байгуулалтын ажил 69 хувьтай. Уулын баяжуулах үйлдвэрийн барилгын угсралтын ажлыг хийх, тоног төхөөрөмжийн тээвэрлэх, төслийн санхүүжилтийн гэрээ хэлэлцээрийг хийнэ.	Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69 хувьд хүрсэн. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Тус төслийн уулын баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад ашиглагдах тоног төхөөрөмж, материал нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж БНХАУ-ын Эрээн боомтын хил, гаалиар нэвтрэхэд доторхой хүндрэлүүд үүссэн бөгөөд тус яамнаас Хилийн Замын-Үүд боомтын зөвлөлд хандаж бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бараа материалыг хил, гаалиар саадгүй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан. Тус төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд Засгийн газрын тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад 2021.11.22-ны өдөр танилцуулсан.	100%
1.4.	Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулах ажилд дэмжлэг үзүүлнэ.	40,402.1 /Гадаадын хөнгөлөлттэй зээл тусламжаар (JBIC) 100%-ийг	Олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулах ажилд дэмжлэг үзүүлсэн эсэх, 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1- Дэмжлэг үзүүлсэн	"Багануур" ХК-ийн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 51 %, "Шивээ овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36%-д хүргэнэ.	"Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 100%, "Шивээ овоо" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 52%-д хүргэнэ.	"Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-иудын тоног төхөөрөмжийг шинэчлэх хүрээнд Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлийг ашиглах дамжуулан зээлдүүлэх гэрээний төслийг батлуулахаар тус яаманд "Эрдэнэс Монгол" ХХК-иас 2021.03.05-ний өдрийн 01/122 дүгээр албан бичгээр ирүүлсэн бөгөөд хариуг 2021.03.15-ны өдрийн 01/593 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Улмаар Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлийг ашиглах дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээг 2021.03.05-ны өдөр байгуулсан байна. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, УУХҮСайд нарын 2021.02.26-ны өдрийн 16,А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019, 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн аудит хийх Ажлын хэсэгт ажиллаж, холбогдох дүгнэлтийн боловсруулсан. Ажлын хэсгийн тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар хүлээгдэж байгаа бөгөөд тайланд "Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний ордуудын олборлолтын өөрийн өртгийг бууруулж, компанийн өр төлбөрийг бууруулах, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хийж, хүчин чадлыг	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>нэмэгдүүлэх, арга хэмжээний саналыг боловсруулж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Эрдэнэс Монгол ХХК /Д.Хаянхярваа/ нарт” даалгах саналыг тусгуулсан.</p> <p>Өнөөгийн байдлаар “Багануур” ХК Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлээр нийт 12 техник, тоног төхөөрөмжийг шинэчлээд байна. Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%-д хүрсэн.</p>	
1.4.1.	<p>“Багануур” ХК-ын ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлд шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>33,608.0 /Гадаадын хөнгөлөлттэй зээл тусламжаар (JBIC) 100%-ийг</p>	<p>Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх 0-Дэмжлэг үзүүлээгүй 1-Дэмжлэг үзүүлсэн</p>	<p>Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 51 хувь, ил уурхайн хүчин чадал 4 сая.тн.</p>	<p>“Багануур” ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 100%-д хүрнэ.</p>	<p>Засгийн газрын 2018 оны 132-р тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд эрчим хүчний нүүрс олборлогч “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн зардал бууруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, уурхайн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангуулахад техникийн шинэчлэл хийх түүнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Эрдэнэс Монгол ХХК, Японы олон улсын хамтын ажиллагааны банкны экспортын зээлийн шугамаар шийдвэрлэсэн. “Багануур” ХК-н экскаватор 6,7 м³ 1 ш, хөрс тээврийн 100 тн-ийн даацтай автосамосвал 6 ш, нүүрс тээврийн 60 тн-ийн даацтай автосамосвал 3 ш, бульдозер 2 ш. Нийт зээлийн хэмжээ 29.78 тэрбум төгрөг. “Багануур” ХК-иас тус тоног төхөөрөмжүүдийн урьдчилгаа төлбөрт 4.5 тэрбум төгрөг, Сангийн яамнаас 907.0 сая иен төлж 2020 оны 12 сард 9 тоног төхөөрөмжийг, 2021 оны 4, 5 сард 3 тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авсан.</p> <p>2021 онд 33.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж хүчин чадлыг 5.7 сая тонн-д хүргэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан боловч Багануурын Цахилгаан станцын ашиглалтад орох хугацаа болоод Ковидын нөхцөл байдалтай холбоотойгоор хөрөнгө оруулалт хойшлогдоод байна.</p> <p>Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%-д хүрсэн.</p>	90%
1.4.2.	<p>Шивээ-овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>6,794.1 /Гадаадын хөнгөлөлттэй зээл тусламжаар (JBIC) 100%-ийг</p>	<p>Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх 0-Дэмжлэг үзүүлээгүй 1-Дэмжлэг үзүүлсэн</p>	<p>“Шивээ овоо” ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36%-д хүргэнэ.</p>	<p>“Шивээ овоо” ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 52%-д хүргэнэ.</p>	<p>Дээрх JBIC төслийн хүрээнд 2 комацу PC1250 гидро экскаватор, 5 комацу HD465 технологийн автомашин нийлүүлэгдэж нийт 14.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2020-2022 оны төлөвлөгөөт хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг биелүүлэх, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж өвөлжилтийг давахад бодитой хувь нэмэр оруулж байна. Дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 3.0 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд үлдэгдэл 11.9 тэрбум төгрөгийг компанийн борлуулалтын орлогоос 4 жилийн хугацаанд төлж барагдуулна. Уг JBIC төсөл бол Шивээ</p>	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						Овоогийн уурхайн хүчин чадлыг 2.0 сая тонны хэмжээнд нь барих техникийн шинэчлэл юм. Нүүрс борлуулалтын зах зээл тодорхой бус болж буурах магадлал байгаатай холбогдуулан нэмэлтээр хөрөнгө оруулалт хийгдээгүй бөгөөд өнөөдрийн байдлаар техник ашиглалт 90%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд өвлийн оргил ачааллын үед акталсан техник ашиглах, гаднын байгууллагаас техник түрээсэлж ажиллуулах замаар шийдвэрлэж байна. Ирэх жилүүдэд нүүрс борлуулалтын зах зээл нэмэгдэх үед хөрөнгө оруулалт техникийн шинэчлэлд зориулж 5.0 тэрбум орчим төгрөгийн санхүүжилт зайлшгүй шаардагдана. Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын дагуу 9 чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний биелэлт 1.5 тэрбум төгрөгийн хэмнэлт гарахаар байна. 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр Шивээ Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн барих 200 мВт-ын ДЦС-ын урьдчилсан ТЭЗҮ-г батлуулсан.	
1.5.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, ажлыг зохион байгуулна.	1,484.5 /Төрийн өмчит компанийн санхүүжилт ээр 100%-ийг/	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, ажлыг зохион байгуулсан эсэх 0-Зохион байгуулаагүй 1-Зохион байгуулсан	Шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 0 хувь.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 10%.	Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2 “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв”-ийн жагсаалтад 500,000,000 /таван зуун/ сая төгрөгийн төсөвт өртөгийг тусгуулж “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд ордын штольня-1, штольня-2 болон штольня-5 хэвтээ амнуудаас хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох” нарийвчилсан зураг төслийг хийх ажлын даалгаврыг УУХҮЯ-ны ТНБДаргаар батлуулж, 2021.04.09-ний өдрийн 03/949 дугаар албан бичгээр БХБЯ-ны ТНБДарга С.Магнайсүрэнд хүргүүлсэн. Тус зураг төслийг гүйцэтгэх тендерт шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжээс 2021.09.01-ний өдөр төслийн эхлэлийн тайланг боловсруулан ирүүлээд байна. Мөн тус зураг төслийн ажлыг гүйцэтгэгч компаниас 2021.11.16-ны өдрийн 486 дугаар албан бичгээр Авто замын маршрутын судалгааг ирүүлсэн бөгөөд тус асуудлыг судлан үзэж холбогдох саналыг “Эрдэнэс Монгол” ХХК-иас авч Авто замын маршрутыг тогтоод байна.	90%
1.5.1	Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалтыг татах ажилд дэмжлэг үзүүлнэ.	714.5 /Төрийн өмчит компанийн санхүүжилт	Судалгааны хөрөнгө оруулалтыг татах ажилд дэмжлэг үзүүлсэн эсэх 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1-	Лабораторын туршилт хийлгэх ажил 50%.	Лабораторын туршилт хийлгэх ажил 100%.	Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15(Мон)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Энэ хугацаанд Асгатын ордоос авчруулсан дээж нь тус ордыг төлөөлөхүйц байж чадахгүй гэж үзэн тус ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах мэдэгдлийг	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

		ээр 100%-ийг/	Дэмжлэг үзүүлсэн			SGSIMME MONGOLIA ХХК-д 2021.01.21-ний өдөр цахим шуудангаар өгсөн. Тайлбар: (Асгатын мөнгөний ордын ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тус уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх тендерт “Асгат Кент” ХХК шалгаран 2019.11.06-2019.12.25-ны хооронд дээж бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын даалгаварт тусгасан ажил үүргийн хуваарь, ажлын гүйцэтгэлийн тайлан зэрэгтэй танилцахад Штольня 1-5 амнуудыг нээж чадаагүйн улмаас ордыг төлөөлөхүйц дээж авч чадаагүй, ажлын даалгаврын дагуу ажлууд бүрэн хийгдээгүй байна. Эндээс харахад Штольня 1-5 амнуудыг нээх, түүнд нэвтрэн дотор нь ажиллах орчин бүрдүүлэх, хүдрийн дээж бэлтгэх зам талбайг засах нээх зэрэг ажлуудад шаардлагатай ТӨСӨВ ТООЦОО-г судалгаагүй хийсэн. Мөн уулын геологи техникийн нөхцөл нэн хүндрэлтэйн дээр цаг уурын нөхцөл байдлыг тооцоолоогүй зэрэг шалтгаанаас үүдэн ордыг бүрэн төлөөлөхүйц дээж бэлтгэхэд ихээхэн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байна. Орд ашиглах бэлтгэл ажлын хүрээнд далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийх, уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд хүргүүлэн улмаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн гуравдугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгуулсан.	
1.5.2	Асгатын мөнгөний ордын зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг татах ажилд дэмжлэг үзүүлнэ.	770.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилт эер 100%-ийг/	Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг татах ажилд дэмжлэг үзүүлсэн эсэх 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1-Дэмжлэг үзүүлсэн	Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт 55%.	Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт 61%.	Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2-д багтсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв”-ийн жагсаалтад багтсан 500000000 /таван зуун/ сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд ордын штольня-1, штольня-2 болон штольня-5 хэвтээ амнуудаас хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох” нарийвчилсан зураг төслийг хийх ажлын даалгаврыг УУХҮЯ-ны ТНБДаргаар батлуулж, 2021.04.09-ний өдрийн 03/949 дугаар албан бичгээр БХБЯ-ны ТНБДарга С.Магнайсүрэнд хүргүүлсэн. БХБЯ-ны сайдын 2021.06.02-ны 1/2087 тоот албан бичгээр дээрх ажил дэлгэрэнгүй жагсаалт үүсгэх мэдүүлэг авах шатанд байна гэсэн хариу ирүүлсэн.	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг 60%-д хүрсэн. Ордын хэмжээнд 5000 га талбайд М 1:2000 гадаргын бүрэн зураглал хийх, тусгай зөвшөөрлийн хил хязгаар тогтоох шав тэмдэг тавих тендерийн баримт бичиг, техникийн даалгаврыг боловсруулж гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна.</p> <p>Асгатын нөөцийн тодотголын тайланг хийхээр тендер 2020 онд зарласан. Сонгон шалгаруулалтаар Стийл-Айрон ХХК шалгарсан бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг 2021.06.01-ний өдөр хүртэл сунгасан. Гэрээний хугацааны дагуу боловсруулсан тайланг хүлээж авсан бөгөөд тайланд шинжээч томилуулахаар ажиллаж байна.</p> <p>“Эрдэнэс Монгол” ХХК нь Баян-Өлгий аймгийн Ногооннуур суман дахь өөрийн эзэмшлийн “Асгат”-ын мөнгө, полиметаллын ордын эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай геологи хайгуулын ажил хийх, дэд бүтэц, уулын баяжуулах, боловсруулах, цэвэршүүлэх үйлдвэрийн инженерчлэл, барилгын ажлыг төлөвлөх, ашиглалтад оруулах, бүтээгдэхүүн гаргах, худалдах замаар үр ашигтайгаар ашиглах зорилгоор АНУ-ын “Commonwealth American Partners” хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлтэй “Хамтын ажиллагаа, түншлэлийн санамж бичиг”-ийг 2021.08.30-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан.</p> <p>Санамж бичигт тусгагдсан үе шаттай ажлуудыг цаашид шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэх зорилгоор тус хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн төлөөллийг Монгол Улсад урьсан бөгөөд энэхүү уулзалтын үеэр хөрөнгө оруулалтын асуудал болон тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагч талтай хамтран эзэмших асуудлаар санал солилцсоны үндсэн дээр холбогдох тооцоо судалгааг хийж Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.</p>	
1.6.	Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулна.	426,507.5 /Төрийн өмчит компанийн санхүүжилт ээр 42%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах	Нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулсан эсэх 0-Зохион байгуулаагүй, 1-Зохион байгуулсан	Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс	Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах	УУХҮСайдын 2020 оны А-292 дугаар тушаалаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод үйл ажиллагаа эрхэлж байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн хэсэг нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд холбогдох дүгнэлтийг 2021.01.22-ны өдөр төсөл боловсруулагчид өгсөн бөгөөд ЭБМЗ-ийн 2021.04.01-ний өдрийн өргөтгөсөн хурлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцэн хүлээн авсан.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

		гэрээгээр 58%-ийг/		баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил 0 хувь.	үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил 32 хувь.	Тавантолгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 335.6 сая. ам долларын өртөг бүхий жилд 10 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай эхний үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2021.08.13-ны өдөр зарласан бөгөөд 2021.09.27-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч шалгарсан хуулийн этгээд нь зураг төсөл боловсруулагч Чайна Металлуржикал Инженеринг ХХК-тэй хамаарал бүхий байх тул 2021.11.15-нд тендерийг ахин зарласан байна. Тендерийн материал хүлээн авах хугацаа 2021.12.15-нд дуусах бөгөөд материал хүлээн авсны дараа 28 хоногийн дотор үнэлгээ болон гэрээ байгуулах ажлыг хийхээр хүлээгдэж байна.	
1.6.1	Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.	61,742.6 /Төрийн өмчит компанийн санхүүжилт ээр 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/	Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажилд дэмжлэг үзүүлсэн эсэх 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1-Дэмжлэг үзүүлсэн	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэлт 0 хувь.	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 5%.	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолын дагуу тус яам нь тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийн хэрэгжүүлэгчийн үүргийг гүйцэтгэж байна. Энэ хүрээнд тус яамнаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд удирдаж хүргүүлэн ажиллаж (2021.05.24-ний өдрийн 01/1345) байна. Улмаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020.12.31-ний өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан тус компанийн хөрөнгө оруулалтын 2021 оны төсөвт техник, тоног төхөөрөмжийн худалдан авахад шаардагдах хөрөнгө оруулалтыг тусгасан. Мөн тус яамнаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-д Тавантолгойн ордын Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогчоор ажиллаж байсан “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Сингапур улсын Five Hills Holdings PTE LTD компаниас өөрийн компанийн хувьцааг худалдах саналыг ирүүлсэнтэй танилцаж, саналыг олон улсын болон манай улсын хууль, тогтоомжийн хүрээнд судлан үзэхийн зэрэгцээ “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн эзэмшиж байгаа тоног, төхөөрөмж барилга байгууламж болон бусад хөрөнгийн үнэлгээг тодорхойлж ирүүлэх чиглэлийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлагад өгөх албан бичгийг боловсруулан 2021.06.10-ны өдөр хүргүүлсэн.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						“Эрдэнэс Тавантолгой” ХК 2021 онд 12ш автосамосвал, 1ш дугуйт ачигч, 1ш бульдозер, 2ш экскаватор шинээр худалдан авсан байна.	
1.6.2	Нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.	263,472.9 /Төрийн өмчит компанийн санхүүжилт аар 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/	Нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлсэн эсэх, 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1-Дэмжлэг үзүүлсэн	Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулын /10 сая.тн/ бүтээн байгуулалтын ажил 0 хувь.	Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулын бүтээн байгуулалтын ажил 34%.	УУХҮСайдын 2020 оны А-292 дугаар тушаалаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод үйл ажиллагаа эрхэлж байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн баг холбогдох дүгнэлтийг 2021.01.22-ны өдөр төсөл боловсруулагчид өгсөн бөгөөд ЭБМЗ-ийн 2021.04.01-ний өдрийн өргөтгөсөн хурлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцэн хүлээн авсан. Тавантолгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 335.6 сая. ам долларын өртөг бүхий жилд 10 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай эхний үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2021.08.13-ны өдөр зарласан бөгөөд 9 дүгээр сарын 27-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч шалгарсан хуулийн этгээд нь зураг төсөл боловсруулагч Чайна Металлуржикал Инженеринг ХХК-тэй хамаарал бүхий байх тул 2021.11.15-нд тендерийг ахин зарласан байна. Тендерийн материал хүлээн авах хугацаа 2021.12.15-нд дуусах бөгөөд материал хүлээн авсны дараа 28 хоногийн дотор үнэлгээ болон гэрээ байгуулах ажлыг хийхээр хүлээгдэж байна.	100%
1.6.3	Ачилтын нэгдсэн төв байгуулах ажилд дэмжлэг үзүүлж, Тавантолгойн ордын гадаргын төлөвлөлтийн зургийг батлуулна.	28,452.8 /Төрийн өмчит компанийн санхүүжилт ээр 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/	Тавантолгойн ордын гадаргын төлөвлөлтийн зургийг батлуулсан эсэх 0-Батлуулаагүй, 1-Батлуулсан	Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 0 хувь.	Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 40%-д хүрэх.	Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв /салбар төмөр зам, ачих байгууламж/-барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулж, барих тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.07-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлуулсан. Улмаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн 2021.11.24-ний өдрийн 16 дугаар хуралдаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцээд хүлээн авсан болно.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

1.6.4	Усан хангамж шийдвэрлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.	72,839.2 /Төрийн өмчит компанийн санхүүжилт эр 100%-ийг/	Усан хангамж шийдвэрлэх ажилд дэмжлэг үзүүлсэн эсэх 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1-Дэмжлэг үзүүлсэн	Усан хангамжийн ажил 0%.	Усан хангамжийн ажил 20%.	Тавантолгойн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн бүтээн байгуулалт /нүүрс угаах үйлдвэр, кокс-эрчим хүчний үйлдвэр/-д шаардлагатай 220 л/с усыг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос хангах саналыг Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолын төсөл, танилцуулгад тусган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн.	90%
2. ЗГҮАХ-3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.							
2.1.	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах ажлыг зохион байгуулна.	46,200.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилт эр 100%-ийг/	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэх ажлыг зохион байгуулсан эсэх 0-Зохион байгуулаагүй 1-Зохион байгуулсан	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадал 50%.	Салхитын мөнгөний ордын баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажил 20 хувь, нэмэлт хайгуулын ажил 100%.	<p>“Эрдэнэс Монгол” ХХК нь үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-ийн хүрээнд зарцуулалт хийж, арилжааны банкнуудтай гэрээ хийж 228,493.0 иргэн 6 сая төгрөг, түүнээс доош дүнтэй зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөж (үүний 43,892.0 иргэн 1 сая төгрөг хүртэлх зээлтэй), 2021.05.21-ний өдөр 194,807 иргэнд 1 сая төгрөгийн өдөр мөнгөжүүлсэн үнэт цаас эзэмшүүлэх замаар байгалийн баялгийн өгөөжөөс хүртээсэн. (Нийт 423,300 тэтгэвэр авагч иргэн).</p> <p>Жилд 600 мянган тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэр-II төслийг хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 90%, угсралт суурилуулалт 80%, барилгын материалын татан авалт 90%, барилга угсралтын ажил 80%, дэд бүтцийн ажил 80% гүйцэтгэлтэй байна.</p> <p>Ковид цар тахлын нөлөөлөл, хөл хорио, Монгол Улсын хил, гаалийн хориг зэргээс үүдэлтэй шинэ баяжуулах үйлдвэрийн барилгын явц график төлөвлөгөөнөөс хоцорч, үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилгын материалууд 2 сар гаруй хугацаатай Хятад, Монголын хил гааль дээр саатаж байгаа зэрэг нь шинэ үйлдвэрийг төлөвлөгөөт хугацаанаас хоцрогдолтойгоор ашиглалтад оруулах нөхцөл байдал үүссэн. Дээрх хил, гаалийн хоригоос үүдэлтэй хүндрэлийг шийдвэрлэх хүрээнд тус яам нь Хилийн Замын-Үүд боомтын зөвлөлд хандаж бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бараа материалыг хил, гаалиар саадгүй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан. Салхитын мөнгөний ордын нөөцийг нэмэгдүүлж, ордын насжилт өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны хайгуулын ажлын хүрээнд хийгдсэн геологи хайгуулын нарийвчилсан ажлын үр дүнд ордын нөөцийг бодитой ба боломжтой /B+C/ зэрэглэлээр 3,169,815.5 тонн хүдрийн</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>нөөцийг ЭБМЗ-өөр 2021.04.15-ны өдөр хэлэлцүүлж Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.</p> <p>Мөн Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус төслийн ажлын гүйцэтгэл, биелэлтийг сар, улирал тутамд авч, хагас жил тутам тайланг нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт уламжилж байна.</p> <p>Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” MERIT төслийн дэмжлэгтэйгээр “Эрдэнэс силвэр ресурс” ХХК хариуцан хэрэгжүүлэх Салхитын мөнгөний ордын Хаалтын менежментийн төлөвлөгөөг загвар байдлаар боловсруулах төслийг хамтран хэрэгжүүлж байна.</p>	
2.2.	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.	2021 онд хөрөнгө төсөвлөөгүй.	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлсэн эсэх 0-Дэмжлэг үзүүлээгүй, 1-Дэмжлэг үзүүлсэн	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах ажил 0 хувь.	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 10%.	<p>Зүүн Цагаан Дэлийн орд газрыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг (тодотгол) боловсруулж ЭБМЗ-ийн 2021.04.13-ны өдрийн хурлаар шийдвэрлүүлсэн.</p> <p>Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ, БОННУ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг батлуулах ажилд дэмжлэг үзүүлж ажилласан.</p> <p>Мөн төсөл хэрэгжүүлэгч нь цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5км түр агаарын шугамыг барьж, уурхайн налуу ам 80м нэвтэрсэн ба 2021 оны эцэст нэвтрэлтийн хэмжээ 120м-130м-т хүрнэ. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан.</p>	100%
3.	ЗГҮАХ-3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.						
3.1.	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулна.	Улсын төсөв 11,602.4	Монгол орны нутаг дэвсгэрийн 43 хувийг 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулсан байна.	41.06%	Нутаг дэвсгэрийн 43%-ийг хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй 15 талбай ялгана.	<p>Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалан 2020 оны 11-р сараас эхэлсэн бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн онцгой нөхцлөөс хамаарч төслүүдийн үр дүнгийн тайлан боловсруулах ажил удааширсан тул Сүүжийн говь-50, Цайлангийн нуруу-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Олон гол-50, Их Өлзийт-50 төслүүдийн хугацааг УУХҮС-ын 2021.02.04-ний өдрийн А/20 дугаар тушаалаар 3-6 сарын хугацаатай сунгасан. 2016-2020 онд хэрэгжсэн Цахир мушгиа уул-50 (ЭБМЗ-ийн 2021.06.24-ний УТХ-07-01 дүгээр дүгнэлт, УУХҮС-ын 2021.08.11-ний А/218 дугаар тушаал), Олон гол-50, Номгоны нуруу-50, Худгийн нуруу-50 төслийн үр дүнгийн тайлантай танилцаж геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэх ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн</p>	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

					авсан. Ингэснээр 14,278.29 км ² талбай буюу 0.91%, нийтдээ 41.97%-ийг тус судалгааны ажилд хамруулаад байна.	
				23 төслийн судалгааны ажлыг эхлүүлсэн байна. 4 төслийн геологийн даалгаврыг батлуулсан байна.	Төлөвлөгөөт онд үргэлжлэн хэрэгжих 23 төслийн хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Үүнд: 1.1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн үргэлжлэн хэрэгжих 23 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан. 2. Үргэлжлэн хэрэгжих 23 төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.24, 2021.03.25, 2021.03.26, 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021 оны тушаалаар баталгаажуулсан. 3. Улсын тусгай хэрэгцээний газарт судалгаа хийх Дөч гол-50, Өндөр ширээт-50, Борзонгийн говь-50, Зангат-50, Гилбэнт уул-50, Хайрхан овоо-50, Овоот толгой-50, Хар хайрхан-50, Их элээт уул-50, Их бэрх уул-50, Улаангом-50, Уушгийн улаан-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Торлог уул-50 төслүүдийн гүйцэтгэгч нарт дэмжлэг үзүүлэх тухай УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, хилийн бүсэд хэрэгжүүлэх Дөч гол-50, Борзонгийн говь-50, Зангат-50, Гилбэнт уул-50, Торлог уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Их бэрх уул-50, Овоот толгой-50, Хар хайрхан-50 төслүүдийн гүйцэтгэгч нарт дэмжлэг үзүүлэх тухай ТНБДаргын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т тус тус хүргүүлсэн. 4. 2021 онд хэрэгжих 23 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг боловсруулан ТНБДаргын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан. 2021 онд хээрийн судалгааны ажилтай Хулд-50, Алагбаян-50, Халзан-Овоо-50 төслүүдэд 2021.09.16-2021.09.24-ний өдрүүдэд шуурхай хяналтыг гүйцэтгэн зөвлөмж өгч ажилласан. Мөн Индэртийн нуруу-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Алагбаян-50, Бүрхтэй уул-50, Хулд-50, Асгат уул-50, Их элээт уул-50, Зангат-50, Бөөн хөх уул-50, Уушгийн улаан-50, Халзан овоо-50 төслүүдийн хээрийн судалгааны анхдагч материалыг 2021.11.08-2021.11.30-ны өдрүүдэд хүлээн авсан.	100%
				4 төслийн геологийн даалгаврыг	Шинээр хэрэгжүүлэх Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Ямаат уул-50, Загал уул-50, нийт 4 төслийн геологийн	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

					батлуулсан байна.	даалгаврыг боловсруулан 2021.03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан. Үүнд: 4 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдүүдтэй Захиалагчаас өгсөн үүргийн дагуу 2021.06.11-ны өдрийн 14, 15, 16, 2021.07.22-ны өдрийн 25 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2021 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021 оны 11-р сард хүлээн авсан.	
3.2.	1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулна.	-	1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг гүйцэтгэх заавар, түүнд тавих шаардлагыг боловсруулсан байна. 0-үгүй 1-тийм	0	1	1:25000-ны масштабын геологийн зураглалын ажил гүйцэтгэх заавар, түүнд тавигдах шаардлагыг боловсруулахад зарцуулах төсвийг аргачлал, хяналтын зардлаас гаргахаар УУХҮЯ-ны ТНБД-ын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан. Заавар боловсруулах хуулийн этгээд буюу ажлын хэсгийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах асуудлыг Үндэсний геологийн албанд шилжүүлсэн.	100%
3.3.	Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна.	Улсын төсөв 1,729.9	Монгол орны нутаг дэвсгэрийг Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажилд 40% хамруулсан байна.	К хавтгайн 14.1% буюу нутаг дэвсгэрийн 34.1%-ийг хамруулсан байна.	Нутаг дэвсгэрийн 40%-ийг хамруулна.	Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1%-ийг хамарсан К хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайлантай танилцан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. ЭБМЗ-ийн хуралдаанаар төслийн үр дүнг хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 14.1%-ийг 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийн нэгтгэлд хамруулсан.	100%
				2 төслийн судалгааны ажлыг эхлүүлсэн байна.		Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг L, M (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх төлөвлөгөөт оны ажлыг эхлүүлсэн. Үүнд: 1. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг L, M (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх 2 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан. 2. Үргэлжлэн хэрэгжих УГЗ-200-L, УГЗ-200-M(N) төсөл /хээрийн судалгаатай/-ийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулсан. 3. Улсын тусгай хэрэгцээний газар болон хилийн бүсэд судалгаа хийх УГЗ-200-L нэгтгэл төслийн гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлэх талаар хандан УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, ТНБДаргын	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т илгээсэн.</p> <p>4. 2021 онд үргэлжлэн хэрэгжих 2 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг боловсруулан ТНБД-ын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан. Үргэлжлэн хэрэгжих төслүүдийн хээрийн судалгааны ажил цар тахлын хөл хорио, вакцинжуулалттай холбоотойгоор 6-р сарын 10-аас эхэлсэн.</p> <p>5. УГЗ-200-Л-нэгтгэл, УГЗ-200-М-нэгтгэл төслүүдийн 2021 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021.11.19-30-нд хүлээн авсан.</p>	
3.4.	Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70%-ийг хамруулна.	Улсын төсөв 2,153.7	Монгол орны нутаг дэвсгэрийн 65 хувийг агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлын нислэгт хамруулсан байна.	63.4%	Ховд-2020 төслийг үргэлжлүүлэх, нутаг дэвсгэрийн 65% -ийг судалгааны ажилд хамруулна.	<p>Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг эхлүүлсэн. Үүнд:</p> <p>1.Ховд-2020 төслийн төсөв, төлөвлөгөөг хянаж боловсруулан УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.</p> <p>2.Үргэлжлэн хэрэгжих Ховд-2020 төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>3.Төлөвлөгөөт онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг хийж дуусгахаар төлөвлөн өмнөх оноос үлдсэн 28,677 тууш км-т судалгааны нислэгийг хийж дууссанаар нутаг дэвсгэрийн 1.6%-ийг хамруулсан. Төслийн ажлыг саадгүй гүйцэтгүүлэх зорилгоор дэмжлэг хүсэх тухай УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 албан бичгийг БОАЖЯ-нд, ТНБДаргын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т хүргүүлсэн.</p> <p>4.Хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021.11.30-нд хүлээн авсан.</p>	100%
3.5.	Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100% хамруулна.	Улсын төсөв 1,185.6	Монгол орны нутаг дэвсгэрийн 80 хувийг 1:1000000-ын масштабын геохимийн зураг зохиох ажилд хамруулсан байна.	65%	Геохими-2019 төслийг үргэлжлүүлэх, нутаг дэвсгэрийн 80% -ийг судалгааны ажилд хамруулна.	<p>Монгол орны нутаг дэвсгэрийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулж зураг зохиох төслийн хүрээнд 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км² талбайд хийсэн ажлыг үргэлжлүүлэн 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Геохими-2019 судалгааны талбайн нь 1,062,197.0 км² буюу нутаг дэвсгэрийн 67.9 хувь -ийг эзлэх бөгөөд 2019, 2020 оны хээрийн судалгаагаар 60.9 хувьд дээжлэлтийн ажлыг хийсэн. Төлөвлөгөөт онд үлдсэн 7 хувийг хээрийн судалгааны ажилд хамруулахаар ажлыг эхлүүлсэн.</p> <p>- Геохими-2019 төслийн төсөв, төлөвлөгөөг боловсруулан УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						- Төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. 5.- Улсын тусгай хэрэгцээний газар болон хилийн бүсэд судалгаа хийх Геохими-2019 төслийн гүйцэтгэгчид Төслийн ажлыг саадгүй гүйцэтгүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлэх тухай УУХУСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, УУХУСайдын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т тус тус хүргүүлсэн.	
3.6.	Бүс нутаг болон хотуудын геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийнэ.	Улсын төсөв 913.9	Төслийг эхлүүлсэн эсэх: 0-Эхлүүлээгүй 1-Эхлүүлсэн	2 төсөл	Эрдэнэт, Дархан хотын суурьшлын бүсэд судалгааны ажлыг хийх, Ховд хотод шинээр судалгааны ажлыг эхлэнэ.	Төлөвлөгөөт онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан хотын геозкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлүүлсэн. Үүнд: 1. “ЭР геозкологи-2019”, “ДА геозкологи-2020” төслийн төсөв, төлөвлөгөөг боловсруулан УУХУСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан. 2. Төслүүдийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.25, 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. 3. “ДА геозкологи-2020” төслийн хээрийн судалгааны ажил гүйцэтгэхтэй холбогдуулан эзэмшлийн талбайд нэвтэрч дээжлэлт хийхэд дэмжлэг үзүүлэх тухай ТНБДаргын 2021.06.03-ны өдрийн 03/1408 дугаар албан бичгийг “Шарын гол” ХК, “Дархан дулааны цахилгаан станц” ТӨКХ, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Эрэл цемент” ХК, “НИК” ХХК-ийн Дархан НХСалбарын захиргаанд хүргүүлсэн. 4. Төслүүдийн 2021 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021 оны 11 дүгээр сард хүлээн авсан.	100%
			Төслийг эхлүүлсэн эсэх: 0-Эхлүүлээгүй 1-Эхлүүлсэн	2 төслийн геологийн даалгаврыг батлуулсан байна.		Шинээр хэрэгжүүлэх Ховд геозкологи-2021, Гүний хагарал-1 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2021.03.15-ны өдөр УУХУ-ийн Дэд сайдаар батлуулсан. Гүний хагарал-1 болон ХО геозкологи-2021 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй Захиалагчаас өгсөн үүргийн дагуу 2021.06.11, 2021.07.21-ний өдрийн 17, 24 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.	100%
			Төслийн үр дүнг хүлээн авсан эсэх: 0-Аваагүй 1-Авсан	ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх ээр санал боловсруулсан байна.		Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн Улаанбаатар геозкологи, гидрогеологийн төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл гүйцэтгээд байна.	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

3.7	Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ.	Улсын төсөв 1,300.0	Төслийг эхлүүлсэн эсэх: 0-Эхлүүлээгүй 1-Эхлүүлсэн	1 төсөл	Мезо-Кайнозой-2021, гүний хагарал-1, гео орчин-2021 сэдэвчилсэн судалгааны ажлыг эхлүүлнэ.	Монгол орны нутаг дэвсгэрийг хамарсан металлогений зураг зохиох Мета-2014 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2021.06.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Тус зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.08.13-ны өдрийн А/225 дугаар тушаалаар төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан. Мезо-Кайнозой-2021, Гео орчин-2021 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг 2021.03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан. Төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн Мезо-Кайнозой-2021 төслийн гүйцэтгэгчтэй 2021.07.07-ны өдрийн 21 дугаартай гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. Харин Гео орчин-2021 төслийн тендер 2 удаа амжилтгүй болсон тул 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2022 оны УУХҮСайдын төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулсан.	90%
3.8	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ.	Улсын төсөв 150.0	Төслийн үр дүнг хүлээн авсан эсэх: 0-Аваагүй 1-Авсан	1 төсөл	ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлыг эхлүүлнэ.	МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан төслийн 4-р үе шатны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2021.06.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Тус зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.08.11-ний өдрийн А/217 дугаар тушаалаар төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан.	100%
			Төслийг эхлүүлсэн эсэх: 0-Эхлүүлээгүй 1-Эхлүүлсэн			Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан “Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн IV үе шатны ажлын үр дүнгийн тайланд шинжээч томилох тухай 2021.01.26-ны өдрийн №УТХ-2021/07 дугаар шийдвэрийн шинжээчээр Б.Дэлгэрцогт, Я.Бат-Ирээдүй, Ц.Минжинсор нар томилогдсон. ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх 2021.06.24-ний өдрийн УТХ-2021-07 дугаар хуралдаанаар Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан “Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн IV үе шатны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, ЭБМЗ-ийн УТХ-2021-07-02 хурлын тэмдэглэл, УТХ-07-02 дугаартай дүгнэлтийг албажуулсан. Тухайн тайланг хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.08.11-ний өдрийн А/217 дугаартай тушаалыг баталсан.	100%

					Төслийн V үе шатны ажлын гүйцэтгэгч шалгаруулах сонгон шалгаруулалтын үр дүнд Геологийн судалгааны төв ТӨҮГ шалгарч “Геологийн судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ”-г ТНБДаргатай 2021.07.21-ний өдрийн 23 дугаар гэрээг байгуулсан.	
					<p>“Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Байгалийн нөөц, баялгийн яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийн төсөлд хятадын талаас ирүүлсэн саналыг тусган 2021.10.07-ны өдөр хүргүүлсэн бөгөөд санамж бичгийг хоёр тал эцэслэн тохироод байна. Санамж бичигт гарын үсэг зурах ёслолыг цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Улаанбаатар дахь БНХАУ-ын ЭСЯ-д эсвэл Бээжин дэх Монгол Улсын ЭСЯ-д гарын үсэг зурах эрх олгон зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p>Монгол Улсын УУХҮЯ болон БНСУ-ын Геологи, эрдэс баялгийн хүрээлэн хооронд хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын Санамж бичгийн төсөлд холбогдох саналыг тусган боловсруулж 2021.10.28-ны өдөр БНСУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-нд цахим шуудангаар хүргүүлэв. Хариуг хүлээж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд санал авах тухай УУХҮСайдын 2021.10.07-ны өдрийн 01/2416 дугаартай албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. ГХЯ-аас 2021.10.28-ны өдрийн 09/4798 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг тусган дахин хүргүүлсэн.</p> <p>УУХҮСайд Г.Ёндон Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэд дарга Малгожата Гошевска тэргүүтэй төлөөлөгчдийг 2021.11.23-ны өдөр УУХҮЯ-д хүлээн авч уулзсан албан уулзалтыг зохион байгуулав. Польшийн талаас БНПУ-ын Сеймийн дэд дарга Малгожата Гошевска, Уур амьсгал, байгаль орчны дэд сайд Пиотр Джиаджио, БНПУ-ын Элчин сайд Крзыштоф Бойко болон Уур амьсгал, байгаль орчны яам, Улсын Геологийн алба, КГХМ компаний төлөөлөгчид оролцсон. Уулзалтын тэмдэглэлийн хувийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн. Айлчлалын үеэр КГХМ компаний төлөөлөгчид үйлчлэх унаагаар хангаж, зочдын VIP танхимын зөвшөөрөл, Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцахтай холбогдуулан 2021.11.10-ны өдрийн 02/2735, 2021.11.17-ны өдрийн 04/2824, 2021.11.12-ны өдрийн</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						04/2779 дугаартай албан бичгийг боловсруулан хүргүүлж, Засгийн газрын авто баазтай Автомашинаар үйлчлүүлэх тухай гэрээг байгуулсан. Монгол Улс, Бүгд Найрамдах Польш улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын геологийн салбарт хамтран ажиллах тухай УУХҮЯ-ны харьяа Үндэсний геологийн алба, Польш улсын Геологийн хүрээлэн-Үндэсний судалгааны хүрээлэнгийн хооронд байгуулах харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийн төслийг Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан санамж бичгийг үйлдэх зөвшөөрлийг авч 2021.11.24-ний өдөр Санамж бичгийг Улаанбаатар хотноо үйлдсэн. Санамж бичиг байгуулах удирдамжийг 2021.07.09-ний өдөр ТНБДаргаар батлуулж Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын 8.2-т заасны дагуу холбогдох газарт бүртгүүлсэн болно.	
4	ЗГҮАХ-3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.						
4.1.	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	Улсын төсөв 350.0	Ажлын явц: Хамгаалсан-100% Хамгаалаагүй-0 хувь	10%	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн төрөлжсөн мэдээллийн санг магматизм, стратиграфийн мэдээллээр баяжуулах Геомэдээлэл-2019 төслийн үр дүнг хүлээн авна.	100%	
			Төслийг эхлүүлсэн эсэх: 0-Эхлүүлээгүй 1-Эхлүүлсэн		Төслийн геологийн даалгаврыг батлуулсан байна.	100%	
					Геомэдээллийн дэд сангуудад нэмэлт баяжуулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх заавар, загвар боловсруулах сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгийн тайланд шинжээч томилох тухай 2021.02.05-ны өдрийн №УТХ-2021/10 дугаар шийдвэрийн дагуу шинжээчээр Т.Кульжамиш, Б.Энхтуяа, Д.Бямбадэмбэрэл нар томилогдсон. ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх 2021.06.24-ний өдрийн УТХ-2021-07 дугаар хуралдаанаар Геомэдээллийн дэд сангуудад нэмэлт баяжуулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх заавар, загвар боловсруулах сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, ЭБМЗ-ийн УТХ-2021-07-03 хурлын тэмдэглэл, УТХ-07-03 дугаартай дүгнэлтийг албажуулсан. Тухайн тайланг хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.08.11-ний өдрийн А/216 дугаар тушаал батлагдсан.		
					Геологийн баримт-1 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайд 2021.03.15-ны өдөр баталсан. Геологийн баримт-1 төслийн тендер 1 удаа амжилтгүй болсон бөгөөд Үндэсний геологийн албанаас Тагнуулын ерөнхий газарт хандан геологийн мэдээллийг боловсруулах энэхүү төслийг өөрсдийн хүчээр хийх хүсэлт гаргасантай холбогдуулан тендерийг зогсоосон. Гэрээ шууд байгуулах ҮГА-ны албан хүсэлтийг Тагнуулын ерөнхий газраас төрийн		

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						нууцтай холбоотой мэдээллийг боловсруулах хуулийн этгээдтэй аюулгүй байдлын гэрчилгээ гаргуулан гүйцэтгүүлэх боломжтой хариу ирүүлсэн ба холбогдох хууль, ТЕГ-ын албан бичгүүдийг судлан уг төслийг 2021 онд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэр гарсан. Учир нь ҮГА-нд хадгалагдаж байгаа геологийн мэдээлэл нь төрийн нууцын жагсаалтад байхгүй бөгөөд албаны нууцтай холбоотой мэдээллийг ашиглан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдтэй төндөрийн хуулийн 3.4 дахь заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах боломжгүй болсон. Уг төслийг 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн УУХҮСайдын 2022 оны төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулсан.	
4.2.	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	Улсын төсөв 450.0	Төслийн хэрэгжилтийн явц: Эхлүүлээгүй-0% Эхлүүлсэн-30%	5%	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архив бүрдүүлэх төслийг эхлүүлнэ.	ТНБДаргын 2021.11.25-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/95 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр геологийн мэдээллийн санг нэгтгэх, бүрдүүлэх, геологийн баримтын архивын үйлчилгээг цахимжуулах, чулуун дээжийн санг шинэчлэх, баяжуулах зорилго бүхий 3 төслийг 2021 оноос шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэх боломжтой эсэх асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс Чулуун дээжийн сан-1 төслийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлэхээр санал гаргасан. Баримт бичгийн менежментийн системийг (DMS) хөгжүүлж байна. Тус систем нь геологийн баримтын төв архивт байгаа тайлан, мэдээллийг татан авах, сканнердах, оптик тэмдэгт мэдрэх, хадгалах, бүртгэх, удирдах үүргүүдтэй. Геологийн баримт материал болон төрөл бүрийн лавлагаа, геомэдээллийг онлайн хэлбэрээр түгээх, хэрэглэгч амар хялбараар мэдээлэл олж авахад хялбар болох системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж байна. Үндэсний геологийн мэдээллийн сангийн портал болох www.mris.mn нүүр хуудасны туршилтын загварыг боловсруулж, холбогдох саналыг авч, сайжруулалт хийж, ҮГА-ны веб сервер дээр www.mris.mn нууцлал хамгаалал (SSL certificate) хийгдсэн. Энэхүү систем нь геомэдээллийн сэдэвчилсэн сангуудын бүртгэл болон удирдлагын системүүдээс бүрдэх бөгөөд олон төрөлт хайлт хийх мета сан, газарзүйн мэдээллийн систем бүхий олон хэрэглэгч ашиглах боломжтой мэдээллийн сан юм.	100%
5	ЗГҮАХ-3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.						

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

5.1.	Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.	Улсын төсөв 544.9	Төслийн хэрэгжилт 0-Эхлүүлээгүй 1-Эхлүүлсэн	1	ГАСАМ төслийн үр дүнгийн тайланг хүлээн авах, өндөр технологийн түүхий эдийн ӨТТЭ-1-2021 судалгааг эхлүүлсэн байна.	Төлөвлөгөөт онд үр дүнгийн тайлан боловсруулах ГАСАМ төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн. Төслийн 2021 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Төслийн суурин боловсруулалтын ажил үргэлжлэн хийгдэж байна. Өндөр технологийн түүхий эдийн ӨТТЭ-1-2021 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайд 2021.03.15-ны өдөр баталсан. Төслийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2021 оны хээрийн анхдагч баримт материалыг хүлээн авсан. Тус төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн 2021.07.07-ны өдрийн 22 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.	100%
5.2.	Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.	Улсын төсөв 7,049.6	Төслийн хэрэгжилт 0-Эхлүүлээгүй 1-Эхлүүлсэн	1	Үнэт, ховор, холимог металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлыг үргэлжүүлэх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх ажлыг эхлүүлсэн байна.	ЭҮ-1-2020 болон БӨМ-Алт-2019 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулж ажлыг эхлүүлсэн. Төслийн 2021 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Төслүүдийн ажил үргэлжлэн хийгдэж байна. - ЭҮ-2-2021, ЭҮ-3-2021 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайд 2021.03.15-ны өдрийн тушаалаар баталсан. 2 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн 2021.07.07-ны өдрийн 19, 20 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. ЭҮ-2 төслийн 2021 оны хээрийн анхдагч баримт материалыг хүлээн авсан.	100%
5.3.	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө.	Хувийн хөрөнгө оруулалт 73,700.0	Сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо нэмэгдсэн байна.	27	Ашигт малтмалын хайгуулын 50-70 тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна.	УУХҮСайдын 2018.02.13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам”-аар 2021 онд СШ-48, СШ-49, СШ-50, СШ-51, СШ-52, СШ-53, СШ-54, СШ-55, СШ-56, СШ-57, 10 багц талбай зарлаж, холбогдох үнэлгээ дүгнэлтийг гаргасан. 2021 онд Нийт 70 талбай олгож Улсын төсөвт 16 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг тогтмол, түргэн шуурхай явуулсны үр дүнд 102 талбайг олгож 29 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>2021 оны 11-р сард СШ-58, СШ-59 зарлаж оролцох хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийн техникийн болон үнийн саналыг хүлээн авч байна.</p> <p>СШ-48, СШ-49, СШ-50 дугаар сонгон шалгаруулалтаар 13 тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд СШ-50, СШ-51 дугаар сонгон шалгаруулалтаар 12 тусгай зөвшөөрөл олгохоор хуульд заасан үйл ажиллагааг явуулж байна.</p> <p>Өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 43%-иар өссөн байна.</p>	
6	ЗГҮАХ-3.2.16. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.						
6.1.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй ил тод болгох хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.	-	Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан эсэх 0-Боловсруулаагүй 1-Боловсруулсан	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгох ажил 0%.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажил 100%.	<p>Геологи, уул уурхай өндөр хөгжсөн орнуудын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтын хэлбэрүүдийн судалгааг боловсруулж УУХҮСайд тэргүүтэй удирдлагын багт 2021 оны 1 дүгээр улиралд танилцуулсан.</p> <p>Монгол Улсад Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн олголт хэрхэн явагдаж байсан, эрх зүйн өөрчлөлт хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо хэмжээнд хэрхэн нөлөөлсөн талаар судалгааг боловсруулж УУХҮСайдад 2021 оны 2 дугаар улиралд танилцуулсан.</p> <p>Ашигт малтмалын тухай хууль болон салбарын байгууллагуудын ажил үүргийн хуваарилалтад чиг үүргийн судалгаа хийх тухай ТНБДаргын 2021.01.18-ны өдрийн 03/125 дугаар албан бичгээр хүргүүлж, АМГТГ, ҮГА-аар холбогдох судалгаануудыг хийлгэсэн. Судалгааны үр дүнг хянаж, холбогдох нэмэлт өөрчлөлт, засваруудыг хийж Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга хийх үүрэг бүхий ажлын хэсэгт шилжүүлсэн.</p> <p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олголтын явцын судалгааг боловсруулж холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Удирлагад танилцуулсан.</p>	100%
6.2.	Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.	2,500.0 /Улсын төсөвөөр 100 хувь /	Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан эсэх 0-Боловсруулаагүй 1-Боловсруулсан	Аж ахуйн тооцоот газрыг бий болгох ажил 0%.	Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллага байгуулах асуудлыг шийдвэрлүүл нэ. 50%.	<p>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг бий болгохоор тусгасан.</p> <p>Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөл болон төрийн өмчит аж ахуйн тооцоот газрын дүрмийн төслийг боловсруулсан бөгөөд холбогдох тооцоо, судалгааг яамны удирдлагад танилцуулсан. Канадын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа Мерит төслийн удирдлагад 2022 оны төлөвлөгөөнд энэ асуудалд хамтран ажиллах санал хүргүүлсэн.</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

6.3.	Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах ажлыг зохион байгуулах хүрээнд Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулна.	818.6 /Улсын төсөвөөр 100 хувь /	Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулна. 0-Боловсруулаагүй 1-Боловсруулсан	Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах ажил 0%.	Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүл нэ. 50%.	Орон нутагт эрдэс баялгийн нэгж байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Өмнөговь, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон аймгуудад байгуулахаар "Зарим орон нутагт Эрдэс баялгийн нэгж байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан бөгөөд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч Сангийн яамны саналыг заавал авахаар буцаасан. Сангийн яамнаас "Нэр дурдсан аймгуудад байгуулах Эрдэс баялгийн хэлтсийг тухайн аймгийн Засаг даргын Тамгын газарт бус харин Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын харьяанд 2022 оноос эхлэн байгуулахаар тогтоолын төслийг өөрчлөх" гэсэн санал ирүүлсэн. Энэ саналтай уялдуулан Сангийн яам холбогдох орон тоо, төсвийг УУХҮСайдын 2022 оны төсвийн төсөлд хянаж 1,0 тэрбум төгрөг тусгасан. Дээрх нөхцөл байдалд тохируулан Засгийн газрын тогтоолыг дахин боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	100%
6.4.	Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна.	170.0 /Улсын төсөвөөр 100%/	Шаардлагатай судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн эсэх. 0-Холбогдох байгууллагуудад хүргүүлээгүй 1- Холбогдох байгууллагуудад хүргүүлсэн	Холбогдох яам, байгууллагат ай хамтарч зохион байгуулах ажил 0%.	Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийн судалгаа гаргана. Мэргэжилтэй ажилчин инженер техникийн ажилтан бэлтгэх санал боловсруулна	- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050 болон түүнээс Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 2021 оны ажиллах хүчний мэдээлэл болон уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд тухайн төслийн техник, технологийн шаардлагаас хамаараад зарим мэргэжлийн инженер, техникийн гадаад ажиллах хүч, мэргэжилтэн шаардлагатай байдаг бөгөөд тус яамнаас нийт давхардсан тоогоор 142 аж ахуйн нэгжийн 8377 инженер, техникийн ажилтны холбогдох материалыг судалж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамжийг үйлчилгээний газарт тодорхойлолт хүргүүлсэн. - Геологийн салбарын ажил мэргэжлийн ангиллыг багцалж, мэргэжлийн нэр, нэршил, ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэх үүрэг, хууль эрх зүйн болон нийгэм эдийн засгийн үндэслэл бүхий тайлбар саналыг нэгтгэн ХНХЯ-нд хүргүүлэхээр Монголын Геологийн Холбоодын Нэгдсэн Зөвлөл-ийн даргын 02/21 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг байгуулсан. Дэд ажлын хэсэг нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх геологийн салбарын мэргэжлийн нэр, индекс, тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, түүнчлэн геологийн салбар дахь ажил мэргэжлийн ангилалд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг /YAMAT-08/-д тусгуулахаар 2021.05.09-ны өдрийн	100%

						034/21 дугаар албан бичгийг УУХҮЯаманд ирүүлсэн. Хувийг ХНХЯ-д хүргүүлсэн.	
7	ЗГҮАХ-3.2.1. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.						
7.1.	Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна.	52,000.0 Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл/	Ажлын явц, хувиар	0%	Төслийн удирдлага, инженеринг, тоног төхөөрөмжийн худалдан авалт. 8.9%	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн хэрэгжүүлж байгаа төслийн технологи өөрчлөгдөх нөхцөл байдал үүсч өмнө сонгосон технологиос хөрөнгө оруулалт болон цахилгаан эрчим хүчний зарцуулалт 2-3 дахин багатай технологи болох Мини домен зуух бүхий гангийн үйлдвэр байгуулах “Монгол ган цогцолбор-1” төслийн ТЭЗҮ-ийг шинээр боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох “МСС-CERI” компаниар /712.5 сая төгрөг/ гүйцэтгүүлж, 2021.09.30-ны өдрийн УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гаргасан.	90%
7.2.	Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.	30,772.4 Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл/	Ажлын явц, хувиар	75.8%	Барилга, дэд бүтцийн ажлыг дуусгаж тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгэнэ. 100%	Орхон аймагт “Бэрэн групп” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайд, Дэд сайд нар тус компанийн захирал Б.Мөнхтөртэй уулзаж төслийн хэрэгжилтийн явцтай тухай бүр танилцах, тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авсан. Мөн тус компанийн хэрэгжүүлж байгаа Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг бүрэн ашиглалтад оруулахад шаардлагатай санхүүжилт, зээлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга, холбогдох материал хүргүүлэх тухай УУХҮСайдын 2021.10.25-ны өдрийн 01/2561 дугаар албан бичгийг ЗГХЭГ-ийн дарга Ц.Нямдоржид хүргүүлсэн. УУХҮСайдын 2021.11.04-ний өдрийн 01/2697 дугаар албан бичгээр тус яамны зүгээс төслийг үргэлжлүүлэх, үйлдвэрийг ашиглалтад оруулахыг бодлогоор дэмжин ажиллаж байгаа тухай албан бичгийг “Бэрэн групп” ХХК болон түүнтэй хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явц, үйлдвэрийн техник, технологийн талаар санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн /УУХҮСайдын 2020.08.28-ны өдрийн А/218 тоот тушаалаар байгуулагдсан/ санал, зөвлөмж, дүгнэлтийн хамт Хөгжлийн банкинд хүргүүлсэн. Тус компаниас үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 15 сая ам.долларын санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг Хөгжлийн банкинд гаргасан бөгөөд банкны зүгээс	70%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						дэмжих саналтай байна. Одоогоор санхүүжилтийн боломжит хувилбарыг судалж байна. Хөгжлийн банкны дэд захирал С.Цэрэндаш, Нөөцийн удирдлагын хэлтсийн захирал А.Хүчитбаатар нартай төслийн нэмэлт зээл, санхүүжилтийн асуудлаар 2021.12.07-ны өдөр уулзалт зохион байгуулж харилцан тохиролцсоны дагуу УУХҮЯ болон Хөгжлийн банк хооронд хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийг дэмжин хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулж байна.	
7.3.	Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна.	11,350.0 Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт/	Ажлын явц, хувиар	9,400.0 сая төг. 16.4%	Өртөөнөөс үйлдвэрийн талбай хүрэх авто зам, дотор авто зам барих, домен зуухны угсралтын ажлыг гүйцэтгэнэ. 56%	Төслийн ажил Ковид-19 цар тахлын улмаас 2020-оос 2021 оны 12 сарын байдлаар зогсонги байдалд байна. Төслийн 2021 оны санхүүжилтыг толгой компани /“Монзол групп” ХХК/-ийн хөрөнгө оруулалтаар шийдсэн. Цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж, 3.567 тэрбум төгрөгийн урьдчилгааг төхөөрөмж нийлүүлэгч компани /БНХАУ-ын “Qianxi ADI Mechanical Casting” Co.Ltd/-д төлсөн боловч төлөвлөгөөний дагуу газар дээр нь очиж тоног төхөөрөмжийн сонголт хийн оруулж ирэх, мөн БНХАУ-аас мэргэжилтэн оруулж ирэх асуудлууд Ковид-19 цар тахлын хилийн хөл хорионы улмаас шийдэгдэхгүй байна.	70%
7.4.	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	40,099.1 “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өөрийн хөрөнгө	Ажлын явц, хувиар	2,306.0 сая төг. (5 %)	Зураг төсөл боловсруулах, УТП-ийн авто зам, дулаан, ус хангамж, цахилгаан хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээг барих ажлыг эхлүүлнэ. 30%	Тус зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 1. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2020.12.15-ны өдөр, Техник технологийн түвшний үнэлгээг 2020.09 сард, БОННУ-ний тайланг 2021.02.09-ний өдөр тус тус холбогдох мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. 2. УУХҮЯамны ЭБМЗ-ийн Боловсруулах үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу дэд бүтцийн нарийвчилсан зураг, төсөл боловсруулах, барьж байгуулах ажилд нийт 136.0 тэрбум төгрөгийг тусгасан ба 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 4.8 тэрбум төгрөг тусгагдсан нь паркийн төмөр зам, авто зам, ус хангамж, ариутгах татуургын систем барих зураг төсөл боловсруулах, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах тендерийн сонгон шалгаруулалтыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас зохион байгуулан ажиллаж байна. 3. Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						4. Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021.07.01-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор тус паркийг байгуулах зорилгоор нийт 1217,4 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжсэн. Үүний дагуу парк байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал хүргүүлэх тухай УУХҮСайдын 2021.07.08-ны өдрийн 01/1764 дугаар албан бичгийг БХБЯ-нд хүргүүлсэн.	
7.5.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үйлдвэр" ТӨҮГ-ын ажлын хүрээнд баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	123,446.0 "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө-30%, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл -70%	Ажлын явц, хувиар	0%	ТЭЗҮ-ийн тодотгол хийх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. 7.5%	Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. БНХАУ-ын China ENFI Engineering Co., Ltd (ENFI) болон China nonferrous metal industry's foreign engineering and construction Co., Ltd (NFC) консорциум нь "Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан ба төслийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд элементийн хүхэр үйлдвэрлэх технологийн "үйлдвэрлэлийн туршилт"-ын ажлыг гүйцэтгэхээр "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран ажиллаж байна. Туршилтын үр дүнд үндэслэн боловсруулагдаад буй ТЭЗҮ-д тодотгол хийнэ.	90%
7.6.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын үйлдвэр" ТӨҮГ-ын ажлын хүрээнд хүдрийг уусгах байгуулна	83,685.5 "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө-34%, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл -66%	Ажлын явц, хувиар	0%	Үйлдвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, тусгай зөвшөөрөл авах. 50%	Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Уг тогтоолын 2 дахь хэсэгт исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас "SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил" гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2021 онд зохион байгуулсан бөгөөд "Майнинг шорт лонг терм" ХХК-тай 2021.09.17-ны өдөр гэрээ байгуулсан. Үйлдвэр байгуулахад шаардлагатай бүтээн байгуулалтын ажлыг 2022 онд эхлүүлж, 2023 онд үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

7.7.	Үнэт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна.	металл барьж	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх: 0-Зохион байгуулаагүй 1-Зохион байгуулсан	ТЭЗҮ, БОННУ, инженер геодезийн зураг хийгдсэн. 1%	1	Засгийн Газрын 2020.06.01-ний өдрийн 212 дугаар тогтоолоор Ашигт малтмал хайх эрх олгогдсон ба тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020.08.26-ны өдрийн 308 тоот шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших Хүрэнцав нэртэй 1704.51 гектар, Мухар хар толгой нэртэй 4313.57 гектар, Довжоот нэртэй 1393.37 гектар, Халзан нэртэй 453.89 гектар талбай нийт 7865.34 гектар талбай бүхий 4 тусгай зөвшөөрлийг олгосон бөгөөд эдгээр талбайг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төслийн тодорхой хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх зорилгоор Хүрэнцав нэртэй талбайд геологийн эрэл хайгуул, геофизикийн ажил гүйцэтгэх тендер зарлан ажиллаж байна. Компанийн эзэмшлийн хайгуулын тусгай зөвшөөрлийг барьцаалан зээл олгох боломжийн талаар арилжааны банкуудад хандсан бөгөөд арилжааны банкуудаас хайгуулын тусгай зөвшөөрөл барьцаалан зээл олгох боломжгүй тухай хариу ирүүлсэн. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулагдсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж Ажлын хэсгийн эцсийн дүгнэлтийг 2021.12.01-ний өдөр гаргаад байна. Мөн төслийг эрчимжүүлэх ажлын хүрээнд үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төсөлд оролцох саналаа илэрхийлсэн БНХАУ-ын уул уурхайн тоног төхөөрөмжийн Шинхай компанийн төлөөлөлтэй УУХҮЯ-ны ХҮБГ, “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн төлөөлөл 2021.11.25-ны өдөр цахим уулзалтыг зохион байгуулж үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулалт, хүчин чадал, өртөг зардал, төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар санал солилцсон. Төслийн хэрэгжилтийн явцтай тухай бүр танилцах, тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэгчтэй сар бүр уулзалт хийх хуваарь гарган 2021.11.22-ны болон 2021.12.06-ны өдрүүдэд “Эрдэнэс Алт ресурс” ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн уулзалтыг зохион байгуулан, тодорхой чиглэл удирдамжийг өгч ажилласан.	90%
------	--	--------------	-----------------------------------	--	---	---	--	-----

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

7.8.	Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.	4,267.9 сая төг.	Ажлын явц, хувиар	Урьдчилсан ТЭЗҮ, Байгаль орчны ерөнхий үнэлгээ хийгдсэн. Газрыг тусгай хэрэгцээнд авсан. 0.2%	Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах. Төмөр зам, эрчим хүч, ус хангамж, гадаад бүтцийн ТЭЗҮ, техникийн нөхцлийн бэлтгэл ажлыг хангана. 0.5%	ЗГ-ын 2017 оны 88 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2018.12.12-ны өдрийн “Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай” 378 дугаар тогтоолоор зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн зөвлөгөө авах зорилгоор өмгөөллийн “Монгол өмгөөлөгч” ХХН-тэй гэрээ байгуулан ажиллаж, гүйцэтгэсэн тайланг хүлээн авсан. Мөн үйлдвэрийг Оюу-толгойн баяжуулах үйлдвэртэй холбох салаа төмөр зам болон эрчим хүчний дэд бүтцийн техникийн нөхцлийг боловсруулаад байна. Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох бэлтгэл ажлын хүрээнд хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хамтарсан ажлын хэсэг байгуулах, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төслийг багтаасан ажлын даалгавар боловсруулж, батлуулах, хөрөнгө оруулагчийн урьдчилсан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, жагсаалт гаргах, эцсийн шалгаруулалтын даалгавар боловсруулах, эцсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах зэрэг цаг хугацаа шаардсан ажлуудыг эхлүүлээд байгаа бөгөөд шалгарсан хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд талуудын саналыг тусган 2022 оны 2 дугаар улиралд багтаан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг УУХҮСайдын 2021.11.04-ний өдрийн 01/2698 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Цаашид төслийн хэрэгжилтийн явцтай тухай бүр танилцах, тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэх нэгжтэй сар бүр уулзалт хийх хуваарь гарган ажиллаж байна.	90%
8	ЗГҮАХ-3.2.1.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.						
8.1.	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг	152,858.875 төгрөг (53,937,500)	Хөрөнгө оруулалтын хэмжээ, шнээр	43,927.0 төгрөг (15,500,000)	Шинээр 2 талбайд БХГ байгуулж,	2021 онд хайгуулын ажилд нийт 40,676,116.37 ам.доллар зарцуулна. “Жи Өү Эйч” ХХК хайгуулын өрөмдлөгийн ажлыг 2021.03.08-ны өдрөөс эхлүүлсэн ба 2021.06.10-ны өдрийн	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	эрчимжүүлж нөөцийг өсгөнө.	ам.доллар) /хувийн хэвшил/	байгуулсан БХГ-ний тоо, нэмэгдсэн нөөц, олборлолтын хэмжээ	ам.доллар), 26 БХГ, Баталгаат нөөц 332 сая.тонн, ашиглалтын баталгаат нөөц 42 сая.тонн, олборлолт 520.0 мянган тонн	хайгуулын ажлын хөрөнгө оруулалт 152,858.875 төгрөг (53,937,500 ам.доллар), ГТ-ны олборлолт 836.4 мян.тн болсон байна.	байдлаар 3 цооногийн өрөмдлөгийн ажил дууссан, 2 цооногийн өрөмдлөгийн ажил явагдаж байна. Уламжлалт бус газрын тосны хайгуулын Гурвантэс-XXXV талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа талаар АМГТГ болон Тэлмэн Ресурс ХК-ийн хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг хянаж үзэж, бичиг баримтын бүрдлийг ханган, яамдын саналыг авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн. Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн, УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн “Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай” А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг “баталгаат (1P)” зэрэглэлээр 1,151,194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,931.0 тонн (1.04 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай (2P)” зэрэглэлээр 3,051,724.0 тонн (23.01 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай+боломжтой (3P)” зэрэглэлээр 5,385,942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар энэ онд 812 мянган тонн газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт 183,2 тэрбум төгрөг төвлөрүүлэх даалгавартай. 2021.06.09-ний өдрийн байдлаар 360,0 мянган тонн газрын тос олборлож, 344,2 мянган тонн газрын тос экспортолж, Улсын төсөвт 65.7 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр эхний хагас жилд ойролцоогоор 405 мянган тонн газрын тос олборлож, экспортлох төлөвтэй байгаа ба гүйцэтгэл 100 хувьд хүрэхээр байна	
8.1.1	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно.	152,858.875 төгрөг (53,937,500 ам.доллар) /хувийн хэвшил/	Хөрөнгө оруулалтын хэмжээ	43,927.0 төгрөг (15,500,000 ам.доллар)	152,858.875 төгрөг (53,937,500 ам.доллар)	Газрын тосны хайгуулын талбайд БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй “Метан газ ресурс” ХХК, “Жи Өү Эйч” ХХК, “Түмэн ойл” ХХК, “Смарт-ойл монголиа” ХХК, “Зон Хэн Юу Тиан” ХХК, “Монголын Алт” ХХК болон “Петровис ресурс” ХХК-иудын 2021 оны жилийн хайгуулын ажлын хөтөлбөр төсвийг батлаад байна. Үүнд: -“Метан газ ресурс” ХХК уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Тавантолгой-XXXIII талбайд 1,402,193.67 ам.долларын хөрөнгө оруулалтаар 4800 тууш.м баганат өрөмдлөг, цооногийн каротаж, сорьцлолтын ажил, лабораторийн ажил, тээвэрлэлт, топогеодезийн ажил,	90%

					<p>байгаль орчны нөхөн сэргээлт, суурин боловсруулалтын ажил гүйцэтгэх.</p> <p>-“Жи Өү Эйч” ХХК уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Номгон-IX талбайд 3,324,960.0 ам.долларын хөрөнгө оруулалтаар эрлийн маршрут, геологийн зураглал, геологи, геофизикийн судалгааны боловсруулалт, техникийн мэдээллийн сан бүрдүүлэх, 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, судалгааны боловсруулалт, тайлал, тайлан, чанарын хяналт, 5000 тууш.м стратиграфийн цооног өрөмдөх, хайгуулын чөмөг дээжлэлттэй, IFOT хэмжилттэй цооног, туршилтын ажил, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.</p> <p>-“Түмэн ойл” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Баянтүмэн-ХVII талбайд 3,832,365.56 ам.долларын хөрөнгө оруулалтаар 2 хэмжээст чичирхийллийн ажлын тайлал хийж, дахин боловсруулах, 2850 тууш.м өрөмдлөгийн ажил, гидрогеологийн цооног өрөмдөх, геофизикийн судалгаа, шаврын судалгаа, цооногийн туршилт, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.</p> <p>-“Смарт-ойл монголиа” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Эргэл-XII талбайд 10,783,114.54 ам.долларын хөрөнгө оруулалтаар геологи, геоморфлогийн судалгаа, талбайн өмнөх судалгааны мэдээлэл цуглуулах, 2 хэмжээст чичирхийллийн судалгааны бэлтгэл, параметрийн тест, хэмжилт, боловсруулалт, үр дүнгийн боловсруулалт, 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын төлөвлөлт, зураг төсөл, бэлтгэл, параметрийн тест, хэмжилт, хээрийн боловсруулалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.</p> <p>-“Зон Хэн Юу Тиан” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Галба-XI талбайд 3,011,247.6 ам.долларын хөрөнгө оруулалтаар хайгуулын 2 цооног өрөмдөх, цооногийн каротаж, шаврын судалгаа, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.</p> <p>-“Монголын Алт” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Төхөм-Х урд талбайд 17,309,120 ам.долларын хөрөнгө оруулалтаар хээрийн анги зохион байгуулалт, татан буулгалт, 500 тууш км 2 хэмжээст чичирхийллийн хээрийн ажил, хээрийн боловсруулалт, суурин боловсруулалт, тайлал хийх, тайлан бичих, 100 км² 3 хэмжээст чичирхийллийн хээрийн ажил, хээрийн боловсруулалт, суурин боловсруулалт, тайлал хийх, үр дүнгийн тайлан бичих, хайгуулын 5 цооногийн өрөмдлөгийн болон дизайн гаргах, давхарга зүйн цооногийн</p>
--	--	--	--	--	---

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>өрөмдлөг, цооногийн чөмөг чулуун дээж авах, шаврын судалгаа, цооногийн каротаж, цооногийн туршилтын ажил, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.</p> <p>-“Петровис ресурс” ХХК уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Т-I талбайд 427,999.00 ам.долларын хөрөнгө оруулалтаар астер зургийн тайлал, геофизикийн судалгаа, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх, уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Богд-IV талбайд 545,864.00 ам.долларын хөрөнгө оруулалтаар сейсмийн судалгааны тайлал боловсруулах, геофизикийн судалгаа, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх, уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Онги-V талбайд 467,251.00 ам.долларын хөрөнгө оруулалтаар 2 хэмжээст сейсмийн судалгааны тайлал боловсруулах, 3 хэмжээст сейсмийн судалгааны тайлал боловсруулах, геофизикийн судалгаа, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхээр тус тус хөтөлбөр төсвийг баталсан.</p> <p>Дээрх гэрээлэгчид 2021 онд хайгуулын ажилд нийт 40,676,116.37 ам.доллар зарцуулахаар төлөвлөгөө, төсөв батлагдсан.</p> <p>Газрын тосны хайгуулын Матад-XX талбайн гэрээлэгч “Петроматад” ХХК, Онги-V талбайн гэрээлэгч “Капкорп Монголиа” ХХК, Тариач-XV талбайн гэрээлэгч “Чайна Голден Сий Петролиум Эксплорэйшн Корпорэйшн” ХХК, Арбулаг-XXIX талбайн гэрээлэгч “Макс ойл” ХХК-иуд 2021 оны төлөвлөгөө, төсвийг батлуулахаар ирүүлээгүй. Ковид цар тахлын нөхцөл байдлын улмаас хил, гааль нээгдээгүй байгаатай холбоотойгоор хүн хүч, техник тоног төхөөрөмж орж ирэх боломжгүй байгаа тул ихэнх гэрээлэгчдийн хайгуулын ажил хийгдэх боломжгүй болсон. Харин “Жи Өү Эйч” ХХК дотоод нөөц бололцоог ашиглан хайгуулын өрөмдлөгийн ажлыг 2021.03.08-ны өдрөөс эхлүүлсэн ба 2021.12.10-ний өдрийн байдлаар хайгуулын 14 цооног өрөмдөж дууссан. Нийт 3 цооногийн өрөмдлөгийн ажил явагдаж байгаа ба өрөмдлөгийн ажлыг “Эрдэнэ дриллинг” ХХК, “Топ даймонд дриллинг” ХХК-иуд гүйцэтгэж байна. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт 519 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил гүйцэтгэсэн ба туслан гүйцэтгэгчээр “Бичил сейсм” ХХК ажилласан. Эдгээр ажлуудад 3 сая гаруй ам.доллар зарцуулсан байна.</p>	
8.1.2	Газрын тосны хайгуулын	БХГ-ний дагуу тухайн	Шинээр байгуулсан	Хайгуулын 23 БХГ	Шинээр 1 талбайд БХГ	АМГТГ-аас 2020.12.30-ны өдрийн 03/5769 дугаар албан бичгээр ирүүлсэн уламжлалт бус газрын тосны хайгуулын	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	жилд оруулах хөрөнгө оруулалтаар тодорхойлог доно. /хувийн хэвшил/	Бүтээгдэхүүн хуваах гэрээний тоо.		байгуулсан байна.	Гурвантэс-XXXV талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны талаар АМГТГ болон Тэлмэн Ресурс ХК-ийн хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Засгийн тогтоолын төсөл, БХГ-ний төсөлд санал авах тухай УУХҮСайдын 2021.02.23-ны өдрийн 01/388 дугаар албан бичгийг бүх яамдад хүргүүлсэн. Сангийн сайдаас БХГ-ний нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах тухай санал ирүүлсэнтэй холбоотойгоор гэрээлэгч буюу хөрөнгө оруулагч талтай Гэрээний үлдсэн нөхцлийг сайжруулах талаар хэлэлцээр хийж, БХГ-ний төслийг дахин ирүүлэх тухай УУХҮСайдын 2021.05.11-ний өдрийн 01/1239 дугаар албан бичгийг АМГТГ-т явуулсан ба АМГТГ нь хөрөнгө оруулагч талтай дахин хэлэлцээр хийж, 2021.05.25-ны өдрийн 3/2188 албан бичгээр БХГ-ний төслийг дахин ирүүлсэн. Тус БХГ-ний төслийг хянан, бүх яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн 203 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Гурвантэс-XXXV талбайд уламжлалт бус газрын тосны /нүүрсний давхаргын метан хий/ үйл ажиллагаа явуулах БХГ-г “Тэлмэн Ресурс ХК”-тай эрхийг АМГТГ-т олгосны дагуу 2021.07.27-ны өдөр БХГ-г байгуулсан.	
8.1.3	Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна.	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	Нэмэгдсэн нөөц	Газрын тосны баталгаат нөөц 332 сая.тонн, ашиглалтын баталгаат нөөц 42 сая. тонн	Хайгуулын 1 талбайд нөөц тогтооно.	Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн, УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн “Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай” А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг “баталгаат (1P)” зэрэглэлээр 1,151,194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,931.0 тонн (1.04 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай (2P)” зэрэглэлээр 3,051,724.0 тонн (23.01 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай+боломжтой (3P)” зэрэглэлээр 5,385,942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн.	100%
8.1.4	Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг	Ашиглалт, олборлолтын ажилд зарцуулах хөрөнгө оруулалтаар тодорхойлог доно.	Газрын тосны олборлолтын тогтвортой байдал	Газрын тосны олборлолт 400.0 мянган тонн	ГТ-ны олборлолт 836.4 мян.тн	Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар энэ онд 812 мянган тонн газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт 213.2 тэрбум төгрөг төвлөрүүлэх даалгавартай. 2021 оны 12 дугаар сарын байдлаар 629.3 мянган тонн газрын тос олборлож, 590.8 мянган тонн газрын тос экспортолж, улсын төсөвт 180.4 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Орлого төвлөрүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэл 85 хувьтай байна.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	<p>зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>/хувийн хэвшил/</p>				<p>БХГ-ний дагуу газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниуд газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө, төсвийг ирүүлсэн.</p> <p>Газрын тосны ашиглалтын БХГ-97 талбайн гэрээлэгч Доншен Газрын тос (Монгол) ХХК-ийн 2021 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2021.05.12-ны өдөр, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн гэрээлэгч Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2021 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2021.05.25-ны өдөр тус тус хэлэлцэн баталсан. Үүнд:</p> <p>Тосон-Уул XIX талбайн 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлууд 2021.12.01-ний өдрийн байдлаар газрын тосны ашиглалтын 35 цооног өрөмдөхөөс (үүнээс 10 цооногт хэвтээ өрөмдлөг) 3 цооног, 1520 метрт перфораци хийхээс 281.2 метрт, 48 үед шингэн хагалбар хийхээс 4 үед, шингэн хагалбар хийсэний дараа цооногоос 33300 тонн шингэн соруулж авахаас 492 тонн шингэн соруулж, 30000 тонн тос шавхалтын аргаар олборлохоос 20189 тонн тос шавхаж, 26 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулахаас хийгээгүй, 30 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулахаас 1 цооногт, 6 цооног их засвар хийхээс 1 цооногт, 50 цооногийг хүчлээр угаахаас 7 цооногт, 8 цооногт полимер шахахаас хийгээгүй, 28 үед том хэмжээний шингэн хагалбар хийхээс хийгээгүй, 13 төрлийн судалгаа хийх хийгээгүй, дэд бүтэц гадаргуун байгууламжийн ажлаас Тосон-Уул XIX талбайн халуун усны станцын барилгын ажил хийсэн байна.</p> <p>Тамсаг XXI талбайн 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлууд 2021.12.01-ний өдрийн байдлаар газрын тосны ашиглалтын 35 цооног өрөмдөхөөс (үүнээс 10 цооногт хэвтээ өрөмдлөг) 2 цооног, 1600 метрт перфораци хийхээс 34.5 метрт, 56 үед шингэн хагалбар хийхээс 35 үед, 25000 тонн тос шавхалтын аргаар олборлохоос 20230.45 тонн, 6 цооног их засвар хийхээс 1 цооногт хийгдсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан 26 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 30 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, шингэн хагалбар хийсний дараа цооногоос 33300 тонн шингэн соруулж авах, 50 цооногийг хүчлээр угаах, 23 цооногт полимер шахах, 8 үед том хэмжээний шингэн хагалбар хийх, 11 төрлийн судалгаа хийх, дэд бүтэц гадаргуун байгууламжийн ажил, хатуу хог хаягдлыг</p>	
--	--	------------------------	--	--	--	--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>цэвэрлэх, дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажил хийгдээгүй байна.</p> <p>1997 оны БХГ-т талбайн 2021 оны ажлын төлөвлөгөөнд газрын тосны ашиглалтын 6 цооног өрөмдөх, 2600 метрт перфораци хийх, 33 цооногт каротаж, 6 цооногт олборлолтын туршилт, 6 цооног ус шахалтад шилжүүлэхээс 5, 25 хуучин цооног олборлолтонд шилжүүлэхээс 22, олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 191 цооногоор нийт 373,083.4 баррель газрын тос олборлож, 21 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулахаас 22, 6 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулахаас 5, 10 цооногт хүчиллэгийн үйл ажиллагаа, 10 цооногт азотын хий шахах үйл ажиллагаанаас 4, 6 төрлийн судалгаа хийхээс 2, дэд бүтэц гадаргуун байгууламжийн 27 ажил, хатуу хог хаягдлыг цэвэрлэх, дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p>	
8.2.	Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.	176,700.0 Хувийн хэвшил	Дамжуулах хоолой барих олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай шийдвэр, ТЭЗҮ	0%	Дамжуулах хоолой барих олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулж, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулсан байна. ТЭЗҮ-ийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ТЭЗҮ-ийг хүлээн авсан байна. 10%	Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаарх танилцуулга хийсэн ба Засгийн газрын хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр төслийн сонгон шалгаруулалт зарлахыг холбогдох сайд нарт даалгасан. Үүнтэй холбогдуулан ТНБДаргын 2021.01.25-ны өдрийн А/08-р тушаалаар "Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах" Үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонирхолтой компанийг сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлт ирүүлэх урилга, сонгон шалгаруулалтыг олон улсад нэр хүнд бүхий Pipeline and Gas Journal сайтад 2021.03.01-ний өдөр нийтлүүлсэн. Газрын тос дамжуулах хоолой байгуулах төслийг Санхүүжүүлэх, Инженерчлэл, зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт (EPC+F)-ын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах Олон улсын тендерийг 2021.03.01-ний өдрөөс 2 үе шаттайгаар зарласан. Урьдчилсан сонгон шалгаруулалтад 9 орны 22 компани оролцсон бөгөөд тэдгээрээс шалгуур хангасан 15 компанид 2021.04.23-нд тендерийн баримт бичгийг хүргүүлсэн. Тендер ирүүлэх хугацааг 2021.05.23-ны өдөр байсныг тендер оролцогч компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 4	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						удаа сунгаж, тендерийг 2021.10.20-ны өдөр хүлээн авсан. Тендерт БНЭУ-ын Kalpataru power transmission limited, Япон улсын Sumitomo corporation, БНХАУ-ын Chinese petroleum pipeline engineering Co.Ltd болон Norinco international cooperation Ltd компаниудаас тендерийн баримт бичгийг ирүүлж техникийн болон санхүүгийн саналыг үнэлж дуусган оролцогчдод захиалагчаас мэдэгдлийг хүргүүлсэн.	
8.2.1	Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна.	-	Дамжуулах хоолой барих олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай шийдвэр	0%	Дамжуулах хоолой барих олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулж, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулсан байна. 100%	Газрын тос дамжуулах хоолой байгуулах төслийг санхүүжүүлэх, инженерчлэл, зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт (EPC+F) хэлбэрээр шалгаруулахаар шийдвэрлэж шалгарсан оролцогчид мэдэгдэл хүргүүлээд байна. Газрын тос тээвэрлэн хүргэх дамжуулах хоолойн трассыг Дорнод, Сүхбаатар, Дорноговь зэрэг 3 аймгийн 9 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 530 км-ээр тогтоон, дамжуулах хоолойн трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай хүсэлтийг УУХҮСайдын 2021.04.30-ны өдрийн 01/1154 дугаар албан бичгээр БХБЯ-нд хүргүүлээд байна.	100%
8.2.2	Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна.	176,700.0 Хувийн хэвшил	Батлагдсан ТЭЗҮ	0%	ТЭЗҮ-ийг боловсруулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, ТЭЗҮ-ийг хүлээн авсан байна. 50%	Тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын шалгаруулалтыг хийж оролцогчдод захиалагчаас мэдэгдэл хүргүүлээд байна. Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулж ТЭЗҮ болон бусад ажлыг зохион байгуулна.	50%
8.3	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	652,796.9 /БНЭУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээл/	Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хөрөнгө оруулалт	387.04 тэрбум, 10%	Үйлдвэрийн технологийн бус барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна. Мөн Лицензит байгууламжийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан байна. 25%	Технологийн бус барилга байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч Жэй Эм Си Прожектс лимитед компани нь 2020.01.15-ны өдөр үйлдвэрийн талбайн ажлыг эхлүүлсэн. EPC-1 багц ажлын зураг төслийн ажил 90%, бусад барилгууд болох захиргааны барилга-24,7%, эмнэлгийн барилга-67,0%, хоолны газрын барилга-68,2%, лабораторийн барилга 68,1%, нэвтрэх хаалга 1-ийн барилга 45,3%, нэвтрэх хаалга 2-ын барилга 36,6%, засварын газрын барилга-23,5%, агуулахын барилга 31,7%, гал командын барилга-25,6%-ийн тус тус гүйцэтгэлтэй буюу EPC-1 багц ажлын гүйцэтгэл 2021.12.07-ны өдрийн байдлаар 36,0%-ийн гүйцэтгэлтэй. Мөн Бор хөөврийн говиос ус дамжуулах шугам хоолойн ажлууд болох өргөх станцын барилга-31,4%, 11 ширхэг худгийн барилга-31,3%, ус нөөцлөх савны барилга-65,1%, ЦДАШ-22,1%, ус	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						дамжуулах хоолой-17,2%, үйлдвэрийн хашаан доторх авто зам-22,6%, зам талбайн ус зайлуулах хоолой-12,4%, зам талбайн ус хураах талбай-81,6%, замын доорх ус дамжуулах хоолой-82,4, технологийн шугам хоолойн сувагчлал-61,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.	
8.3.1	Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.	652,796.9 /БНЭУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээл/	Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалт, 387.04 тэрбум, 10%	Үйлдвэрийн технологийн бус барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна. Мөн Лицензит байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. 25%	Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэг бүхий Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2021 оны 122, 133 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Шадар сайдын 2021 оны 87 дугаар тушаалаар Ажлын хэсгийн төлөвлөгөө, ШСайдын 2021.09.13-ны өдрийн 01/21 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль, Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам, газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайг үйлдвэрт олгох асуудлыг тус тус батлуулсан. БНХАУ-ын Тяньжин боомтод саатсан барилгын материалыг татан авах талаар ГХЯ, ЗТХЯ, БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, МГТБҮ ТӨХХК, Энэтхэгийн JMC компанитай хамтран ажиллав. Мөн бүтээн байгуулалтын явцын талаар УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021.10.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 04 дүгээр тогоол гарсан.	100%
8.4.	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	2,834,500.0 Хувийн хэвшил	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдал	2.0 сая тонн	Шатахууны хангамж тогтвортой байна. хэрэглээ 2.1 сая тонн	Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 202 аж ахуйн нэгж улсын хэмжээнд шатахууны 86 агуулах, 1419 шатахуун түгээх станцаар дамжуулан бүтээгдэхүүний хангамж, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж байна. 2021.12.10-ны өдрийн байдлаар 1.6 сая тонн ГТБ импортлон, хэрэглэгчдийг газрын тосны бүтээгдэхүүнээр тасралтгүй, тогтвортой ханган ажиллаж байна. Засгийн газрын 2020.10.07-ны 136 дугаар тогтоолоор 2021 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 24 аж ахуйн нэгж 120,350.00 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ нь эдгээр аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Улсын хэмжээнд 2021.12.06-ны өдрийн байдлаар шатахууны ердийн хэрэглээний 28 хоногийн буюу 113.1 мянган тонн нөөцтэй байна. Өргөн хэрэглээний АИ-92 автобензиний үнийг тогтворжуулах, хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх,	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

					<p>харилцааг зохицуулах “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ыг Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн 68 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээний үлгэрчилсэн загвар, мэдээ тайлангийн маягтын загварыг УУХҮСайдын 2021.04.28-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан. Тус тушаал, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах тухай 2021.04.30-ны өдрийн 01/1150 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн ба журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Мөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын 2021.03.24-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба ЗГ-ын 74 дүгээр тогтоолоор улсын нөөцийг 30000 тонноор нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.</p>		
8.5.	Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Хувийн хэвшил	Евро-5 стандартын шатахууны хэрэглээ	13%	Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 15%-д хүрсэн байна.	<p>Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100% импортоор хангаж байгаа бөгөөд 2021.12.10-ны өдрийн байдлаар нийт 1.6 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс 1.4 сая.тонн шатахуун импортолсон байна. Үүнд: дизелийн түлш 902.9 мян.тонн, автобензин 516.3 мян.тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин 37233 тонн, дизелийн түлш 120019 тонн, нийт 157252 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 11 хувийг эзэлж байна. ОХУ-ын Роснефть компаниас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ литр тутамдаа 150-180 төгрөгөөр өндөр байна. Энэхүү үнийн зөрүүтэй холбоотойгоор Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээ дорвитой нэмэгдэхгүй байгаа болно. Иймд энэхүү үнийн зөрүүг арилгах зорилгоор автобензин, дизелийн түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахуунд ногдох онцгой албан татварыг экологийн бага ангиллын стандартын шатахуунаас тодорхой хувиар бага тогтоох эрх зүй, татварын орчин бүрдүүлэх шаардлага тулгарч байна. Энэ хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хуулийн төслийг боловсруулан 2021.02.04-ний өдрийн 01/291 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, чанар стандартын шаардлага хангахгүй шатахуун гарган авах зориулалтаар импортолж буй зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах замаар агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулахаар 2021.01.12-ны өдрийн 02/67 дугаар бичгээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо /ОББҮХ/-нд хүргүүлсэн. Дээрх асуудал ОББҮХ-ны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан ба тус чиглэлээр ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажиллаж байна.	
8.6	Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулна.	ТЭЗҮ-ээр тодорхойлог доно. Хувийн хэвшил	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ	0%	БОНБНҮ-г боловсруулж, батлуулсан байна. 10%	Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан.	100%
8.7	Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна.	-	Эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал	"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК, "Эрчис ойл" ХХК, "Эрдэнэс Метан" ХХК, "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ	Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, УИХ-д	ЗГХЭГ-ын дарга болон УУХҮСайд нарын 2021.02.26-ны өдрийн 16-А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэгт ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит "Эрчис Ойл" ХХК, "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ, "Эрдэнэс метан" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан УУХҮСайд 2021.03-р сард Төрийн өмчийн бодлого,	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

					хүргүүлэх 10%.	зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн.	
Зорилго 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2018 онд 75 хувь байгааг 2021 онд 81 хувьд хүргэнэ.							
1 Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна.							
1.1	Геологийн салбарт баримтлах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.	-	Үзэл баримтлалыг боловсруулсан эсэх 0- боловсруулаагүй 1-боловсруулсан	0	Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Засгийн газарт хүргүүлсэн байна	Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хийх үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчилэн байгуулах тухай УУХҮСайдын 2021.04.06-ны өдрийн тушаалаар байгуулсан. Газрын хэвлийн тухай хуулийн хэрэгцээ шаардлага болон өнөөдрийн эрх зүйн актад үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах судалгаануудыг Австрали-Монголын хамтын ажиллагааны АМЕР төслийн туслалцаатайгаар хууль эрх зүйчдийн 2 багийн хүчээр хийлгүүлж байна. УУХҮСайдын 2021.03.26-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсантай уялдуулан Газрын хэвлийн тухай хуулийн 4 зүйл, 8 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, 1 зүйлийг шинээр нэмэх санал, танилцуулгыг 2022.01.01-ний өдрөөс дагаж мөрдөх Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэхээр Ажлын хэсэгт 2021.06.07-нд хүргүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн 2021.09.27-ны өдөр цахимаар зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу ХЗДХЯ, СЯ-наас Засгийн газарт өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. ХЗДХЯ болон СЯ-наас УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авахаар хандсан бөгөөд ХЗДХЯ-нээс зохих зөвшөөрлийг авсан. Харин СЯ-нд 2021.10.06-ны өдрийн 01/2406, 2021.10.13-ны өдрийн 01/2460, 2021.11.09-ний өдрийн 01/2723, 2021.12.08-ны өдрийн 1/3038 дугаартай албан бичгээр тус тус хандсан боловч одоогоор УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг ирүүлээгүй бөгөөд УИХ-д тус хуулийн төслийг хууль тогтоомжийн дагуу өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Мөн УУХҮС-ын 2021. 05.04-ний өдрийн А/93 дугаар тушаалаар	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						байгуулагдсан “Дэд ажлын хэсэг”-ийн хүрээнд УУХҮС-ын 2021.03.16-ны өдрийн А/51 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийн төсөвт үзүүлэх үр нөлөөг судлах, холбогдох тооцоо судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийн байгуулан ажиллаж, холбогдох судалгаа, үнэлгээний тайланг зэргийг хийж гүйцэтгэсэн. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХСайд болон ССайдаар батлуулж, тус хуулийн төсөл болон дагалдан гарах Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж бусад яамдаас санал авахаар УУХҮСайдын 2021.11.11-ны өдрийн 01/2766 дугаартай албан бичиг хүргүүлж, саналын товъёог бэлтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Улмаар Хуулийн төслийн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр холбогдох материалыг хүргүүлээд байна.	
1.2.	Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга талаар нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой судалгаа хийх, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулна.	-	Боловсруулсан эсэх 0- боловсруулаагүй 1-боловсруулсан	0	1	УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2021 оны туршид дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д “хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх аргачлал”-ын дагуу Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан; 2.Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой болон бусад судалгааны тайлан; 3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал; 4.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; 5.Шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсантай холбогдуулан дагалдаж гарах хуулийн төслүүд; 6.Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгасан талаарх харьцуулсан судалгаа; 7.Одоогийн мөрдөж байгаа ашигт малтмалын тухай хуулиас шинэчилсэн найруулгад тусаагүй хасагдсан заалтын харьцуулалт, тайлбар; 8.Шинэчилсэн найруулгад шинээр зохицуулагдаж байгаа заалтын талаар мэдээллийг тус тус боловсруулсан.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						Ажлын хэсгээс хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн яамны удирдлагад 10 орчим удаа танилцуулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 91 дүгээр зүйл. Мэдээллийн сангийн хэлбэр, 92 дугаар зүйл. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангийн тогтолцоо, төрөл, 93 дугаар зүйл. Мэдээллийн сангийн бүрдэл, 94 дүгээр зүйл. Мета мэдээллийн сан, 95 дугаар зүйл. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг хэрэгжүүлэх байгууллага, хугацаа, 96 дугаар зүйл. Мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэг, 97 дугаар зүйл. Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөлтэй танилцаж, холбогдох саналыг жижиг ажлын хэсэгт хүргүүлсэн.	
1.3	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулна.	-	Боловсруулсан эсэх 0- боловсруулаагүй 1-боловсруулсан	0	1	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮСайдын 2020.11.02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2020 оны 8 дугаар сард Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалдаа нийцүүлэн боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу яамны цахим хуудас, “Нээлттэй нийгэм форум” болон “Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга” төслийн цахим хуудсанд тус тус байршуулж санал авч, хуулийн төслийн хэлэлцүүлгийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2020.10.06-ны өдөр зохион байгуулж, саналыг тусгасан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хуулийн төсөл, дагалдах хуулийн болон дүрэм, журам боловсруулах үүрэг бүхий олон улсын болон дотоодын зөвлөх 2020 оны 12 дугаар сараас ажиллаж, өмнө боловсруулсан хуулийн төсөлд тулгуурлаж шинэчилсэн хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулсан. Зөвлөхүүдийн ажилласан хуулийн төслийг 2021.04.05-нд Ажлын хэсэгт танилцуулсан. Ажлын хэсгийн гишүүд нь хуулийн төслийн бичвэрийг эцэслэн боловсруулсан.	100%
1.4	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж, батлуулна.	-	Гүйцэтгэл %	70%	100%	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг УИХ-ын чуулганаар шийдвэрлэсэн бөгөөд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Тус яамнаас боловсруулан 2019.03.20-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Бямбацогтын санаачилсан Үйлдвэрлэл, технологийн	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нэгтгэх Ажлын хэсэгт орж ажилласан. ҮТПЭЗБТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тайланг хийж гүйцэтгэсэн. Ажлын хэсэг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг баталсан бөгөөд одоо олон нийтийн хэлэлцүүлгийн шатандаа байна. Мөн хуулийн төсөлд Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн.	
1.5	Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулна.	50.0 сая	Гүйцэтгэл %	20%	100%	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасны дагуу Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж гүйцэтгэсэн. Хуулийн төслийн тандан судалгааны хүрээнд Аж үйлдвэрийг амжилттай хөгжүүлж байгаа гадаадын 10 гаруй орны сайн туршлагуудаас судалж хуулийн төсөлд тусгасан. -Хуулийн төслийн үзэл баримтлалыг УУХҮСайд, ХЗДХСайд хамтран 2021.03.09-ний өдөр баталсан. -Хуулийн төслийн талаар салбарын мэргэжлийн холбоод, их дээд сургууль, аж ахуйн нэгжүүд болон төрийн захиргааны төв байгууллагуудаас www.mmhi.gov.mn, www.mgram.gov.mn цахим хуудсаар 2021.02.18-ны өдрөөс 2021.03.17-ны өдрүүдэд санал авсан. - Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлэн дэмжигдэж, 2021.11.24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлээд байна.	100%
1.6	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.	-	Боловсруулсан эсэх 0- боловсруулаагүй 1-боловсруулсан	2014 оны Газрын тосны тухай хууль	1	Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮС-ын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс санал авахаар 2021.09.09-ний өдрийн 08/2198 дугаартай албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг судалгааны тайлангуудыг тус тус боловсруулсан. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.2 дахь хэсэгт нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал болон танилцуулгыг боловсруулсан.	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

1.7	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.	-	Боловсруулсан эсэх 0- боловсруулаагүй 1-боловсруулсан	2005 оны Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэн 2021.11.17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д яаралтай горимоор өргөн барих тухай 60 дугаар тогтоолыг гаргуулсан. Үүнтэй холбоотой УИХ-ын хэлэлцүүлэгт орох, ЭЗБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.	100%
1.8	Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна.	-	Батлуулсан эсэх 0-батлуулаагүй 1-батлуулсан	80%	1	Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийг ХЗДХЯ, СЯ, УУХҮЯ, АМГТГ, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг хамтран боловсруулж, Засгийн газрын 2020.12.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-ын чуулганаар нэн яаралтайгаар хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг 2021.01.29-ний өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.	100%
1.9	Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын дүрэм, журам, заавар, норм норматив, стандарт, аргачлал, маягыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулна.	-	Боловсруулж, нэмэлт өөрчлөлт, оруулсан дүрэм, журам, заавар, норм норматив, стандартын тоо	0	10	- УУХҮСайдын 2021.07.27-ний өдрийн А/195 дугаар тушаалаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээни актын улсын нэгдсэн санд 2021.08.05-ны өдрийн 5413 дугаарт бүртгүүлсэн. - “Үйлдвэрлэл /аж үйлдвэрийн салбар/-ийн технологийн түвшний үнэлгээ хийх, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.05.31-ний өдрийн “Санал авах тухай” 03/1381 дугаартай албан бичгээр ХХААЯ болон БШУЯ-нд хүргүүлсэн бөгөөд журмын төслийг 2021.06.02-ны өдөр УУХҮЯ-ны https://www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд 30 хоног байршуулсан. БШУЯ-ны ТНБДаргын 2021.06.21-ний өдрийн 2/3064, ХХААХҮЯ-ны ТНБДаргын 2021.06.17-ны өдрийн 01/1964 дугаартай албан бичгээр тус тус ирүүлсэн саналуудыг журмын төсөлд тусган Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу журмын төслүүдийн салбарын хэлэлцүүлгийг 2021.09.15-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт оролцсон аж ахуйн нэгж, их дээд сургууль ,эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллага, холбооны эрдэмтэн судлаач 20 гаруй төлөөлөлийн санал зөвлөмжийг журмын төсөлд тусган “Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам”-ын төслийн журмын нөлөөллийн шинжилгээг ХЗДХСайдын 2018 оны А/147 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-	100%

					<p>ын дагуу гүйцэтгэж, танилцуулгыг бэлтгэн баталгаажуулахаар 2021.11.24-ний өдөр ХХААХҮ-ийн яаманд хүргүүлсэн.</p> <p>- Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 7 дугаар зүйлийн 7.7-д тус тус заасны дагуу “Үйлдвэрлэл /аж үйлдвэрийн салбар/-ийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам болон технологийн түвшний үнэлгээ хийх, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалын төслүүдийг боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮСайдын 2020.11.04-ний өдрийн А/273 дугаар тушаалаар байгуулагдаж, журмын төслийг урьдчилсан байдлаар гарган ХХААЯ, БШУЯ-даас санал авч, төслийг УУХҮЯ-ны цахим хуудсанд http://mmhi.gov.mn/public/more/id/1412 60 хоног байршуулсан. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу журмын төслүүдийн салбарын хэлэлцүүлгийг 2021.09.15-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт оролцсон аж ахуйн нэгж, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллага холбооны эрдэмтэн судлаач 20 гаруй төлөөллийн санал зөвлөмжийг журмын төсөлд тусган “Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ыг БШУСайд, УУХҮСайд, ХХААХҮСайдын “Журам батлах тухай” 2021.11.08-ны өдрийн А/381 / А/274 / А-313 дугаар хамтарсан тушаалаар батлуулан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5553 дугаарт бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актыг УУХҮЯ-ны цахим хуудсанд байршуулсан.</p> <p>- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 128 дугаар тогтоолоор “Монгол Улсын нутаг дэвсгэрт эргэлтийг зөвшөөрөх, олон улсад бүртгэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон тэдгээрийн үндсэн түүхий эдийн жагсаалт”-ыг батлуулсан.</p> <p>- УУХҮСайд болон Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020.05.20-ны өдрийн А/102, А-177 дугаар хамтарсан тушаалд 2021.03.16-ны өдрийн А/52, А-82 дугаар тушаалаар “Алтны хөнгөлөлттэй санхүүжилт олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>- Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журамд УУХҮСайдын 2021.03.05-ны өдрийн А/45 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж, 2021.04.23-ны өдөр ХЗДХЯ-захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.</p>
--	--	--	--	--	---

					<p>- УУХҮЯ-наас 2020 онд зарласан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тендерт Хатандалай ХХКомпани шалгарч “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” баримт бичгийн талаар харьцуулсан судалгаа хийх, санал дүгнэлт, аргачлал боловсруулах судалгааны ажлын тайланг 2020.12.17-ны өдөр ирүүлснийг 2021.01.13-нд актаар хүлээн авсан. Дээрх ажлын бүрэлдэхүүн хэсэг болох Газрын тосны нөөц, баялгийн менежментийн систем буюу “Petroleum Resources Management System”-ийг хэрэглэх зааврыг тус компаниас хүлээн авсан. Журмын төслийг Хатандалай ХХК эхний байдлаар боловсруулж ирүүлсэн бөгөөд төслийг сайжруулж, үр нөлөөллийн үнэлгээ, хэлэлцүүлгийн саналын товчоог боловсруулж, шаардлагыг эцэслэн батлуулахаар ажиллаж байна.</p> <p>- Газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм боловсруулахтай холбогдуулан талаарх олон улсын туршлага, стандарт, дүрэм журмын талаар судалгаа хийж, санал, дүгнэлт боловсруулах тухай эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгүүлэх төсвийг УУХҮСайдын 2021 оны төсвийн багцад суулгасан. Шууд гэрээ байгуулах нөхцлөөр Эрхэс сувд компани тус ажлыг гүйцэтгэхээр шалгарч судалгааны ажлыг эхлүүлээд байна. Мөн Канадын Мерит төсөлтэй хамтран дүрэм боловсруулахтай холбогдуулан гадаад орнуудын ижил төстэй стандарт, журмуудыг харьцуулсан судалгааг хийж УУХҮЯ, АМГТГ, МХЕГ, гэрээлэгч ААН-тэй хамтран ажиллаж байна. Дүрмийн эхний хувилбарыг боловсруулж, 2021.12.23-24-ний өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулахаар ажиллаж байна.</p> <p>- Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан тус хуулийн 3.3 дахь хэсэгт заасан “Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2021.04.13-ны өдрийн А/75 дугаар тушаалаар байгуулж журмын төслийг боловсруулж ЗГ-ын 2021.08.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 241 дүгээр тогтоолоор батлуулсан.</p> <p>- УУХҮСайдын 2020 оны А/321 дүгээр тушаалаар байгуулагдсан Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулах арга</p>
--	--	--	--	--	---

					<p>хэмжээний төлөвлөгөө боловсруулж Ажлын хэсгийн хуралдааныг цахимаар зохион байгуулж, журмын нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал авах тухай ТНБДаргын 2021.02.09-ний өдрийн 03/325 дугаар албан бичгийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Тус байгууллагаас 2021.02.24-ний өдрийн 1/150 дугаар албан бичгээр ирсэн саналын дагуу Ажлын хэсэг хуралдсан. Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмын шинэчилсэн найруулгын төслийг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа шинэчилэн найруулах нь зүйтэй байна гэсний дагуу Ажлын хэсэг дэмжиж дүгнэлт гаргасан.</p> <p>- Нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (мөнгө, цагаан тугалга, хар тугалга-цайр, вольфрам, молибден)-ийг ХБНГУлсын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн буюу BGR-ийн “Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь институцын болон боловсон хүчний чадавхийг хөгжүүлэх-II” төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ГУУС-ийн Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл, сургалтын төвийн эрдэмтэн, судлаачдаар гүйцэтгүүлж геологичдын дунд олон нийтийн хэлэлцүүлгийг 2021.01.14-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021.04.30-ны өдрийн ХХ-05 дугаар хуралдаанаар мөнгө, цагаан тугалга, хар тугалга-цайр, вольфрам, молибденийн аргачилсан зөвлөмжийг хэлэлцүүлж ХХ-05-01-ХХ-05-05 дугаар зөвлөмж гарсан. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.06.11-ний өдрийн А/153 дугаар тушаал батлагдсан.</p> <p>- Бал чулуу, давс, карбонат чулуулаг, хөнгөн цагаан, лити-цези, элс хайрга, газрын ховор элементийн аргачилсан зөвлөмжийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021.06.03-ны өдрийн ХХ-07 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.07.09-ний өдрийн А/190 дугаар тушаал батлагдсан. Нийт гарсан Боть-2, 3-ыг товхимол болгон хэвлүүлж, 1000%-ийг геологичдын хүртээл болгосон.</p> <p>- Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр АМЕР-II-ын санхүүжилтээр фосфат, манган, берилли, никель-кобальт, хромын хайгуулын ажилд</p>
--	--	--	--	--	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>хэрэглэх аргачилсан зөвлөмжийн төслийг 2021 оны 10 дугаар сараас эхлүүлсэн ба салбарын эрдэмтдийн оролцоотойгоор боловсруулж эхлээд байна.</p> <p>- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төсөлд санал авах тухай УУХҮСайдын 2021.04.08-ны өдрийн 01/911 дугаар албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн, УУХҮСайдын 2021.04.29-ний өдрийн 01/1130 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-аас 2021.05.12-ны өдрийн ХЭГ/1287 дугаартай албан бичгээр Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлгийг зохион байгуулж дахин ирүүлэхээр материалыг буцаасан. ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2021.05.07, 2021.06.04-ний өдрүүдэд Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг АМГТГ-ын 301 тоот өрөөнд 2 удаа зохион байгуулаад байна. Журмын төслийн 2 удаагийн хэлэлцүүлэгт 18 аж ахуйн нэгжийн 48 хүн оролцож санал ирүүлсэн бөгөөд саналыг судлан холбогдох өөрчлөлтийг гүйцэтгэж ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлтгэж байна.</p>	
<p>Зорилго 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2018 онд 75 хувь байгааг 2021 онд 81 хувьд хүргэнэ.</p>							
1	Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.						
1.1	Цар тахлын үед салбарын үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор халдвар хамгааллын дэглэмийг хатуу чанд мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлнэ.	-	Зөвлөмж хүргүүлсэн эсэх 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн	0	1	<p>Хүнд үйлдвэрийн салбараас Коронавируст халдвар (SARS-CoV-2)-ын эсрэг вакцинжуулалтад хамрагдах ААНБ-ын жагсаалтыг шинэчлэн гаргаж яамны Шуурхай штабт цахимаар 2021.03.18-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>Мөн Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн өдрүүдэд ажиллах хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг нэгтгэн боловсруулж яамны Шуурхай штабт хүргүүлэв.</p>	100%
1.2	Валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн ханшийг тогтворжуулах хүрээнд алтны үйлдвэрлэлд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.	-	УУХҮСайд, Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2020 оны А/102, А-177 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журмын	110.0 тэрбум төгрөг	150.0 тэрбум төгрөг	<p>УУХҮСайд, Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020.05.20-ны өдрийн А/102, А-177 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Алт-2” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор олгох хөнгөлөлттэй санхүүжилтийн түр журам”-д 2021.03.16-ны өдрийн А/52, А-82 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>Энэхүү журмаар 6 хүртэлх сар буюу богино хугацаатай зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийг энэ он дуустал</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

			хэрэгжилтийг хангасан эсэх 0-Хангаагүй, 1-Хангасан			сунгаж, урт хугацаат зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийг 24 сар хүртэл байсныг 36 сар хүртэл болгон өөрчилсөн. Улмаар УУХҮСайд, Монголбанкны ерөнхийлөгч нарын 2020.05.20-ны өдрийн А/102, А-177 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Алт-2” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор олгох хөнгөлөлттэй санхүүжилтийн түр журам”-д 2021.03.16-ны өдрийн А/52, А-82 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан журмын 6.1-д заасны дагуу тус яамнаас уулын ажил гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийг хангасан нийт 94 алт олборлогч аж ахуйн нэгжийн жагсаалтыг Монголбанканд хүргүүлсэн. 2021.12.31-ний өдрийн байдлаар 25.3 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг 5 аж ахуйн нэгж, 309.7 тэрбум төгрөгийн урт хугацаат төлбөрийн санхүүжилтийг 13 аж ахуйн нэгжүүдэд тус тус авсан байна.	
1.3	Нүүрсний экспортыг эрчимжүүлэх хүрээнд Монгол Улс, БНХАУ-ын “Ногоон гарц журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд ажлыг зохион байгуулна.	-	Нүүрс тээврийн жолооч нарыг БНХАУ-ын талын тусгаарлалтын бүсэд байршуулж, хонуулах ажлыг зохион байгуулсан эсэх 0-Зохион байгуулаагүй 1-Зохион байгуулсан	0	1	Монгол-Хятадын хилийн бүсийн “Ногоон гарц” түр журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх санал хүргүүлэх тухай УУХҮСайдын 2021.02.16-ны өдрийн 01/373 дугаар албан бичгийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Үүний дүнд Ховд аймгийн нутаг дэвсгэрт орших Булган боомтыг амралтын өдрүүдэд ажиллуулж хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Мөн нүүрс тээврийн жолооч нарыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг дархлаажуулалт болох вакцинжуулалтад хамруулах ажлыг 2021.03.18-ны өдрөөс эхлүүлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн жолооч нарыг нэн түрүүнд вакцинд хамруулах шийдвэрийг Эрүүл мэндийн яамнаас гаргуулан Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт 11000 вакцины тун хүргүүлснээр Гашуун сухайт боомтын 5449, Оюутолгойн тээврийн 200, Шивээ хүрэн боомтын 1658, нийт 7307 тээврийн жолооч, тээвэр хариуцсан ажилчдыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг вакцинд хамруулсан болно.	100%
1.4	Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх хүрээнд хилийн Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.		Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан эсэх	0	1	Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомтод нүүрсний чингэлэгт тээврийн хяналтын нэмэлт гарц байгуулах тухай тогтоолын төслийг Засгийн газрын 2020.12.30-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор батлуулсан. Улмаар Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомтод нүүрсний чингэлэгт тээврийн хяналтын нэмэлт гарцыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулж, Хил хамгаалах ерөнхий газарт	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

			0-Зохион байгуулаагүй 1-Зохион байгуулсан			<p>үнэ төлбөргүй шилжүүлэх тухай Монголын Алт (МАК) ХХК-ийн 2020 оны 02/1041 дүгээр албан бичгийн дагуу “Хяналтын нэмэлт гарц барьж хүлээлгэн өгөх тухай гэрээ”-ний төслийг УУХҮСайдын 2021.02.19-ний өдрийн 01/390 дүгээр албан бичгээр Хил хамгаалах газар, Монголын Алт (МАК) ХХК-иудад хүргүүлж, 2021.03.29-ний өдөр гэрээ байгуулсан.</p> <p>Шивээхүрэн боомтод баригдаж байгаа нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарцыг ашиглалтад оруулах ажилтай зэрэгцэн цаг алдалгүй гаалийн хяналтын бүс байгуулах ажлын зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч Засгийн газрын 2020.04.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу дахин танилцуулахаар тогтсон.</p> <p>Засгийн газрын 2021.07.02-ны өдрийн 185 дугаар тогтоолоор хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах үүргийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан.</p> <p>Энэ асуудлын хүрээнд нүүрсний экспортын 95 орчим хувийг бүрдүүлдэг хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Гашуунсухайт боомтод чингэлэгт тээврийн терминал байгуулах ажлыг “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-иудын хөрөнгөөр гүйцэтгэж, ашиглалтад оруулсан бол Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах ажлыг нийт 8 аж ахуйн нэгж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 80 хувьтай байна.</p>	
1.5	Уурхайн ажилчдын ээлж солилцох түр журмыг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн яам, Эрүүл мэндийн яамдуудтай хамтран баталж, хэрэгжилтийг хангана.	-	Уурхайн ажилчдын ээлж солилцох түр журмыг боловсруулж батлуулсан эсэх 0-Батлуулаагүй 1-Батлуулсан.	0	1	<p>УУХҮСайд, ЭМСайд, ЗТХСайдын хамтарсан тушаалаар “Ажилтнуудын ээлж солилцож, шилжилт хөдөлгөөн хийх үйл ажиллагаанд баримтлах түр журам”-ыг 2020.12.30-ны өдөр баталж, уурхайнууд болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчид, тээвэрлэгчид, харуул хамгаалалтын гэрээт аж ахуйн нэгжүүдийн ажилчдын ээлж солилтыг 2020 оны 12 сараас эхлэн нэгдсэн зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.</p> <p>Мөн Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 48 дугаар тушаал, Хилийн боомтын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолын дагуу Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар, хамгааллын дэглэмийг</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						сахиулах, боомтын аюулгүй байдлыг хангуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч, холбогдох зохион байгуулалтаар ханган ажиллах чиг үүрэг бүхий Шуурхай бүрэлдэхүүнд орж, тухай бүр Өмнөговь аймагт томилолтоор ажилласан.	
1.6	Тавантолгой, Нарийнсухайт, Айлбаян, Ерөө-Хүдрийн бүлэг ордод нэгдсэн байдлаар, Оюутолгой, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөшөөт, Таяннуур, Улаан, Төмөртийн овоо, Багануур, Шивээ-Овоо, Адуунчулуун, Шарын голын уурхай, газрын тосны Зүүнбаян, Тосон уул, Тамсагийн орд тус бүрт халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүсийг байгуулах ажлыг зохион байгуулах хүрээнд хөдөө, орон нутагт томилолтоор ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	20.0 сая төгрөг	Хөдөө орон нутагт томилолтоор ажилласан эсэх 0-Ажиллаагүй 1-Ажилласан	0	1	Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоол, УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.02.10-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Тавантолгой, Нарийнсухайт, Оюутолгой, Дорноговь аймгийн Айлбаянгийн ордуудад тус бүрт халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах Аюулгүйн тусгай бүсийг байгуулах ажлыг зохион байгуулах хүрээнд хөдөө, орон нутагт томилолтоор ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Өмнөговь аймгийн нутагт орших Оюутолгой, Тавантолгой, Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто зам, Цагаан хадны гаалийн хяналтын бүс, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн авто зам, хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын 38 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2021.05.01-ний өдрөөс 2021.05.07-ны өдөр хүртэл томилолтоор ажилласан.	100%
2.	Геологийн салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.						
2.1.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг тогтоох асуудлыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төслийг хүргүүлнэ.	-	Ордуудын хил заагийг тогтоож хүргүүлсэн эсэх. 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн	8	Ордуудын хил заагийг тогтоож Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төслийг хүргүүлсэн байна.	Стратегийн ач холбогдол бүхий 7 ордын материалыг бүрдүүлж, судалж байна. Энэхүү 7 ордын материалд дүн шинжилгээ хийж, талбайн хил зааг тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлохоор ажиллаж байна. Ордуудын талбайн хил заагийг тогтоох саналыг бэлтгэж эхэлсэн.	70%
2.2.	Төрөөс тогтоосон газарт хайгуулын	-	Засгийн газрын хуралдаанаар	0	Засгийн газрын	АМГТГ-аас Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн сонгон	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	тусгай зөвшөөрөл олгох талбайн хил, заагийг тогтоох асуудлыг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төслийг хүргүүлнэ.		хэлэлцүүлэхээр төслийг хүргүүлсэн эсэх 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн		хуралдаанаар хэлэлцүүлэхээр төслийг хүргүүлсэн байна.	шалгаруулалтаар олгох нийт талбайгаас 3.5 сая гектар талбайг хасаж, хэтийн төлөв бүхий улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуулын шатны ажил хийгдсэн эрдсийн хуримтлалтай 2.3 сая гектар талбайг нэмж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх тухай ТНБДаргын 2021.04.29-ний өдрийн 03/1133 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын шинэчилсэн найруулгатай холбогдуулан Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох талбайн хил заагийг 2022 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна.	
2.3.	Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хөтөлбөрийн биелэлт 50%-д хүрсэн байна.	30%	Хөтөлбөрийн биелэлт 50%-д хүрсэн байна.	<p>1. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 91 дүгээр зүйл. Мэдээллийн сангийн хэлбэр, 92 дугаар зүйл. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангийн тогтолцоо, төрөл, 93 дугаар зүйл. Мэдээллийн сангийн бүрдэл, 94 дүгээр зүйл. Мета мэдээллийн сан, 95 дугаар зүйл. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг хэрэгжүүлэх байгууллага, хугацаа, 96 дугаар зүйл. Мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэг, 97 дугаар зүйл. Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөлтэй танилцаж, холбогдох саналыг жижиг ажлын хэсэгт хүргүүлсэн.</p> <p>2. Үндэсний геомэдээллийн сан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу олон улсын жишигт нийцсэн геомэдээллийн санг бий болгох асуудлын хүрээнд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хийж, хэрэгжүүлсэн ажлыг танилцуулах хуралдааныг зохион байгуулсан. Энэ хүрээнд ҮГМС-ийн портал болох www.mgis.mn нүүр хуудасны туршилтын загварыг боловсруулж, холбогдох саналыг авч, сайжруулалт хийж, ҮГА-ны веб сервер дээр www.mgis.mn нууцлал хамгаалал (SSL certificate) хийсэн. Веб сервэр тохируулга хийгдэн ажиллаж байна.</p> <p>3. Хөтөлбөрийн хүрээнд ҮГА-д PaloAlto 820 төхөөрөмжийг суурилуулж ашиглалтын лицензийг идэвхжүүлэн хамгаалалтын болон сүлжээний удирдлага, НА горим, LDAP, Global Portal, DHCP, Security Policy, NAT, DNS АМГТГ-тай холбогдох VPN гэх мэт тохируулгыг хийн программ хангамжийн хувилбарыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр шинэчилсэн.</p> <p>4. 2021 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Геомэдээллийн сангийн сэдэвчилсэн судалгааны ажлуудын үр дүнд үүссэн мэдээлэл, баримтад тулгуурлан үүсгэх “Геологийн баримт-1”,</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>Геомэдээллийн сангийн сэдэвчилсэн судалгааны ажлуудын үр дүнд үүссэн мэдээлэл, баримтад тулгуурлан үүсгэх “Чулуун дээжийн сан-1”, Геологийн баримтын төв архивын эрэл хайлтын дотоод программыг 2021-2023 онуудад сайжруулах, цахим үйлчилгээг нэвтрүүлэх төслийн геологийн даалгаварт холбогдох саналыг өгсөн. Эдгээр төслүүд нь 2022 оноос хэрэгжихээр болсон.</p> <p>5.Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу биелэлтийг 2021.03.05-ны өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн. Хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Засгийн газрын 2021.10.13-ны өдрийн хуралдаанаар “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” асуудал танилцуулагдаж, Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөр хүчингүй болсон.</p> <p>Засгийн газрын 2021.10.13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон салбарын бодлого, төлөвлөлттэй холбоотой Засгийн газрын тогтоолд хийх үр дүнд суурилсан эцсийн үнэлгээний тайланд Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг тусган ХШҮДАГ-т 2021.11.16-ний өдөр хүргүүлсэн.</p>	
2.4.	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх бүх төрлийн геологийн судалгааны ажлын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, дүн шинжилгээ хийж тайлагнана.	-	Геологийн судалгааны ажлын хэрэгжилт 0-Хэрэгжүүлээгүй 1-Хэрэгжүүлсэн	0	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.	2021 онд хэрэгжих 53 төслөөс шинээр эхлэх 15 төслийн геологийн даалгаврыг 03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.03.19-ний өдөр зарласан шалгаруулалтын ажлаас 11 төслийн гүйцэтгэгч шалгарсан бөгөөд зөвлөх үйлчилгээний 14-17, 19-21, 23-25 дугаар гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. Төлөвлөгөөт онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 38 судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөний тодотголтой танилцан 03.25-03.29-нд ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн. Дээрх 38 төслийн 1-10 дугаар сарын ажлын гүйцэтгэлийг ҮГА-аас ирүүлсэн. Мөн Үндэсний Геологийн албанаас 2020 онд гүйцэтгэсэн 52 төслийн жилийн тайланг нэгтгэн 2021.01.08-нд ирүүлсэн. 2021 онд үр дүнгийн тайлантай 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 9 төслийн үр дүнг хүлээн авснаар нутаг дэвсгэрийн геологийн тогтоцыг судлан зураглаж, ашигт малтмалын тархалт, хэтийн төлөвийг тодорхойлж, металл болон металл бус ашигт малтмалын хувирсан бүс, эрдэсжсэн цэг, илрэлийг тогтоосон байна.	100%
			Хээрийн ажлын анхдагч материалыг хүлээн авсан эсэх: 0-аваагүй		7 төслийн суурин боловсруулалтын ажилтай танилцсан байна.	Чулуун хороот-50, Түдэвтэй-50, Дэвийн хонгор уул-50, Модот толгой-50, Бүрхтэй уул-50, Асгат уул-50, ГАСАМ төслийн суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тооцоололтой танилцан 2021.03.25, 03.29-ний өдрийн ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

			1-авсан			Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 12 (1:50000-ны масштабын ГЗЕЭА-ын 11, ашигт малтмалын эрэл үнэлгээний 1 төслийн хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 11.08-11.29-ний өдрүүдэд хүлээн авсан.	
			Батлуусан эсэх: 0-батлуулаагүй 1-батлуулсан		Төсөв, төлөвлөгөөг батлуулсан байна.	Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих: -1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн үр дүнгийн тайлан зохиох 6, хээрийн судалгааны ажилтай 23, шинээр эхлэх 4, -Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох 2, -Сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан зохиох 1, хээрийн судалгааны ажилтай 6, шинээр эхлэх 7, -Геологийн мэдээллийн сангийн чиглэлээр эхлэх 3, -Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр эхлэх 1, нийт 53 төслийн ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг ТНБДаргын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан.	100%
			Хээрийн ажлын анхдагч материалыг хүлээн авсан эсэх: 0-аваагүй 1-авсан		4 төслийн хээрийн ажилд шуурхай хяналт хийсэн байна.	Дэлхий нийтийг хамарсан Ковид-2019 цар тахлын тархалт, хөл хорио, вакцинжуулалтаас хамаарч 2021.05.20-ноос эхлэн геологийн судалгааны хээрийн ажил эхэлсэн. Төлөвлөгөөт оны 2-р улирлын сүүлийн сард төлөвлөсөн хээрийн шуурхай хяналтын ажлыг Хулд-50, Алагбаян-50, Халзан-Овоо-50, Борзонгийн говь-50 төслүүдийн хээрийн судалгааны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан 9 сард хийж, ажлын явцыг шалган, зөвлөгөө, зөвлөмжөөр ханган ажилласан. Дээрх төслүүдийн хээрийн судалгааны ажлыг 11дүгээр сард хүлээн авсан.	70%
3.	Уул уурхайн салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.						
3.1.	1.УУХҮЯамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн орд ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна. 2.ЭБМЗ-ийн боловсруулах үйлдвэрийн салбар хуралдааныг зохион байгуулах	-	Зохион байгуулсан хурлын тоо	2020 онд 13 удаагийн хурлыг зохион байгуулсан.	16 удаагийн хурлыг зохион байгуулах	Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлыг 2021 оны 01 дүгээр сараас эхлэн цахим хэлбэрээр 17 удаа зохион байгуулж 216 асуудлыг хэлэлцэж, 193 техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан. УУХҮСайдын 2020 оны А/239 дүгээр тушаалаар байгуулагдсан ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны дарга О.Чулуун, гишүүд Х.Баярхангай, Х.Санчигдорж, М.Нямсүрэн, М.Энхжаргал, С.Батмөнх, Я.Ариунчимэг, Д.Оюун, Г.Сэрсмаа, Д.Отгонбаатар, Д.Цэдэнбалжир, Ж.Тогтох, Ч.Төмөрчөдөр, Б.Дэлгэрцогт, А.Готовсүрэн, н.б.д Ч.Бямбажав гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>Шинээр байгуулагдсан ЭБМЗ-ийн салбар хуралдааны гишүүд 2021.03.03-ны өдөр Үндэсний геологийн албанд хуралдаж дараах асуудалд санал нэгдсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. УТХ-өөр хэрэгжүүлж байгаа ГСА-ын төсөл, төсвийн тодотголын хуралдааныг цахимаар зохион байгуулах, 2. Үр дүнгийн тайлан хэлэлцэх хуралдааныг ажлын хэмжээ, ач холбогдлыг нь харгалзан үзэж биечлэн хэлэлцэх, шинжээчид, тайлан зохиогчид нь биечлэн хуралдаанд оролцох, 3. Геологийн судалгааны ажлын геологийн даалгавраас зөрүүтэй төсөл тендерт шалгарч, гэрээ байгуулж байгаа тул энэ талаар тусдаа хуралдаж зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад саналаа уламжлах. <p>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журамд заасан хугацааны дагуу тус салбар хуралдаанаар 2021 онд нийт 38 төслийн 2021 оны төсөл, төсвийн тодотголыг 2021.03.24, 25, 26, 29-ний өдрүүдэд хэлэлцсэн. Нийт 38 төслийг хэлэлцсэн талаарх ЭБМЗ-ийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг боловсруулж албажуулсан. Үүний дагуу төсөл тус бүрээр УУХҮСайдын А/104-А/141 дугаартай тушаалыг 2021.05.20-ны өдөр батлуулсан.</p> <p>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх УТХ-2021-05 дугаар хуралдаанаар 3, УТХ-2021-06 дугаар хуралдаанаар 2, УТХ-2021-07 дугаар хуралдаанаар 3, УТХ-2021-08 дугаар хуралдаанаар 3, УТХ-2021-09 дугаар хуралдаанаар 4 үр дүнгийн тайлан хэлэлцэж, нийт геологийн судалгааны ажлын 15 үр дүнгийн тайлан хэлэлцэж УУХҮСайдын тушаалыг албажуулсан.</p>	
3.2.	“Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв”-ийн барилгын засвар, газрын доорх малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэнэ.	1.7 тэрбум төг	Барилгын засвар, газрын доорх малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэсэн эсэх 0 – Гүйцэтгээгүй 1 – Гүйцэтгэсэн	3.2 тэрбум төг	4.9 тэрбум төгрөг	<p>Төсөл, арга хэмжээний сургалт, судалгааны төвийн барилгын засвар өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг “Хөх майдар” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд гэрээт ажлыг 2021.06.15-ны өдөр хүлээн авахаар ажиллаж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021.11.29-ний А/287 дугаар тушаалаар “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв /Хэнтий, Батноров Сум, Бэрх тосгон/” төсөл, арга хэмжээний газрын доор малталт, нэвтрэлтийн ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж, хүлээн авах үүрэг бүхий Комисс томилогдсон. Тус комиссын Нарийн бичгийн даргаар ажиллаж гарын доор малталт, нэвтрэлтийн ажил гүйцэтгэх гэрээт ажлыг дүгнэн акт үйлдэж хүлээн авсан.</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

3.3	Уурхай, уулын болон баяжуулах 20 үйлдвэрүүдийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж уурхай үйлдвэрийг ашиглалтад оруулна.	-	Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг байнгын ашиглалтад хүлээн авсан тоо	2020 онд 104	144 (20)	“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах түр заавар”-ын төслийг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.02.08-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулсан. 2021.12.31-ний өдрийн байдлаар нийт 39 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулсан байна.	100%
4 Газрын тосны салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.							
4.1	Газрын тосной үйл ажиллагаанд холбогдох байгууллагатай хамтран шалгалт хийнэ.	-	Хяналт, шалгалтын тоо	1	2	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 8 гэрээлэгч, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй 3 гэрээлэгчийн БХГ-ний хэрэгжилт, 2020 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан болон 2021 оны ажлын төлөвлөгөө, төсвийг хэлэлцэх жилийн уулзалтад оролцож, БХГ-ний хэрэгжилт, ажлын тайлан, жилийн төлөвлөгөө төсөвт санал өгч тусгуулсан. Газрын тухай хууль, БХГ болон тусгай зөвшөөрлөөр хүлээсэн үүргээ биелүүлээгүй газрын хайгуулын Хар-Ус II, Номгон IX, Хөхнуур XVIII, Дарьганга XXIV, Хэрлэнтохой XXVIII талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу дүгнэх, хяналт шалгалт хийх ажлыг холбогдох байгууллагуудтай зохион байгуулж, тайлан дүгнэлтийг боловсруулаад байна. Мөн газрын тосны хайгуулын Эргэл XII талбайн гэрээлэгч Смарт ойл ХХК-ийн гадаадаас ажиллах хүч авах тухай хүсэлт, Галба XI талбайн гэрээлэгч Зон Хэн Юу Тиан ХХК-ийн тусгай зөвшөөрөл сунгах хүсэлттэй холбогдуулан Газрын тосны тухай хууль, БХГ-ний хэрэгжилтийн байдалд хяналт, шалгалт хийж, ГТ-ны тухай хуулийн 11 зүйлийн 11.2.9 заалтын хэрэгжилтийг хангуулсан. Газрын тосны хайгуулын Матад XX талбай ашиглалтад шилжиж байгаатай холбогдуулан газрын тосны тухай хууль, журмын холбогдох заалтын дагуу УУХҮСайд, БОАЖСайд нарын 2021.09.30-ны өдрийн А/253, А/309 дугаар тушаалаар байгуулагдсан газрын тосны хайгуулын Матад XX талбайн зарим хэсгийг буцаан авахад дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг Гэрээлэгчийн газрын тосны тухай хууль, БХГ, Байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт, шалгалт хийж, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг боловсруулж байна.	100%
4.2	Газрын тосны хайгуулын талбайд	-	Нээлттэй сонгон шалгаруулалт	0	1	Нээлттэй сонгон шалгаруулалт зарлаагүй. Газрын тосны тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу эрлийн гэрээнээс	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	нээлттэй сонгон шалгаруулалт зарлана.		зарласан талбайн тоо			Нүүрсний давхаргын метан хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах 1 талбай зарлагдаж 2021.07.27-ны өдөр Гурвантэс ХХХV талбайд БХГ байгуулсан.	
4.3	Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавина.	-	Засгийн газрын 2020.10.07-ны өдрийн 136 дугаар тогтоол	120350 тонн	120350 тонн	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 136 дугаар тогтоолоор нэр бүхий аж ахуй нэгжүүдэд 30 хоногийн хэрэглээний буюу 120350 тн (А-80-4800 тн, АИ-92-38800 тн, ДТ-74200 тн, ТС-1 2550 тн) шатахуун бүрдүүлэхийг даалгасан. Улсын хэмжээнд 2021.12.06-ны өдрийн байдлаар шатахууны ердийн хэрэглээний 28 хоногийн буюу 113.1 мянган тонн бүтээгдэхүүний нөөцтэй байна. Үүнээс А-80 автобензин 7260 тонн буюу 45 хоног, Аи-92 автобензин 46162 тонн буюу 39 хоног, дизелийн түлш 53585 тонн буюу 22 хоног, ТС-1 онгоцны түлш 1902 тонн буюу 22 хоногийн нөөцтэй байна. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заасны дагуу “Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2022 онд бүрдүүлэх компанийн нөөц”-ийн тогтоолын төсөл, танилцуулгыг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2021.10.06-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах талаар компанийн нөөц бүрдүүлэх тогтоолын хавсралтад хамрагдсан бүх ААН-үүдэд газрын даргын 2021.10.28-ны өдрийн 08/2603 дугаар албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Нөөц бүрдүүлэлтэд АМГТГ-тай хамтран тухай бүр хяналт тавин ажиллаж байна.	100%
4.4	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан шатахууны жижиглэн борлуулалтын үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулна.	-	Шатахууны үнийн хэлбэлзлийн хувь	3%	10%	2020 онд өргөн хэрэглээний АИ-92 автобензиний жижиглэнгийн үнийг тогтворжуулахтай холбогдуулан Төрийн өмчит “Эрчис ойл” ХХК болон шатахууны импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч 17 аж ахуйн нэгжүүдийн хооронд санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглан дотоодод борлуулах шатахууны үнийг тогтворжуулах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан. Үүний хүрээнд АИ-92 автобензиний жижиглэн борлуулалтын үнийг 2021.07.01-ний өдөр хүртэл хугацаанд 1450 төгрөгөөр тогтворжуулсан. Тодорхой хүчин зүйлүүдийн нөлөөллөөр дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тасралтгүй өссөн бөгөөд үүнийг дагаад ОХУ-аас манай улсад нийлүүлж буй газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ сар бүр нэмэгдэж ирсэн. Иймд Засгийн газрын 2020 оны 232 дугаар тогтоолоор байгуулагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн	90%

						байгууллагуудын хамтарсан зөвлөл"-ийн 2021.11.22-ны өдрийн анхдугаар хуралдаанаар шатахууны үнийн асуудлыг хэлэлцсэн бөгөөд АИ-92 автобензиний жижиглэнгийн үнийг 6 сарын хөдөлгөөнт дундаж үнээр тооцон сар бүр өөрчлөлтийг оруулах, аажмаар үнийг зах зээлийн горимд шилжүүлэх тухай зөвлөмжийг гаргасан. АМГТГ-тай хамтран шатахууны үнэ, холбогдох тооцоо, судалгааг тухай бүр хийж хяналт тавьж ажиллаж байна.	
5	Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.						
5.1	Гадаргын усыг ашиглах төсөл хэрэгжих хүртэл Таван толгойн нүүрсний ордыг газар доорх усаар хангах ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан эсэх 0-зохион байгуулаагүй 1-зохион байгуулсан	0	1	УУХҮСайд аймгуудын засаг дарга нартай байгуулах гэрээний төсөлд эрхлэх асуудлын хүрээнд “Эрдэнэс тавантолгой” ХХК-ийн барьж байгуулах нүүрс угаах үйлдвэр /дэд бүтцийн төслүүд/-ийн усны хэрэгцээг гадаргын усны төсөл хэрэгжих хүртэлх хугацаанд Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усаар хангах асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах тухай санал боловсруулж гэрээнд тусгасан. - Тавантолгойн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн бүтээн байгуулалт /нүүрс угаах үйлдвэр, кокс-эрчим хүчний үйлдвэр/-д шаардлагатай 220 л/с усыг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос хангах асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Тавантолгойн үйлдвэрлэл технологийн паркийн ус хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулсан. - Тавантолгойн нүүрсний ордод түшиглэн байгуулагдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр БОАЖЯ-ны байр суурийг сонсох, харилцан мэдээлэл, санал солилцож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох уулзалтыг УУХҮСайд Г.Ёндон, Усны газрын дарга Ш.Мягмар, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, Дэлхийн банкны “2030 Усны нөөцийн бүлэг”-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Д.Доржсүрэн болон бусад холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2021.04.03-ны өдөр зохион байгуулсан. - Тавантолгойн нүүрсний ордод түшиглэн байгуулагдах Нүүрс баяжуулах үйлдвэрт шаардлагатай усны хэрэгцээг “Загийн усны хоолой” газрын доорх усны ордоос хангах шугам, хоолой татах барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн 2022 оны төсөвт 72.3 тэрбум төгрөгийг тусгасан. Мөн компанийн зүгээс усны нөөц ашиглахад	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						шаардлагатай дүгнэлт, зөвшөөрлийг БОАЖЯ-ны “Монгол Ус” ТӨҮГ, Галба өөш – Долоодын говийн сав газрын захиргаа зэрэг байгууллагуудаас авсан ба Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос Тавантолгой уурхай хүртэл 70 км шугам хоолой татах трассыг баталгаажуулан захирамж гарган, ус хангамжийн системийг цахилгаанаар хангах техникийн нөхцөлийг ЭХЯ болон Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-иар гаргуулаад байна.	
5.2	Салбарын үйлдвэрүүдэд шаардлагатай мэргэжлийн инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэй ажиллах хүчний судалгааг гаргана.	-	Судалгаа хийгдсэн эсэх 0-хийгдээгүй 1-хийгдсэн	0	1	УУХҮСайдын 2020.10.19-ний өдрийн А/260 дугаар тушаалаар Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн нэр, индексийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хүрээнд Хүнд үйлдвэрийн салбарын боловсон хүчний тоо болон шаардлагатай байгаа мэргэжлийн инженер, техникийн ажилтнуудын судалгааг гаргахаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. ААНБ-ын боловсон хүчний тоог гаргах ажлын хүрээнд: Судалгаанд 72 аж ахуй нэгж байгууллагын 4963 хүн ажиллаж байна гэсэн урьдчилсан тооцоо гарсан. Үүнээс удирдах болон инженер мэргэжилтэй 678 хүн, технологийн 2619 хүн, туслах болон бусад ажил үүрэг гүйцэтгэдэг 1666 хүн байна. 2. Шинээр боловсон хүчин бэлтгэхэд шаардлагатай ажил, мэргэжлийн нэр, индексийг гаргах ажлын хүрээнд: Хүнд үйлдвэрийн салбарт 2021-2025 онд байгуулагдах нийт 9 төсөлд шаардлагатай боловсон хүчний мэдээллийг холбогдох төсөл хэрэгжүүлэгчдээс авч нэгтгэн боловсруулж урьдчилсан байдлаар гаргасан ба томоохон ААНБ-уудаас албан бичгээр санал авч боловсруулалт хийн дүгнэлт гаргасан. Үүнд: ААНБ-аас давхардсан тоогоор нийт 112 ажил мэргэжлийн санал ирснээс 80 ажил, мэргэжлийн ангиллыг багцалж, мэргэжлийн нэр, нэршил, индекс, үндсэн үүрэг, тодорхойлолт, хууль эрх зүйн болон нийгэм эдийн засгийн үндэслэл бүхий мэдээллийг бэлтгэсэн.	100%
6	Геологи, уул уурхай хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.						
6.1	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.	-	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	33	40	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг 8 удаа зохион байгуулж тусгай зөвшөөрлийн 37 асуудлыг хэлэлцэж, 34 асуудлыг шийдвэрлэсэн.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

6.2	Хүнд үйлдвэрийн салбарын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.	-	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо (өсөлт)	45	Хуулийн хугацаанд шийдвэрлэж тусгай зөвшөөрлийн тоог 2-оор нэмэгдүүлсэн байна.	УУХУСайдын 2018.05.23-ны өдрийн “Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримтын жагсаалт батлах тухай” А/105 дугаар тушаалын дагуу хүсэлтийг хүлээн авч, материалын бүрдлийн шаардлага хангасан “Одээд экспрес” ХХК-д 2021.02.23-ны өдрийн А/23 дугаар тушаал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын бүтцийн нэгж Засвар механикийн заводод УУХУСайдын 2021.03.01-ний өдрийн А/35 дугаар тушаалаар тус тус 3 жилийн хугацаатай тусгай зөвшөөрлийг олгосон.	100%
6.3	Газрын тосны салбарын хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.	-	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	2020 оны 131 тусгай зөвшөөрлийг сунгах болон шинээр олгосон.	2021 онд 131 Өнгөрсөн оны түвшинд хадгалах	<p>-Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн бүх төрлийн шатахуун болон шатдаг хий импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг УУХУСайдын 2018 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-д нийцүүлэн хянаж, түргэн шуурхай шийдвэрлэж байна. 2021 оны 12 дугаар сарын байдлаар шатахууны нийт 292, шатдаг хийн 75 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Үүнээс бүх төрлийн шатахуун импортлох 90, бөөний худалдаа эрхлэх 92, жижиглэнгийн худалдаа эрхлэх 110, шатдаг хийн импортлох 19, шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх 23, АХЦС-аар худалдах 21, баллоноор худалдах 12 тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна. Тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн ч, журмын дагуу материалын бүрдэлт шаардлага хангах боломжгүй нийт 12 ААН-д хүсэлтийг албан бичгээр буцаан хүргүүлсэн.</p> <p>-Петро Матад ХХК-д УУХУСайдын 2021.07.02-ны өдрийн А/186 дугаар тушаалаар №696 тоот газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Газрын тосны тухай хуулийн дагуу 25 жилийн хугацаатайгаар олгосон.</p> <p>-Уламжлалт бус газрын тосны хайгуулын Тавантолгой ХХХIII талбайд нүүрсний давхаргын метан хийтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан Метан газ ресурс ХХК-д хайгуул хийх тусгай зөвшөөрөлийг УУХУСайдын 2021 оны А/47 дугаар тушаалаар 10 жилийн хугацаагаар олгосон.</p> <p>-Уламжлалт бус газрын тосны хайгуулын Гурвантэс ХХХV талбайд нүүрсний давхрагын метан хийтэй холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан Тэлмэн ресурс ХХК-д хайгуул хийх тусгай зөвшөөрөлийг УУХУСайдын 2021 оны А/239 дүгээр тушаалаар 10 жилийн хугацаагаар олгосон.</p> <p>-Газрын тосны хайгуулын Онги V талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар бүтээгдэхүүн</p>	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						хуваах гэрээ байгуулсан Капкорпмонголиа ХХК-д хайгуул хийх тусгай зөвшөөрөлийг УУХҮСайдын 2021 оны А/242 дугаар тушаалаар 2 жилийн хугацаатай Газрын тосны тухай хуулийн 38.3-т заасны дагуу нөхөн олгосон.	
6.4	Сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох	-	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	27	50	УУХҮСайдын 2018.02.13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам”-аар 2021 онд СШ-48, СШ-49, СШ-50, СШ-51, СШ-52, СШ-53, СШ-54, СШ-55, СШ-56, СШ-57, 10 багц талбай зарлаж, холбогдох үнэлгээ дүгнэлтийг гаргасан. 2021 онд нийт 70 талбай олгож Улсын төсөвт 16 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг тогтмол, түргэн шуурхай явуулсны үр дүнд 102 талбайг олгож 29 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2021 оны 11 сард СШ-58, СШ-59 зарлаж оролцох хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийн техникийн болон үнийн саналыг хүлээн авч байна. СШ-48, СШ-49, СШ-50 дугаар сонгон шалгаруулалтаар 13 тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд СШ-50, СШ-51 дугаар сонгон шалгаруулалтаар 12 тусгай зөвшөөрөл олгохоор хуульд заасан үйл ажиллагааг явуулж байна. Өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 43%-иар өссөн байна.	100%
Зорилго 4. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2020 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.							
1.	Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна.						
1.1.	Салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үр ашиг, ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэх талаар холбогдох судалгаа хийж, санал зөвлөмж боловсруулна.	-	Хамрагдсан аж ахуйн нэгж /компани/-ийн тоо	3	9	Салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн санхүү, эдийн засгийн болон үйлдвэр-лэлийн мэдээллийг сар бүр нэгтгэж удирдла-гад танилцуулсан. Мөн үйлдвэрлэлийн болон санхүү, эдийн засгийн мэдээллийг 2015-2020 оны байдлаар нэгтгэн боловсруулсан. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэд хөрөнгө оруулалтын сан /”Эрдэнэс Ассет Менежмент ҮЦК” ХХК/ байгуулж Шивээ-Овоогийн ордыг түшиглэн 200 МВт-ын цахилгаан станц барих, Зэсийн исэлдсэн хүдрийг боловсруулах үйлдвэр барих төслийн судалгаа хийсэн. Уурхайн хаалтын төлөвлөгөөг “Эрдэнэс Сильвер” ХХК-ийн Салхитын холимог металлын ордын жишээн дээр боловсруулж, “Загвар төсөл”-ийн нээлтийг 2021.09.24-ний өдөр зохион байгуулсан. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль боловсруулагдаж байгаатай холбогдуулан салбарын талаар мэдээлэл, судалгааг боловсруулж, УУХҮСайдын 2021.09.13-	90%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						ны өдрийн 01/2212 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	
1.2.	Экспортод гаргаж буй ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох жишиг үнэ зарлаж ажиллана.	-	Зарласан тоо	9 удаа	9 удаа	Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.07.27-ны өдрийн 200/А/177 тоот хамтарсан тушаалаар “Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлэх” үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 342, 465 дугаар тогтоолын дагуу Ажлын хэсгийн бүрэлдэхүүн сар бүрийн 10-ны дотор хуралдаж “Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд” мэдээлж ажилласан.	100%
1.3.	Экспортын голлох ашигт малтмалын зах зээлийн судалгаа хийж, удирдлага мэдээллээр түргэн шуурхай хангаж ажиллана.	-	Судалгааны тоо	3	5	•УУХҮСайдын өгсөн чиглэлийн дагуу алт, нүүрс, зэс, төмөр зэрэг ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн олон улсын зах зээлийн чиг хандлагын талаарх холбогдох судалгааг боловсруулж танилцуулсан. АМГТГ-аас ирүүлсэн мэдээлэл болон гадаад, дотоодын бусад судалгааны тайлан түүний эх сурвалжаас авсан мэдээллийн хүрээнд голлох ашигт малтмалын дэлхийн болон дотоодын зах зээлийн судалгаа, үнэ, нөөцийн талаар мэдээлэл бэлтгэсэн. Газрын ховор элементийн хэрэглээ, зах зээлийн судалгаа хийсэн.. •Бусад улс орны болон дотоодын голлох ашигт малтмалын /алт, зэс, төмрийн хүдэр, нүүрс, жонш/ зах зээлийн чиг хандлага, нөөц, олборлолт, үйлдвэрлэл, үнийн талаарх танилцуулга, тооцоо судалгааг холбогдох эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн боловсруулсан. •Аж үйлдвэрийн салбар (Уул уурхай, олборлох салбар, хүнд аж үйлдвэрийн салбар)-ын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт, хөдөлмөр эрхлэлт, эрдэс бүтээгдэхүүний экспорт, импорт, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн мэдээллийг боловсруулсан.	100%
1.4.	Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг тайлагнана.	-	Судалгааны тайлангийн тоо	3	3	“Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн судалгааны тайланг олон нийтэд ил тод, нээлттэй болгох” хүрээнд “Үүсмэл ордын экологи, эдийн засгийн үнэлгээ, уул техникийн нөхөн сэргээлтийн технологи”, “Газрын ховор элемент агуулсан хүдрүүдийн технологийн судалгаа”-ны тайлангуудыг цахим хэлбэрт шилжүүлж, Шинжлэх ухаан, технологийн сангийн онлайн мэдээллийн сан /data.stf.mn/-д байршуулсан.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						Улсын төсвийн хөрөнгө болон Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа эрдэм шинжил-гээ, судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж МУИС, Үндэсний геологийн алба, Уул уурхайн хүрээлэн, зэрэг байгууллагатай хамтран ажилласан.	
1.5.	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулж ажиллана.	-	Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс холбогдох шийдвэр гарсан байх	4	6	Монголын ОУИТБС-ын Ажлын албаны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд: -УУХҮСайдын 21 аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд орон нутагтай хамтран ажиллах, дэд зөвлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар холбогдох заалтуудыг тусгав; -2021 оны 5 сард Төвийн бүсийн, 8-р сард Баруун бүсийн, 10-р сард Говийн бүсийн, 12-р сард Зүүн бүсийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын чуулганыг зохион байгуулсан; -Ажлын хэсгийн 53, 54, 55, 56, 57 дугаар хуралдааны хөтөлбөр, удирдамжийг хянаж, батлуулах, тогтсон хугацаанд зохион байгуулахад холбогдох арга хэмжээг авсан; -Ажлын албанд харилцааны мэргэжилтэн авч ажлуулснаар Ажлын албыг бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах боломжоор хангав; -Азийн хөгжлийн банкны “Олборлох салбарын засаглалыг сайжруулах” (ТА 9752 MON) төслийн хүрээнд Эрдэс баялгийн салбарын ил, тод байдлын тухай хуулийн төсөл дээр ажиллахаар шалгарсан дотоодын болон гадаадын зөвлөхтэй хамтран хуулийн төслийг эцэслэн боловсруулж холбогдох санал, дүгнэлтийн хамт Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн; -Монголын ОУИТБС-ын Ажлын албаны 2021 оны хагас, бүтэн жилийн тайлан боловсруулсан; -Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэй боловсруулсан Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн iltodgeree.mn цахим санг ОУИТБС-д шилжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмын төслийг Монголын ОУИТБС-ын Ажлын албатай хамтран боловсруулж, УУХҮСайдын 2021.09.14-ний А/246 дугаар тушаалаар батлуулсан; Ажлын албаны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахтай холбоотой бусад асуудлуудыг зохион байгуулж ажилласан.	100%
1.6.	Эрдэс баялгийн салбарын статистикийн мэдээллийг нэгтгэн	-	Мэдээллийн тоо	12	16	УУХҮСайдын 2021.04.05-ны өдрийн А/63 тушаалаар батлагдсан "Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний Геологийн	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	боловсруулах, тайлагнах, удирдлагыг шуурхай мэдээллээр хангана.					албанаас мэдээ, тайлан ирүүлэх журам"-д заасны дагуу 7 хоног бүр тайлан мэдээг авч боловсруулалт хийсэн. Эрдэс баялгийн салбарын 2021 оны гүйцэтгэлийн мэдээллийг сар тус бүрээр гаргаж өмнөх оны мөн үетэй харьцуулан боловсруулж, удирдлагад танилцуулсан. Мөн УУХҮЯ-ны цахим хуудсанд тухай бүр байршуулсан. Газрын тосны бүтээгдэхүүний импорт, нөөц, хоногийн мэдээллийг инфорграфик байдлаар боловсруулж 2021.11.19-ний өдөр Дэд сайдад танилцуулсан. 2021.12.03-ны өдөр эцсийн байдлаар яамны удирдлагууд танилцуулсан.	
1.7.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Ашиглах ордын тоо	0	1	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөц, түүнд шаардлагатай хөрөнгө оруулалт, борлуулалтын орлого, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамж, АМНАТ, төслийн үр ашиг зэрэг техник, эдийн засгийн голлох үзүүлэлтийн талаар мэдээлэл танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан. Оюутолгойн далд уурхайг ашиглалтад оруулах, Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр, Оюутолгойн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, Эрдэнэт үйлдвэрийн технологийн парк, Газрын тос боловсруулах үйлдвэр, Дарханы металлургийн цогцолборыг барьж байгуулах ажлууд хийгдэж байна. 2021 онд уул уурхайн салбарт хийгдсэн ГШХО-ын дүн 1.07 тэрбум ам.долларт хүрсэн нь Монгол Улсад орсон нийт ГШХО-ын 80.3 хувьтай тэнцэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.4 хувиар өссөн. Өнөөгийн байдлаар дотоодын нийт бүтээг-дэхүүний 24 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 69 хувь, экспортын 93 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байна. Тус салбарт 1.3 тэрбум ам.дол-ын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдээд байна.	100%
<p>Зорилго 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2019 онд 47.5 хоног байгааг 2021 онд 30 хоногт хүргэнэ.</p>							
1.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.						
1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2021 оны үйл ажиллагааны болон	-	Арга хэмжээг хуулийн хугацаанд хэрэгжүүлсэн эсэх 0-хэрэгжүүлээгүй 1-хэрэгжүүлсэн	0	1	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг тайлагнасан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2021 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлыг тухай бүр хуулийн хугацаанд зохион байгуулж ажилласан.ТНБД-ын 2021.02.06-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулсан	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлын зохион байгуулна.					салбарын болон яамны стратеги төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулан УУХҮСайдын 2021.04.19-ний А/81 дугаар тушаалаар батлуулсан. УУХҮЯамны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж 2021.01.27-ны өдөр батлуулсан. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д тусгагдсан 7 зорилтын 59 арга хэмжээ, “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-д тусгагдсан 6 зорилтын 32 арга хэмжээ, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-д тусгагдсан 5 зорилтын 14 арга хэмжээний хэрэгжилтийг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн. УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хамаарах 2 зорилт, 3 арга хэмжээний хэрэгжилт, 2 дугаар хавсралтын 15 төсөл, арга хэмжээний биелэлт, 3 дугаар хавсралтын 3 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн биелэлтийн тайланг 2021 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж ХШҮДАГ-т 2021.12.20-ны өдөр хүргүүлсэн. УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хамаарах зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн тайланг 2021 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж ХШҮДАГ-т 2021.12.24-ний өдөр хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тусгагдсан зорилтын чиг үүрэгт хамаарах хэрэгжилтийн тайланг ТНБДаргын 2021.11.12-ны өдрийн 03/2782 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	
1.2	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг	-	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавих 0- шийдвэрлэлтийн хувь нэмэгдээгүй 1-нэмэгдсэн	2020 онд 99%	100%	УУХҮЯ, АМГТГ болон Үндэсний геологийн албанд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал бүрээр гарган 2021.01.07-ны өдрийн 03/44, 2021.04.05-ны өдрийн 03/880, 2021.07.09-ний өдрийн 03/1817, 2021.10.08-ны өдрийн 03/2440 дугаар албан бичгээр тус тус ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2021 оны III улирлын байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 398 өргөдөл, гомдол албан бичгээр ирснээс шийдвэрлэсэн 376, хяналтад байгаа 17, хугацаа хэтэрсэн 5, шийдвэрлэлтийн хувь 94.9%-тай үнэлэгдсэн.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	нэгтгэн холбогдох газарт хүргүүлнэ.					Жилийн эцсийн тайланг 2022.01.10-ны өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлнэ.	
1.3	УУХҮЯамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж тайлагнана.	-	Салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх 0-зохион байгуулсан 1-зохион байгуулаагүй	0	1	УУХҮЯ-ны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар зөвлөлийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталсан. Төлөвлөгөөний дагуу Салбар зөвлөлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Одоогоор салбар зөвлөл нь 9 гишүүнтэй ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар салбар зөвлөл нь: 2020 оны Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, яамны төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан бусад холбогдох материалыг Төрийн албаны зөвлөлд 2021.01.05-ны өдрийн 21/01 дугаар албан бичгээр хугацаанд нь хүргүүлээд байна. -Төрийн албаны зөвлөлөөс жилийн эцсийн байдлаар нийт 30 бичиг ирүүлснээс 11 хариутай албан бичгийн хариуг боловсруулан хугацаанд нь хүргүүлсэн байна. Нийт 3 удаагийн хуралдааныг зохион байгуулж холбогдох шийдвэр гарч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. -Мөн ТАЗ-өөс ирүүлсэн хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг 13 хавсралтаар боловсруулан нэгтгэж хүргүүлсэн. -УУХЗЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын, Ашигт малтмал, газрын тосны газрын 4 хэлтсийн даргын, АМГТГ-ын 6 мэргэжилтний сул орон тоог нөхөх тухай хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж Тусгай шалгалтыг зохин байгуулсан бөгөөд энэ тухай тайланг ТАЗ-д хугацаанд нь хүргүүлсэн. . -Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор УУХҮЯ-ны бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсаны дагуу зарим газар, хэлтсийн даргын Албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл хүсэн Төрийн албаны зөвлөлөөр хэлэлцүүлэн ТАЗ-ийн 167 дугаар тогтоолоор зөвшөөрөл авч, УУХҮЯ-ны ТНБДаргын А/88 дугаар тушаалаар баталсан. УУХҮЯ-ны 36 албан хаагчийн Албан тушаалын тодорхойлолтыг батлуулах зөвшөөрлийг хүсч ТАЗ-д хүргүүлсэн. 2021.12.15-ны өдрийн хуралдаанд танилцуулахаар тогтсон. -Төрийн жинхэнэ албан хаагчтай холбоотой 1, үйлчилгээний албан хаагчтай холбоотой 1 гомдлыг хэлэлцсэн байна.	100%
1.4	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авилгатай тэмцэх үндэсний	-	Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл		АТҮХХАХ Төлөвлөгөө гарч хэрэгжилтийг	УУХҮЯ-ны Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021.01.11-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллаж байна.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, тайлагнана.		ажиллагаа зохион байгуулсан эсэх 0-Үйл ажиллагаа зохион байгуулсан 1-Зохион байгуулаагүй		зохион байгуулж, АТГ-тай хамтран ажилласан байх	Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмын дагуу яамны ажиллагсдын болон харьяа үйлдвэр компаниудын зарим удирдах ажилтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргуулан авч АТГ-т хүргүүлсэн. /2021.03.09, 03/954/ Хугацаа хожимдуулсан албан хаагч байхгүй болно. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 75 албан хаагч ХАСХОМ-ын мэдүүлэг өгсөн байна. Яамны 4 албан хаагчийн ХАСУМ-ын мэдүүлгийг хянуулсан байна. Авлигатай тэмцэх газрын Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Ганхуягтай хамтран 2021 онд Авлигын эсрэг хамтдаа сэдэвт аяны хүрээнд яамны сурталчилгааны самбарыг шинэчлэн яамны вэб сайтанд мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг сургалтад Төрийн захиргааны удирдлагын газрын 2, Хуулийн хэлтсийн 2, бусад газар, хэлтсийн 4 албан хаагчийг сургалтад хамруулаад байна.	
1.5	Салбарын төрийн албан хаагчдийн сургалтын хөтөлбөр боловсруулах, салбарын мэргэжлийн сургалтын байгууллага их, дээд сургууль, салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагууд, гадаад дотоодын төсөл хөтөлбөртэй хамтран мэдлэг, ур чадвар, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна.	Сайдын багцийн холбогдох зардал болон бусад эх үүсвэрээс	Сургалт 0-зохион байгуулсан 1-зохион байгуулаагүй	0	1	УУХҮЯ-ны 2021 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилгодсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч, Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугмаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 128 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2021 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	100%
1.6	Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллана.	Сайдын багцийн холбогдох зардал	Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх	Бичиг хэргийн шийдвэрлэлт 2020 онд 91%	92%	УУХҮЯ-нд 2021.12.10-ны байдлаар нийт 5974 албан бичиг ирсэн ба үүнээс 2501 албан бичигт хариу өгч, 128 албан бичиг хяналтын шатанд ,131 албан бичиг шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн ба бичгийн шийдвэрлэлтийн хувь 90,6% байна. УУХҮЯ-нд ирсэн 5974 албан бичгийг хүлээн авч бүртгэн, удирдлагад танилцуулж, цохолтын дагуу ТЗУГ- 2298 , СХОГ-127, ГБГ-609, ХҮБГ-287, ХШҮДАГ-124, УУБГ-1662, ГТБГ-854, ЗБҮБТН-13 тус тус хуваарилан шилжүүлсэн бөгөөд шийдвэрлэлтийн явцад тогтмол хяналт тавин ажиллаж байна.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						УУХҮЯ-ны мэргэжилтнүүдээс нийт 3043 албан бичиг боловсруулагдаж гарсан ба үүнээс ТЗУГ-1331, СХОГ-84, ГБГ-362, ХҮБГ-232, ХШҮДАГ-112, УУБГ-532, ГТБГ-385, ЗББҮБТөсөл - 5 байна. Эдгээр албан бичгүүдэд дугаар өгөн, дугтуйлан холбогдох газруудад шуудангийн үйлчилгээгээр болон бусад хэлбэрээр хүргүүлсэн болно. Нийт ирсэн 5974 албан бичгийн 68264 хуудас, нийт явуулсан 3043 албан бичгийн 21657 хуудас, 182 өргөдлийн 821 хуудас нийт 90742 хуудас материалыг сканнердаж файл үүсгэн хадгалж, цахим системд бүртгэн оруулсан.	
2	Салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.						
2.1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шүүхэд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөн оролцоно.	-	Төлөөлсөн эсэх 0- төлөөлөөгүй 1-төлөөлсөн	0	1	1.Интерглобал ХХК, 2.Баян петролиум ХХК, 3.Х.Пүрэвдолгорын, 4. “Би ар икс” ХХК, 5.“Монголын геологи уул уурхайн мэргэжлийн институт” ГҮТББ, 6.“Лукрий” ХХК-ийн нэхэмжлэлтэй, УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ, 7.Б.Батхүүгийн нэхэмжлэлтэй Захиргааны хэрэг, 8. УУХҮЯ-ны нэхэмжлэлтэй “Гео магнат ресурс” ХХК-д холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд УУХҮЯ-ыг итгэмжлэлээр төлөөж оролцов. 9.Эн Си Ар ай ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн шүүхэд, 10. ОТ ХХК-ийн нэхэмжлэлтэй олон улсын арбитрын маргаанд болон Их тохойрол тусгай зөвшөөрөлтэй холбоотой WMMining болон WMMining AG компанийн нэхэмжлэлтэй олон улсын арбитрын маргаанд ажлын хэсэгт оролцож байна.Монгол Улсыг төлөөлөх ажлын хэсэгт ажиллаж байна. 11.Шунхлай энерги ХХК-ийн нэхэмжлэлтэй Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох хариу тайлбар, нотлох баримт, төлөөлөгч томилох тухай албан бичгийг боловсруулж, 2021.08.09-ний өдрийн 03/1955, 03/1957 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэв. 12.“Дипирамид” ХХК-ийн нэхэмжлэлтэй, УУХҮЯ-нд холбогдох Захиргааны хэрэгт хариуцагчийн төлөөлөгчөөр оролцож байна. Шүүхийн шийдвэр гараагүй байна. 13.“Сонор трейд” ХХК-ийн нэхэмжлэлтэй, УУХҮЯ-нд холбогдох хэрэгт хариуцагчийн төлөөлөгчөөр оролцож байна. Шүүхийн шийдвэр гараагүй байна. 14.Зэс эрдэнийн хувь ХХК-ийн нэхэмжлэлтэй , УУХҮЯ-нд холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>төлөөлөгчөөр оролцож Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэв.</p> <p>15. Хил хязгааргүй алхам ТББ-аас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан УУХҮСайдын 2018 оны А/28 тоот тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох журам” захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь хүчингүй болгох тухай” шаардлага бүхий нэхэмжлэлд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон 2021.12.06-ны өдөр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцов, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна.</p> <p>15. Монгол Анар трэйд ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн маргаанд оролцож, Засгийн газрыг төлөөлсөн.</p> <p>16. Очот Уул ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн маргаанд Засгийн газрыг төлөөлж байна.</p> <p>17. Эй Эс Ти Эс ХХК-ийн нэхэмжлэлтэй маргаанд Засгийн газрыг төлөөлж байна.</p> <p>18. Оюутолгой ХХК-ийн нэхэмжлэлтэй олон улсын арбитрын маргааны ажлын хэсэгт ажиллаж байна.</p>	
2.2	Салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан төсөлд санал зөвлөмж өгөх, хуульд нийцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	-	Боловсруулж, хүргүүлсэн эсэх 0– Боловсруулж, хүргүүлээгүй 1-боловсруулж, хүргүүлсэн	0	1	<p>1.УУХҮС-ын 2018 оны А/28 дугаар тушаалаар байгуулагдсан Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын шинэчилсэн найруулгын төсөл болох “Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын төслийг Геологийн бодлогын газартай хамтран ажиллаж байна.</p> <p>2.Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд боловсруулагдсантай холбогдуулан АМГТГ, ҮГА болон яамны дотоод нэгжийн хүрээнд саналыг нэгтгэн судлан үзээд Зөрчлийн тухай хуульд оруулах Уул уурхай, геологи, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хамаарах асуудлаар хуульд оруулах саналыг ХЗДХЯ-нд хүргүүлэн ажиллав.</p> <p>3. Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдсэн Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын хавсралтад заасан Төрийн эзэмшлийн хувь хэмжээг хэвээр хадгалах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалттай холбогдуулан тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ШТАББ ТӨҮГ, ГТЛ ТӨҮГ, ГСТ ТӨҮГ-уудыг Төрийн эзэмшлийн хувь хэмжээг хэвээр хадгалах жагсаалтад оруулахаар СЯ болон ЗГХЭГ-т удаа дараа саналыг боловсруулан хүргүүлж ажиллав.</p>	100%
2.3	Салбарын хууль тогтоомж, эрх зүйн	-	Мэдээллийн сан бүрдүүлэх эсэх	0	1	Дээд шатны байгууллагаас УУХҮЯаманд ирүүлсэн УИХ-ын 2 тогтоол, Ерөнхий сайдын 45 захирамж, Засгийн газрын 58	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

	актын мэдээллийн сан бүрдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг лавлагаа мэдээллээр үйлчилнэ.		0-Мэдээллийн сан бүрдүүлж ажиллаагүй 1-Мэдээллийн сан бүрдүүлсэн			тогтоол, Засгийн газрын хуралдааны 81 тэмдэглэл, Ерөнхий сайдын 1 албан даалгавар, Шадар сайдын 1 албан даалгавар, нийт 188 эрх зүйн баримт бичгийг тухай бүр яамны удирдлагуудад танилцуулж, АБЛЕ системийн Олон нийтийн Файлын сан болон Teams-ийн файл хэсэгт баримт бичгийн төрлөөр мэдээллийн сан үүсгэсэн. Мөн Удирдлагаас өгсөн нэмэлт үүрэг даалгаврын заалтыг файл тус бүрийн сэтгэгдэл нэмэх хэсэгт тэмдэглэл нэмэн нийт албан хаагчдад харахад хялбар, ойлгомжтой байдлаар системд байршуулж ажилласан.	
3	УУХҮСайдын багцын төсвийн гүйцэтгэл 2020 онд 95,7 хувь байсныг 2021 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.						
3.1.	Салбарын сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2021 оны батлагдсан төсвийн хуваарь, 2022 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын санал, төсвийн төслийг боловсруулж батлуулна.	Сайдын багцын холбогдох зардал	Шийдвэрлүүлсэн эсэх: 0-тийм 1 - үгүй	0	1	Монгол Улсын 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдлуулан УУХҮСайдын голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл болон экспортын төсөөлөл, бүтээгдэхүүний үнэ, 2021 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын хүлээгдэж буй гүйцэтгэл, 2023-2024 оны төсөөлөл, холбогдох тайлбар, танилцуулгыг боловсруулахад УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа АМГТГ-ыг зөвлөмжөөр хангаж, хянан УУХҮСайдын 2021.04.16-ны өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 01/1010 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, холбогдох тайлбар, үндэслэлээр ханган ажилласан. Улсын Их хурлын 2021.05.13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эцэслэн баталсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмблэх үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу боловсруулан 2021.05.06-ны өдрийн 01/1194 дугаартай албан бичгээр СЯ-нд хуулийн хугацаанд хүргүүлж, Сангийн яамны Хөрөнгө оруулалтын газарт холбогдох тайлбар үндэслэлээр ханган ажилласан. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан УУХҮСайдын багцын 2022 оны төсвийн хязгаарын санал, 2023-2024 оны төсөөллийг боловсруулан	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						“2022 оны хязгаарын санал, 2023-2024 оны төсөөлөл хүргүүлэх тухай” 01/1380 тоот албан бичгээр СЯ-нд хүргүүлж СЯ-ны Төсвийн бодлогын газрын орлогын хэлтэс болон зарлагын хэлтэст шаардлагатай тайлбар мэдээллийг өгч ажилласан. Засгийн газрын 2021.06.30-ны өдрийн 178 тоот тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны хязгаарыг баталсан	
3.2.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж ажиллана.	Батлагдсан төсөв-40,118,265,400.0 Хөрөнгө оруулалт-29,157,100,000.0	Хуулийн хугацаанд зохион байгуулж ил тод байдлыг хангах 0-үгүй 1-тийм	0	1	- Захиалагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулан, УУХҮСайдын 2020.11.25-ны өдрийн А/300 дугаар тушаалаар батлуулсан. Холбогдох хууль, журмын өөрчлөлт, төсөвт хийгдсэн тодотгол зэрэгтэй холбоотойгоор 2021 оны А/18, А/78, А/79, А/95, А/144, А/234 дүгээр тушаалуудаар зохих өөрчлөлтүүдийг оруулан батлуулсан. Уул уурхайн салбарын төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянах, батлуулах ажлын хүрээнд УУХҮСайдын А/19 дүгээр тушаалаар “Эрчис ойл” ХХК, А/21 дүгээр тушаалаар “Эрдэнэс Тавантолгой” ХК, А/31 дүгээр тушаалаар “Зүүнбаян төмөр зам” ХХК, А/56 дугаар тушаалаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төлөвлөгөөг хянан батлуулсан. Дээрх компаниудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” ЗГ-ын 124 дүгээр тогтоолуудтай нийцүүлэн хянаж, автомашин, тавилга эд хогшил, дүрэмт хувцас худалдан авах зардлуудыг хянан, шаардлагатай худалдан авалтуудыг хасаж, зохих нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр оруулан батлуулж ажилласан. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор нийт 27 тушаалын төсөл бэлтгэн, хянуулж, батлуулсан. Үүнд: Сайдын тушаал 20, Төрийн нарийн бичгийн даргын тушаал 7. Захиалагчийн болон УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан даруйд нь болон өөрчлөлт орсон тухай бүр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -д оруулан, Сангийн яамаар хянуулан батлуулж ажилласан. 2021 онд нийт 31 удаагийн өөрчлөлтийн хүсэлтийг гарган шийдвэрлүүлж ажилласан. - Худалдан авах ажиллагааг хариуцсан мэргэжилтэнд зөвлөмж өгч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 2021.01.14-ний өдрийн 03/100 тоот албан бичгээр, УУХУСайдын эрхлэх асуудлын хүрээний аж ахуйн нэгж байгууллагуудын 2020 онд дотоодын үйлдвэрүүдээс худалдан авсан нийт 408 нэр төрлийн, 51.4 тэрбум төгрөгийн бараа, бүтээгдэхүүний тайланг нэгтгэн боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2021.01.25-ны 01/205 тоот албан бичгээр хүргүүлж, дотоод худалдан авалтын нэгдсэн тайланд нэгтгүүлэх чиглэлийг өгч мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан.	
3.3	Салбарын сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын төсвийн багцын зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хуваарийн дагуу санхүүжүүлж гүйлгээг хянан баталгаажуулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох газарт хүргүүлнэ.	Улсын төсөв-40,118,265,400.0	Бэлтгэл хангагдсан эсэх 0-хангагдаагүй 1-хангагдсан	0	1	УУХУСайдын /ТЭЗ/-ын батлагдсан төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын хуваарийн саналыг боловсруулж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхэд харьяа байгууллагын холбогдох албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдамжаар хангаж, төсвийн хуваарийн саналыг нэгтгэн боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. УУХУСайдын 2021 оны төсвийн урсгал зардал болон хөрөнгө оруулалтын санхүүжилт, орлогын төлөвлөгөөний хуваарь Сангийн сайдын 2020.12.31-ны өдрийн 248 тоот тушаалаар батлагдаж 2021.01.21-ний өдрийн 4-1/245 тоот албан бичгээр ирсэнийг, харьяа байгууллагуудад хүргүүлж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан. 2021 оны зарлагын хуваарийг Сангийн яамнаас батлахдаа зарим зардлуудыг 12 сард санхүүжүүлэхээр баталсан нь үйл ажиллагааны дагуу төлөвлөгдсөн ажлыг санхүүжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгосон. Үүнтэй холбоотойгоор зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай зардлын хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг СЯ-нд тухай бүрт хүргүүлэн санхүүжилтийг шийдвэрлэж ажилласан. 2021 оны төсвийн жилд УУХУЯ-ны урсгал зардлаас 598.4 сая төгрөг, АМГТГ-ын урсгал зардлаас 51.1 сая төгрөг, Үндэсний геологийн албаны урсгал зардлаас 268.5 сая төгрөг, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албаны зардлаас 150.1 сая төг, Геологи, хайгуул, судалгааны ажлын зардлаас 26.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг батлагдсан хуваараас наашлуулан шаардлагатай үед нь эрхийг нээлгэж, санхүүжилтийн хуваарьт холбогдох өөрчлөлтийг оруулж санхүүжилтийг тухай бүрд олгосон. - Дотоод томилолт, эрдэм шинжилгээ судалгааны ажил, мэдээлэл сурталчилгааны зардлын хуваарьт өөрчлөлт оруулах өөрчлөлт оруулах хүсэлтийг УУХУСайдын	100%

					<p>2021.05.18-ны өдрийн 01/1297 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж холбогдох өөрчлөлтийг оруулж 6 дугаар сарын санхүүжилтийн хуваарьт дотоод томилолтын зардалд 13.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээлгүүлээд байна.</p> <p>- 2021.02.17-ны Засгийн газрын 43 дугаар тогтоолоор болон 2021.04.08-ны Засгийн газрын 93 дугаар тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны батлагдсан төсөвт зохицуулалтыг хийн 362.6 сая төгрөгийг хэмнэлт гаргасан. Улсын Их хурлын 2021.07.07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан 2021 оны төсвийн тодотголоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсөв 39.8 тэрбум төгрөг болж батлагдсан. Харин яамны 2021 оны батлагдсан төсөв 5,035.4 сая төгрөг байснаас 150.0 сая төгрөгийг Үндэсний геологийн албанд зохицуулалт хийж, 282.0 сая төгрөг тодотголоор хэмнэлтээр бууруулж 4,603.4 сая төгрөг болж батлагдсан. Төсөвт тодотгол хийгдэж хуваарьт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2021 онд УУХҮСайдын багцын төсөвт нийт 4 удаагийн хүсэлтээр 585.9 сая төгрөгийн зохицуулалтыг хийлгэсэн байна. Үүнд: УУХҮЯ-ны урсгал зардалд 269.4 сая төгрөг, АМГТГ-ын урсгал зардалд 25.2 сая төгрөг, Үндэсний геологийн албаны урсгал зардалд 291.3 сая төгрөгийн зохицуулалтыг тус тус хийлгэж шаардлагатай санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж ажилласан.</p> <p>УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Төрийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад мэргэжил арга, зүйн зөвлөгөөгөөр хангаж шаардлагатай зааварчилгааг цаг тухай бүрт өгч хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.</p> <p>Төлбөр тооцоог төрийн сангаар гүйцэтгэхдээ 2021 оны батлагдсан зардлын хүрээнд Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах заавар, журмын дагуу төлбөр тооцоог хийж байгаа эсэхэд сар бүр хяналт тавьж төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийг зөвлөмжөөр хангаж ажилласан. УУХҮЯ-ны төрийн сангийн нэгжээр УУХҮЯ, АМГТГ, ҮГА төлбөр тооцоогоо хийж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын нийт 17 данс төрийн санд бүртгэлтэй байна. Мөн УУХҮЯ-ны хөврүүлэлтийн 100900018701 дансаар яам болон харъяа байгууллагуудын гадаад төлбөр тооцооны хөврүүлэлтийг хийж сургалтын төлбөр болон гишүүнчлэлийн хураамжийн төлбөрийг шилжүүлж гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай хийж гүйцэтгээд байна.</p>
--	--	--	--	--	---

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						- УУХҮСайдын багцын 2020 оны 12 сар, 2021 оны эхний 11 сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн боловсруулах, сар бүр хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлэхэд зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажилласан.	
3.4	УУХҮСайдын багцын хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологийн судалгааны ажлын санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэх, Санхүүгийн тайланг холбогдох газарт хүргүүлнэ.	Геологи-27,430,000,000.0 Хөрөнгө оруулалт-1,727,100,000.0	Тайланг хугацаанд нь гаргаж, дүгнүүлсэн эсэх 0 - зөрчилтэй, 1 - зөрчилгүй	0	1	УУХҮСайдын багцын хөрөнгө оруулалтын ажлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган удирдлагад танилцуулж баталгаажуулан УУХҮСайдын нэгтгэсэн тайланд нэгтгэхэд мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан. УУХҮСайдын 2021.04.13-ны өдрийн тушаалаар 2021 онд улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан. Уг хөрөнгө оруулалтаар өнгөрсөн оны үргэлжилсэн 3 гэрээ, шинээр байгуулагдсан 2 гэрээ байгуулагдсан. 2021.12.12-ны байдлаар гэрээний дагуу хүлээлгэж өгсөн ажлын нийт 1.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг олгоод байна. 2021 оны Төсвийн тухай хуулиар геологи, хайгуул, судалгааны ажилд 27.4 тэрбум төгрөг батлагдсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулж, удирдлагад танилцуулан, Сангийн яаманд хүргүүлж, санхүүжилтийн хуваарьт тухай бүр холбогдох өөрчлөлтийг оруулж 2021.12.10-ны байдлаар нийт 20.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгоод байна. Геологийн ажлын гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг нээж хуваарьт холбогдох өөрчлөлт оруулахад мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. Улсын төсвөөр хийгдэх геологи судалгааны ажлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргахад удирдлага, зөвлөмжөөр хангаж, удирдлагад танилцуулан баталгаажуулж, УУХҮСайдын нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн. УУХҮСайдын харьяа байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Засгийн газрын нэгдсэн тайлангийн цахим программд шивж оруулан тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулан баталгаажуулсан. УУХҮСайдаас 2020 оны жилийн эцсийн тайланд аудит хийлгүүлэхэр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн албан тоотын дагуу аудит хийхэд шаардлагатай тайлбар, үндэслэлээр ханган, дүгнэлт гаргуулсан. Аудитлагдсан тайланг Засгийн газрын нэгдсэн тайланд нэгтгүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөмж, тайлбар, үндэслэлээр ханган ажилласан.	100%
4	Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.						

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

4.1	Салбарын гадаад харилцааг өргөжүүлэх чиглэлээр бусад улс, оронтой хоёр болон олон талт хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн төсөл, санамж бичгийн төслийг боловсруулах, орчуулах, гэрээ үзэглэх ёслолыг зохион байгуулах, бүртгүүлнэ.	0	Төсөл боловсуулсан эсэх 0-үгүй 1-тийм	0	1	<p>“Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Байгалийн нөөц, баялгийн яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийн төсөлд хятадын талаас ирүүлсэн саналыг тусган 2021.10.07-ны өдөр хүргүүлсэн бөгөөд санамж бичгийг хоёр тал эцэслэн тохироод байна. Санамж бичигт гарын үсэг зурах ёслолыг цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Улаанбаатар дахь БНХАУ-ын ЭСЯ-д эсвэл Бээжин дэх Монгол Улсын ЭСЯ-д гарын үсэг зурах эрх олгон зохион байгуулахаар төлөвлөж байна. Монгол Улсын УУХҮЯ болон БНСУ-ын Геологи, эрдэс баялгийн хүрээлэн хооронд хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын Санамж бичгийн төсөлд холбогдох саналыг тусган боловсруулж 2021.10.28-ны өдөр БНСУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-нд цахим шуудангаар хүргүүлэв. Хариуг хүлээж байна.</p> <p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд санал авах тухай УУХҮСайдын 2021.10.07-ны өдрийн 01/2416 дугаартай албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. ГХЯ-аас 2021.10.28-ны өдрийн 09/4798 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг тусган дахин хүргүүлсэн.</p> <p>УУХҮСайд Г.Ёндон Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэд дарга Малгожата Гошевска тэргүүтэй төлөөлөгчдийг 2021.11.23-ны өдөр УУХҮЯ-д хүлээн авч уулзсан албан уулзалтыг зохион байгуулав. Польшийн талаас БНПУ-ын Сеймийн дэд дарга Малгожата Гошевска, Уур амьсгал, байгаль орчны дэд сайд Пиотр Джиаджио, БНПУ-ын Элчин сайд Крзыштоф Бойко болон Уур амьсгал, байгаль орчны яам, Улсын Геологийн алба, КГХМ компаний төлөөлөгчид оролцсон. Уулзалтын тэмдэглэлийн хувийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн. Айлчлалын үеэр КГХМ компаний төлөөлөгчид үйлчлэх унаагаар хангаж, зочдын VIP танхимын зөвшөөрөл, Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцахтай холбогдуулан 2021.11.10-ны өдрийн 02/2735, 2021.11.17-ны өдрийн 04/2824, 2021.11.12-ны өдрийн 04/2779 дугаартай албан бичгийг боловсруулан хүргүүлж, Засгийн газрын авто баазтай Автомашингаар үйлчлүүлэх тухай гэрээг байгуулсан.</p> <p>Монгол Улс, Бүгд Найрамдах Польш улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын геологийн салбарт хамтран ажиллах тухай УУХҮЯ-ны харьяа Үндэсний</p>	100%
-----	--	---	---	---	---	--	------

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						геологийн алба, Польш улсын Геологийн хүрээлэн-Үндэсний судалгааны хүрээлэнгийн хооронд байгуулах харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийн төслийг Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан санамж бичгийг үйлдэх зөвшөөрлийг авч 2021.11.24-ний өдөр Санамж бичгийг Улаанбаатар хотноо үйлдсэн. Санамж бичиг байгуулах удирдамжийг 2021.07.09-ний өдөр ТНБДаргаар батлуулж Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын 8.2-т заасны дагуу холбогдох газарт бүртгүүлсэн болно.	
4.2	Яамны удирдлага, албан хаагчдыг 2 орны Засгийн газар хоорондын болон олон улсын хурал чуулга, уулзалтад оролцуулах, гадаад айлчлал, арга хэмжээг зохион байгуулна..	219,000,000 төг	Зохион байгуулж оролцсон эсэх 0-Оролцоогүй 1-Оролцсон	0	1	1. УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал БНЭУ-ын Газрын тос, байгалийн хийн яамны дэд сайд Тарун Капуртай 2021.02.02-ны өдөр цахимаар уулзсан. Уулзалтад УУХҮДэд сайд О.Батнайрамдал, ГТБГ-ын дарга Н.Анхбаяр, ТЗУГ-ын ГХАХ-ийн дарга Ч.Анун, ГХЯ-ны Ази, номхон далайн орнуудын газрын зөвлөх Э.Есүхэй, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, Энэтхэгийн талаас Гадаад хэргийн яамны Зүүн азийн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Навиншиваско, ГХЯ-ны зөвлөх Панкажи, Монгол Улсад суугаа Элчин сайд М.П Сингх, “Engineers India Limited” компанийн удирдлагууд оролцсон. Уулзалтын мөрөөр түүхий тос дамжуулах төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах олон улсын тендер зарлахтай холбогдуулан 10 орны нэр бүхий ЭСЯ руу албан бичиг хүргүүлсэн ба БНЭУ-д нүүрс нийлүүлэх асуудлаар Монгол, Энэтхэгийн хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг 2021.03.25-ны өдөр цахимаар зохион байгуулав. 2. Канадын Хайгуулч, олборлогчдын холбооноос 2021.03.15-ны өдөр цахимаар зохион байгуулсан Олон улсын уул уурхайн сайд нарын дээд хэмжээний чуулга уулзалт (PDAC-2021)-д УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал оролцсон. Канад, Еврази, Оросын бизнесийн холбооноос 2021.01.18-ны өдөр цахимаар зохион байгуулсан Х дахь удаагийн чуулга уулзалтад ГТБГ-ын дарга Б.Бат оролцсон. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын 16-р хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2021.05.19-ний өдрийн 01/1307 дугаар албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. Ажлын хэсгийн хуралдааны бэлтгэлийн хүрээнд 2021.05.11-д цахимаар зохион байгуулагдсан Монголын талын ажлын хэсгийн уулзалтад ГТБГ-ын ГТБХГХ-ийн шинжээч	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						Д.Даваабаяр, УУБГ-ын Техник технологийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Г.Намчинсүрэн нарыг оролцуулав. УИХ-ын дарга Г.Занданшатар 2021.11.30-2021.12.05-ны өдрүүдэд БНЭУ-д хийх албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд УУХҮСайд Г.Ёндон оролцох бэлтгэл ажлыг хангав. Бэлтгэл ажлын хүрээнд УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.11.25-ны өдрийн А/94 дугаартай тушаалаар нислэгийн тийз, зочид буудлын захиалгыг баталгаажуулсан. Мөн Дели дэх Монгол Улсын ЭСЯ-тай холбогдон УУХҮСайд Г.Ёндон газрын тосны үйлдвэрийн асуудлаар БНЭУ-ын EIL, Tata Steel, ONGC компаниудтай хийх албан уулзалтуудыг баталгаажуулан хөтөлбөр боловсруулж, ярианы сэдвийг бэлтгэв.	
4.3	Яамны удирдлагуудыг гадаад орны дипломат төлөөлөгчийн газар (ЭСЯ, Олон улсын байгууллага, бусад байгууллага)-ын тэргүүнүүд, гадаад орны төлөөлөгчидтэй хийх уулзалтыг зохион байгуулах, аман болон бичгийн орчуулга хийнэ.	0	Зохион байгуулсан эсэх 0-үгүй 1-тийм	0	1	1. 2021.02.09: УУХҮСайд Г.Ёндон Бүгд Найрамдах Франц Улсын "Орано" группийн Уул уурхайн бизнес нэгжийн Ерөнхийлөгч Н.Маестай хийсэн уулзалт 2. 2021.03.23: УУХҮСайд Г.Ёндон Оюу Толгой ХХК-ийн гүйцэтгэх захирал Армандо Торрестой хийсэн цахим уулзалт 3. 2021.03.04: УУХҮСайд Г.Ёндон "Тийс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал Лион Кутцертэй хийсэн цахим уулзалт 4. 2021.03.17: УУХҮСайд Г.Ёндон БНХАУ-ын Элчин сайд Цай Вэньруйтэй цаг үеийн асуудлаар утсаар ярилцах уулзалт 5. 2021.04.22: УУХҮСайд, УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал нар KOURA компаний удирдлагуудтай хийсэн цахим уулзалт 6. 2021.04.15: УУХҮСайд Г.Ёндон Монгол, Германы хамтарсан технологийн их сургуулийн удирдлагуудтай хийсэн цахим уулзалт 7. 2021.08.13: УУХҮСайд Г.Ёндон "Бадрах Энержи" ХХК-ийн гүйцэтгэх захирал Марк Меллеардтай хийсэн уулзалт 8. 2021.10.21: УУХҮСайд БНКаУ-ын Элчин сайд Ж.Адилбаев, Сымбат инженеринг компаний захирал Меирам Тлеужан нартай хийсэн уулзалт 9. 2021.10.19: УУХҮСайд Г.Ёндон Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Обрущанский Борбала Аннатай хийсэн уулзалт 10. 2021.10.21: УУХҮСайд Г.Ёндон БНКаУ-ын Элчин сайд Ж.Адилбаев, Сымбат инженеринг компаний захирал Меирам Тлеужан нартай хийсэн уулзалт 11. 2021.11.09: УУХҮСайд Г.Ёндон БНЭУ-ын Элчин сайд М.П.Сингхтэй хийсэн уулзалт 12. 2021.11.09: УУХҮСайд Г.Ёндон Рио Тинто компаний гүний уурхайн асуудал хариуцсан Грегг С-тэй хийсэн уулзалт	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						<p>13. 2021.01.12: УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал АНУ-ын UDAID-ийн Азийн сангийн төлөөлөлтэй хийсэн цахим уулзалт</p> <p>14. 2021.02.26: УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал Амчам-ын гишүүдтэй хийсэн цахим уулзалт</p> <p>15. 2021.03.18: УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Төв ази хариуцсан бүсийн тэргүүлэх эдийн засагч Эрик Ливнитэй хийсэн цахим уулзалт</p> <p>16. 2021.05.19: УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал АМЕП хөтөлбөрийн удирдагч Кирстен Ливермортой хийсэн цахим уулзалт</p> <p>17. 2021.08.13: УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдал Газрын тос боловсруулах үйлдвэр болон БНЭУ-ын холбогдох төлөөлөгчтэй хийсэн уулзалт</p> <p>18. 2021.11.12: УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдалаар ахлуулсан “Хариуцлагатай, ил тод уурхайг хөгжүүлэх орон тооны бус зөвлөл”-ийн ээлжит хурал</p> <p>19. 2021.11.03: УУХҮЯ-ны ТНБДарга Г.Нандинжаргал Польш Улсын Элчин сайд Кшиштоф Бойкотой хийсэн уулзалтыг зохион байгуулав.</p>	
<p>Зорилго 6. Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангаж хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн ЗГХЭГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээгээр 2018 оны зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү 3.4 байсныг 2021 онд 1.5 болгон бууруулна.</p>							
<p>6.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийнэ.</p>							
6.1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.	-	ЗГ-ын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу тухай бүр хүргүүлсэн байна. 0-Боловсруулж, хүргүүлээгүй 1-Боловсруулж, хүргүүлсэн	0	1	<p>1. УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтэд (151 шийдвэрийн 247 зүйл, заалт) хяналт-шинжилгээ, үнэлгээг (90.3%) хийж, тайланг УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2020.01.14-ний өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2020.01.15-ны өдрийн 01/121 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Мөн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд (153 шийдвэрийн 263 зүйл, заалт) хяналт-шинжилгээ, үнэлгээг (84.3%) хийж, Удирдлагын зөвлөлийн 2021.06.30-ны өдрийн 09 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2020.07.01-ний өдрийн 01/1697 дугаар албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрт</p>	100%

					<p>хамаарах Засгийн газрын шийдвэрүүдийн 2021 оны I улирлын (нийт 18 шийдвэрийн 34 зүйл, заалт) биелэлтэд 2021.04.15-ны өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээг (83.03%), 2021 оны III улирлын (нийт 40 шийдвэрийн 68 зүйл, заалт) биелэлтэд 2021.09.14-ний өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээг (85.4%) тус тус хийсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайланг тухай бүр байршуулж баталгаажуулсан.</p> <p>2. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтэд (17 зорилтын 72 арга хэмжээ) хяналт-шинжилгээ, үнэлгээг (50.3%) хийж, тайланг УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021.01.27-ны өдрийн 04 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.01.27-ны өдрийн 01/234 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2021 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг (51,7%) хийж, тайланг 2021.07.01-ний өдрийн “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 01/1698 дугаар албан бичгээр, мөн 2021.09.01-ний өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг (64.7%) хийж “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.09.27-ны өдрийн 01/2306 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т тус тус хүргүүлсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайланг байршуулж баталгаажуулсан.</p> <p>3. “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (70.0 хувь) хийж, тайланг УУХҮЯамны Удирдлагын зөвлөлийн 2021.01.20-ны өдрийн 03 дугаар хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.01.21-ний өдрийн 01/189 дүгээр албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэв.</p> <p>4. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д тусгагдсан 7 зорилтын 59 арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэл, хүрсэн түвшинг үнэлж (78.6 хувь), тайланг УУХҮЯамны Удирдлагын зөвлөлийн 2021.03.30-ны өдрийн 06 дугаар хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.03.31-ний өдрийн 01/775 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайланг байршуулж баталгаажуулав.</p> <p>5. “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-д тусгагдсан 6 зорилтын 32 арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэл, хүрсэн</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>түвшинг үнэлж (86.8 хувь), тайланг УУХҮЯамны Удирдлагын зөвлөлийн 2021.03.30-ны өдрийн 06 дугаар хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.03.31-ний өдрийн 01/775 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайланг байршуулж баталгаажуулсан.</p> <p>6. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-д тусгагдсан 5 зорилтын 14 арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэл, хүрсэн түвшинг үнэлж (83.3 хувь), тайланг УУХҮЯамны Удирдлагын зөвлөлийн 2021.03.30-ны өдрийн 06 дугаар хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.03.31-ний өдрийн 01/775 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайланг байршуулж баталгаажуулсан.</p> <p>7. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө /Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл/-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (73.5 хувь) хийж, тайланг УУХҮЯамны Удирдлагын зөвлөлийн 2021.01.20-ны өдрийн 03 дугаар хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.01.20-ны өдрийн 01/161 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>8. Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-2” үндэсний хөтөлбөр (80.0 хувь), 2019 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний геомэдээллийн сан” үндэсний хөтөлбөр (66.2 хувь), 2019 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр” (70.0 хувь)-т тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг УУХҮЯамны Удирдлагын зөвлөлийн 2021.03.30-ны өдрийн 06 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.03.31-ний өдрийн 01/776 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулж баталгаажуулсан.</p> <p>9. УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн (4) хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (79.2 хувь) хийж, “Гадаад хамтын ажиллагааны төслүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2021.03.01-ний өдрийн 01/455 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	
--	--	--	--	--	---	--

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						10. УУХҮЯамны 2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ (84.7 хувь) хийж, тайланг УУХҮЯамны Удирдлагын зөвлөлийн 2021.03.29-ний өдрийн 05 дугаар хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд 2021.03.31-ний өдрийн 01/772 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайланг байршуулж баталгаажуулав.	
6.2.	Санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана.						
6.2.1.	Яамны дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд холбогдох чиглэлийн дотоод аудит хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан яамны удирдлагад танилцуулна.	-	Төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийсэн эсэх 0-үгүй 1-тийм	0	1	УУХҮЯамны ХШҮДАГ-ын 2021 оны дотоод аудитын төлөвлөгөөг УУХҮСайдын 2021.02.16-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу УУХҮЯамны архив, албан бичиг хэрэг бүртгэл болон уурхай, уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах комиссын үйл ажиллагаанд хийх дотоод аудитыг гүйцэтгэв. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багц, УУХҮЯ-ны шилэн данс, болон дотоод аудитын 2020 оны жилийн эцэс, 2021 оны 1, 2, 3 дугаар улирлын тайланг Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавьж ажилласан.	100%
Зорилго 7. Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангаж e-mongolia төрийн нэгдсэн үйлчилгээнд 5 үйлчилгээг нэгтгэнэ.							
7.1.	“Эрдэс баялгийн цахим засаглал” үндэсний арга хэмжээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд батлаж хэрэгжилтийг ханган ажиллана.						
7.1.1	“Эрдэс баялгийн цахим засаглал” үндэсний арга хэмжээний төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хөтөлбөр батлагдсан эсэх 0-батлагдаагүй 1-батлагдсан	0	1	“Эрдэс баялгийн цахим засаглал” бүрдүүлэх хууль, эрх зүйн орчны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын сайн туршлагад суурилсан Үндэсний арга хэмжээ (хөтөлбөр)-ний төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан суурь судалгаа хийх зөвлөх компанийг сонгон шалгаруулахаар ТНБД-ын 2021 оны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо байгуулан ажлыг хууль журмын дагуу гүйцэтгэсэн боловч 3 удаагийн тендер шалгаруулалтад аж ахуйн нэгжүүд оролцоогүй тул тухайн ажлыг 2022 онд хийхээр хойшлуулсан. “Эрдэс баялаг – Цахим шилжилт” хэлэлцүүлгийг 100% цахимаар хийсэн. Хэлэлцүүлэг 500 орчим оролцогчдыг хамарсан ба УУХҮЯ-ны зүгээс Эрдэс баялгийн цахим	70%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

						засаглалыг бүрдүүлэх нөхцөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулсан.	
7.1.2	УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээнд ашиглагдаж байгаа мэдээллийн сангийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, сайжруулалт хийх арга замуудыг тодорхойлон эдгээр системүүдийг уялдуулсан нэгдсэн систем бүрдүүлнэ.	150 сая.төг	Дүн шинжилгээ хийж нэгдсэн системийн талаарх дүгнэлт гарсан эсэх 0-гараагүй 1-гарсан	0	1	УУХҮЯамны ТНБД-ын 2021.01.18-ны өдрийн А/05 дугаар тушаалаар “Салбарын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, уялдаа холбоог сайжруулах, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг төлөвшүүлэх зорилгоор яам болон агентлагуудын ашиглаж буй мэдээллийн сангуудын хэрэглээнд дүн шинжилгээ хийх, уялдаа холбоог хангах, нэгдсэн нэг системд нэгтгэх чиглэлээр санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг яам, агентлагуудад ашиглагдаж буй мэдээллийн сан, техник хангамж, программ хангамжийн судалгаанууд хэрэглээнд дүн шинжилгээ хийн, уялдаа холбоог хангах, нэгдсэн нэг системд нэгтгэх чиглэлээр санал дүгнэлт боловсруулсан. Нэгдсэн систем бүрдүүлэх чиглэлээр Австрали-Монголын эрдэс баялгийн хамтын ажиллагааны төсөл (АМЕР)-тэй хамтран ажиллаж байна.	100%
7.2.	УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.						
7.2.1	УУХҮЯ-аас олгодог тусгай зөвшөөрлийн бүртгэлийн систем хөгжүүлнэ.		Тусгай зөвшөөрөл цахимаар олгох ажлын гүйцэтгэлийн хувь	80%	100%	УУХҮЯ-наас ААН-д олгодог тусгай зөвшөөрлийн бүртгэлийн систем хөгжүүлэлтийг хийж дууссан. Системийг нэвтрүүлэх, шаардлагатай сургалтыг зохион байгуулах ажлыг хийж байна. Мөн цахим систем ашиглах журам боловсруулж байна.	100%
7.2.2	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны цахим систем нэвтрүүлнэ.	43.875.000	Цахим систем нэвтрүүлэх ажлын гүйцэтгэлийн хувь	80%	100%	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны цахим системийг хөгжүүлэлтийг "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ-тай хамтран хийж дуусгасан. Системийн хэрэглэгчдийн сургалтыг зохион байгуулж, гарын авлага бэлтгэн туршилт хийн нэвтрүүлэх ажлыг хийж байна.	100%
7.2.3	УУХҮЯамны удирдлагын мэдээллийн цахим сан, ухаалаг хэрэглээ /mobile application/ систем нэвтрүүлнэ.	16.000.000	Цахим систем нэвтрүүлсэн эсэх 0-үгүй 1-тийм	0	1	УУХҮЯ-ны удирдлагын мэдээллийн цахим систем нэвтрүүлэх /mobial application/-ээр “Ханхөлгөн” ХХК-тай хамтран ажиллаж, хөгжүүлэлтийн ажил хийгдэж дууссан. Системийн туршилтыг зохион байгуулж УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны албан хэрэгцээнд ашиглах бэлтгэл ажлыг хангаад байна.	100%
7.2.4	УУХҮЯамны албан хэрэглээнд майкрософт нэвтрүүлэх 365	3.000.000	365 систем нэвтрүүлэх ажлын гүйцэтгэлийн хувь	90%	100%	“Майкрософт Оффис 365”-ыг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж худалдан авсан. Программын хөгжүүлэлтийг хийж УУХҮЯ-ны албан хэрэгцээнд нэвтрүүлсэн.	100%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны Гүйцэтгэлийн тайлан

7.2.5	УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээг E-Mongolia платформд нэгтгэнэ.		E-Mongolia үйлчилгээнд нэгтгэсэн эсэх 0-үгүй 1-тийм	0	1	Засгийн газрын 2020 оны 90 дүгээр тогтоолын хүрээнд төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж “e-Mongolia” цонхонд нэгтгэх салбарын 18 ажлуудын санал боловсруулж ХХМТГ-т 2020.12.24-ний өдрийн 03/3205 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын хүрээнд “E-Mongolia” платформд нэгтгэх үйлчилгээний дэлгэрэнгүй судалгааг ХХМТГ-аас ирүүлсэн загварын дагуу боловсруулж 2021.01.26-ны өдрийн 10/216 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2021 оны 5 дугаар сард тусгай зөвшөөрлийн бүртгэлтэй танилцах, лавлагаа авах үйлчилгээг E-Mongolia-д холбуулсан.	70%
-------	---	--	---	---	---	--	-----

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА

Г.БАТБАЯР

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.НАРАН-ЭРДЭНЭ